Монгол Улсын
Засгийн Газар

САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ЯАМ
ЯДУУРЛЫН СУДАЛГААНЫ НЭГЖ

Mongolia

НҮБ-ын ХХ/ШОУХА "Ядуурлын Судалгаа, Хөдөлмөр Эрхлэлтийг Дэмжих", МОН/01/Ю01 төсөл

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

"МАЛЧДЫН ХӨРӨНГИЙГ ЭДИЙН ЗАСГИЙН ЭРГЭЛТЭНД ОРУУЛАХ АРГА ЗАМЫН ҮНЭЛГЭЭ"

Улаанбаатар хот
2004 он

Санхүү Эдийн Засгийн Яам
Ядуурлын Судалгааны Нэгж

НҮБ-ын ХХ/ШОУХА "Ядуурлын Судалгаа, Хөдөлмөр Эрхлэлтийг Дэмжих", МОН/01/Ю01 төсөл

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

"МАЛЖУУЛАЛТААР МАЛЧИН ӨРХҮҮДИЙН ОРЛОГЫГ НЭМЭГДҮҮЛЖ, АМЬЖИРГААГ БАТАЛГААЖУУЛАХ СТРАТЕГИЙН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ НЬ"

Тайлан бичсэн: Л.Наранхүү
Д.Шомбодон
Б.Жандагсүрэн
С.Амгаа
Ц.Алтанбат

Зөвлөх: Ричард Маршал, ЯСН
Ш. Мөнхцэрэн, ЯСН

УЛААНБААТАР, 2003

ӨМНӨХ ҮГ

Монгол улсын Засгийн газар болон НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, Шведийн Засгийн газар/ШОУХАН-ээс хамтран хэрэгжүүлж буй "Ядуурлыг бууруулах хөдөлмөр эрхлэлтийг дэмжих" МОН/01/Ю01 төсөл 2001 оны 7 дугаар сараас хэрэгжиж байна. Энэхүү төслийн хүрээнд Санхүү, эдийн засгийн яамны дэргэд Ядуурлын судалгааны нэгжийг байгуулан ажиллаж байна.

Төслийн гол зорилгын нэг нь Ядуурлыг бууруулах бодлого, үйл ажиллагааг сайжруулан хэвшүүлэхэд чухал хэрэгсэл болох ядуурлын судалгаа хийх, хяналт тавих, дүн шинжилгээ хийж, бодлого боловсруулах, үндэсний чадавхийг бэхжүүлэх явдал бөгөөд Ядуурлын судалгааны нэгжээс дээрх зорилтын хүрээнд хэд хэдэн судалгааг 2003 онд гэрээгээр хийлгэснээс энэ удаа "Малжуулалтаар малчин өрхийн орлогыг нэмэгдүүлж, амьжиргааг баталгаажуулах стратегийн үр дүнг үнэлэх нь" судалгааны тайланг Та бүхэнд толилуулж байна.

Сүүлийн жилүүдэд байгаль, цаг уурын нөлөөллөөс болж ядуурал, ялангуяа малчид ядуусын эгнээд шилжин орох эрсдэл бий болж байгаатай уялдан тэдний эрх ашгийг хамгаалах үүднээс судалгааны үндэслэлтэй шийдвэр гаргах нь тулгамдсан асуудлын нэг болоод байна. Судалгаа нь мал аж ахуйн салбарын үйл ажиллагаа болон хэрэгжүүлж буй арга хэмжээнд үнэлгээ өгч, малчдын орлогыг нэмэгдүүлэх боломжийг судалж, тодорхой зөвлөмжүүдийг гаргаснаараа малчдын нийгмийн амьдралд чухал үүрэг гүйцэтгэнэ гэж үзэж байна.

Монгол улсын Засгийн газраас Эдийн засгийн өсөлтийг дэмжиж, ядуурлыг бууруулах стратегийн баримт бичгийг батлан хэрэгжүүлж эхлээд байгаа өнөө үед судалгааны тайлан гарч байгаа нь баримт бичгийн хүрээнд, ядуурлыг бууруулахаар авч хэрэгжүүлэх үйл ажиллагаанд тусгалаа олох боломжтой.

Малжуулах хөтөлбөрийн үр дүнгийн талаар хийгдсэн дээрх судалгааны ажлыг Хөдөө Аж Ахуйн Их Сургуулийн эрдэмтэн багш нараас бүрдсэн баг долоон сарын хугацаанд хийж гүйцэтгэсэн бөгөөд судалгааны дүнг Ядуурлын судалгааны нэгжээс зохион байгуулсан Бүсийн болон Үндэсний таван удаагийн семинараар хэлэлцүүлж, орон нутгийн бодлого боловсруулагчдын саналыг тусгаснаараа оролцоог тодорхой хэмжээнд хангасан судалгаа боллоо гэж бид дүгнэж байна. Ядуурлын судалгааны нэгжээс судалгаануудын дүн болон зөвлөмжүүдийг нэгтгэн бодлого боловсруулагчдад хүргүүлэх болно.

Санхүү, эдийн засгийн яамны
Эдийн засгийн нэгдсэн бодлого,
Төлөвлөлтийн газрын дарга

/Ж.ЖАРГАЛСАЙХАН/

НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөрийн
"Ядуурлын судалгаа, Хөдөлмөр эрхлэлтийг
дэмжих" Төслийн Үндэсний Менежер

/П.ЦЭЦГЭЭ/

АГУУЛГА

Төслийн багийн танилцуулга 5

Хүснэгт 6

Зураг 7

Товчилсон үгийн тайлбар 8

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. УДИРТГАЛ

Оршил 9

Судалгааны зорилго 10

Судалгааны зохион байгуулалт 10

Судалгаанд ашигласан тоо мэдээ 12

Анкет асуулгын судалгааны үндсэн агуулга 13

ХОЁРДУГААР БҮЛЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Судалгааны материалд боловсруулалт хийсэн арга зүй 16

Түүвэрлэлт 17

ГУРАВДУГААР БҮЛЭГ. МАЛЖУУЛАЛТЫН ШАЛТГААН

Монголын малчдын нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдал 21

Бэлчээрийн мал аж ахуйн онцлог, давуу ба сул талууд 23

Малжуулах арга хэмжээг явуулах болсон шалтгаан 28

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. МАЛЖУУЛАХ ҮЙЛ ЯВЦ

Малжуулах арга хэмжээнд хамрагдсан аймаг сум, өрх, малын тоо 30

Судалгаанд хамрагдсан аймгуудын малжуулах үйл явц 34

Малжуулах арга хэмжээг зохион байгуулсан байгууллагууд 44

Малжуулах айл өрхийг сонгосон шалгуур 49

ТАВДУГААР БҮЛЭГ. МАЛЖУУЛАЛТЫН ҮР ДҮН, ТҮҮНД НӨЛӨӨЛСӨН ХҮЧИН ЗҮЙЛС

Малжуулалтад хамрагдсан өрхийн малын тоо, бүтэц 54

Малжуулалтын үр дүнгийн талаарх үнэлэлт 55

ЗУРГААДУГААР БҮЛЭГ. МАЛЖУУЛАХ АРГА ХЭМЖЭЭГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АРГА ЗАМ

Малжуулах арга хэмжээг боловсронгуй болгох арга замын талаарх бодол санал 67

Малчдын ирээдүйн талаарх төсөөлөл 68

ДОЛООДУГААР БҮЛЭГ. МАЛЧИН ӨРХИЙН АМЬЖИРГААГ САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ

Малчин өрхийн амьжиргааг сайжруулах зорилтын онцлог 70

Малчин өрхийн амьжиргааг сайжруулах талаар авах арга хэмжээний тогтолцоо 73

Малжуулалт явуулахад баримтлах загвар 74

НАЙМДУГААР БҮЛЭГ. ЗӨВЛӨМЖ БА ДҮГНЭЛТ

Малжуулалтаар олгох малын тоо, түүний бүтэц 76

Малжуулах үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар 76

Малчин өрхийн амьжиргааг сайжруулах талаар 77

Ерөнхий дүгнэлт 80

Ашигласан материал 82

ТӨСЛИЙН БАГИЙН ТАНИЛЦУУЛГА

Төслийн удирдагч

Лхамсүрэнгийн НАРАНХҮҮ
Эдийн засагч
Эдийн засгийн ухааны доктор (Ph.D), профессор
ХААИС-ийн ЭЗБС-ийн багш

Төслийн багийн гишүүд:

Баасанжавын ЖАНДАГСҮРЭН
Агро -эдийн засагч
Эдийн засгийн ухааны доктор (Ph.D), дэд профессор
ХААИС-ийн ЭЗБС-ийн багш

Дорлигийн ШОМБОДОН
Эдийн засагч-мал зүйч
Нийгмийн ухааны доктор (Ph.D)
Бизнес хөгжлийн агентлагын ахлах менежер

Сономын АМГАА
Эдийн засагч нягтлан бодогч
Эдийн засгийн ухааны доктор (Ph.D)
ХААИС-ийн ЭЗБС-ийн багш

Цэдэвсүрэнгийн АЛТАНБАТ
Эдийн засагч
Эдийн засгийн ухааны доктор (Ph.D)
ХААИС-ийн ЭЗБС-ийн Менежментийн тэнхимийн эрхлэгч

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1.1 Судалгаанд хамрагдагсадын тоо

Хүснэгт 2.1 Малжуулалтын судалгаанд хамруулсан аймгийн сонголт
Хүснэгт 2.2 Хохирлын түвшингийн судалгаа
Хүснэгт 2.3 Дундговь аймгийн судалгаанд хамруулах сумын сонголт
Хүснэгт 2.4 Судалгааны төлөөлөх чадвар

Хүснэгт 3.1 Малчин өрхийн нийгэм ахуйн зарим үзүүлэлтүүд, мянган өрхөөр
Хүснэгт 3.2 Малчин өрхийн орлого, зардлын тооцоо (Завхан аймгийн Идэр, Эрдэнэхайрхан сумын жишээн дээр)
Хүснэгт 3.3 Бэлчээрийн мал аж ахуйн давуу ба сул талууд
Хүснэгт 3.4 Зудын хохирол, сүүлийн жилүүдийн байдлаар
Хүснэгт 3.5 Малжуулах болсон шалтгаан

Хүснэгт 4.1 Малжуулах арга хэмжээг зохион байгуулсан байгууллага хамрагдсан аймаг, сум, өрхийн тоо
Хүснэгт 4.2 Малжуулах төсөлд хамрагдсан байдал
Хүснэгт 4.3 Малжуулалтанд хамрагдсан өрхийн малжуулалтанд хамрагдах үеийн малын тоо, өрхийн бүтцээр
Хүснэгт 4.4 Малжуулах төслийг хэрэгжүүлэгчид
Хүснэгт 4.5 Малжуулах төсөлд хамрагдсан байдал
Хүснэгт 4.6 Нэг өрхийн малын тооны өөрчлөлт, сумын дундажаар
Хүснэгт 4.7 Малгүй ба малаа хорогдуулсан айл өрхийн шилжилт хөдөлгөөн
Хүснэгт 4.8 Баянхонгор аймгийн малжуулах төсөлд хамрагдсан байдал
Хүснэгт 4.9 Судалгаанд хамрагдсан өрхийн малын тоо
Хүснэгт 4.10 Малжуулалтанд хамрагдсан өрхүүдэд олгосон
Хүснэгт 4.11 Зохион байгуулсан сургалт
Хүснэгт 4.12 Хөвсгөл аймаг дах малжуулалтын үр дүнгийн судалгаа
Хүснэгт 4.13 Малжуулалтанд хамрагдсан өрхүүдийн орлогоор хийсэн бүлэглэлт
Хүснэгт 4.14 Судалгаанд хамруулах сумын сонголт
Хүснэгт 4.15 Байгалийн гамшигийн улмаас малгүй буюу цөөн малтай болсон өрхүүдийг малжуулах төслийн хуваарь
Хүснэгт 4.16 Ядуурлыг бууруулах хөтөлбөрөөр малжуулсан аймаг, сум, малын тоо
Хүснэгт 4.17 Малжуулалтаар олгосон малын тоо, бүтэц
Хүснэгт 4.18 Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн малжуулалтын судалгаа
Хүснэгт 4.19 “Санкей” сонины газрын малжуулалтын дүн
Хүснэгт 4.20 Малжуулалтанд хамруулах өрхийг сонгосон шалгуур, удирдлагын бодлоор
Хүснэгт 4.21 Малжуулах арга хэмжээнд хамруулсан шалгуур (саналын хувийн

	жингээр)
Хүснэгт 4.22	Удирдлагын гүйцэтгэсэн үүрэг
Хүснэгт 4.23	Малжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлсэн аймаг, сумдын онцлог, давуу ба сул талууд.
Хүснэгт 5.1	Судалгаанд хамрагдсан өрхийн малын тоо, толгойгоор
Хүснэгт 5.2	Судалгаанд хамрагдсан өрхийн малын тооны бүтэц, %
Хүснэгт 5.3	Малжуулах арга хэмжээ зөв эсэхэд өгсөн үнэлэлт, хувийн жингээр
Хүснэгт 5.4	Малжуулалтаар авсан малын тооны өөрчлөлт
Хүснэгт 5.5	Малчин өрхийн бүтээмжийн өөрчлөлт
Хүснэгт 5.6	Малчин өрхийг малын тоогоор нь бүлэглэсэн бүлэглэлт
Хүснэгт 5.7	Малжуулах арга хэмжээний малчдын амьдралд нөлөөлсөн нөлөөлөл, саналын хувийн жингээр
Хүснэгт 5.8	Судалгаанд хамрагдсан малчин өрхийн хөрөнгийн хангамж (нийт дүнд эзлэх хувийн жингээр)
Хүснэгт 5.9	Судалгаанд хамрагдсан малчин өрхийн хөрөнгийн хангамж, аймгаар (нийт дүнд эзлэх хувийн жингээр)
Хүснэгт 5.10	Малжуулах арга хэмжээ аваагүй бол яах байсан бэ
Хүснэгт 5.11	Малжуулалтанд хамрагдаад малаа өсгөсөн өрхийн тоо
Хүснэгт 5.12	Малжуулалтаар авсан малаа өсгөсөн шалтгаан, хувийн жингээр
Хүснэгт 5.13	Малжуулалтаар авсан малаа хорогдуулсан шалтгаан, саналын хувийн жингээр
Хүснэгт 5.14	Ган, зудад малаа хорогдуулсан шалтгаан (саналын хувийн жингээр)
Хүснэгт 5.15	Судалгаанд хамрагдагсдын тодорхойлолт, аймгаар
Хүснэгт 5.16	Судалгаанд хамрагдагсадын тодорхойлолт, малжуулалтын үр дүнгээр
Хүснэгт 5.17	Судалгаанд хамрагдагсадын боловсролын байдал, хувийн жингээр
Хүснэгт 5.18	Өвөлжөө хаваржааны хангамж, бэлчээрийн хүрэлцээ (нийт дүнд эзлэх хувийн жингээр)
Хүснэгт 6.1	Малжуулалтыг илүү үр дүнтэй болгох байсан арга замууд
Хүснэгт 6.2	Малжуулалтын арга хэлбэрийг боловсронгуй болгох санал
Хүснэгт 6.3	Ирээдүйн амьдралын талаарх санал, бодол
Хүснэгт 6.4	Мал аж ахуй эрхлэж амьдрах нь хир ирээдүйтэй вэ
Хүснэгт 6.5	Малчин өрхийн үндсэн хэрэглээнүүдийн хангамжийн байдал (Өрхийн хувийн жингээр)
Хүснэгт 7.1	Малчин өрхийн амьжиргааны түвшний ялгаа
Зураг 1.1	Судалгаа явуулах дэс дараалал
Зураг 3.1.	Малжуулах болсон шалтгаан
Зураг 4.1.	Малжуулах арга хэмжээнд хамрагдсан аймгууд
Зураг 4.2	Судалгаанд хамрагдсан аймгууд
Зураг 5.1	Малчин өрхийн орлогын бүтэц

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ТАЙЛБАР

СЭЗЯ	Санхүү Эдийн Засгийн Яам
ЯСН	Ядуурлын судалгааны нэгж
НҮБ	Нэгдсэн Үндэсний Байгууллага
НҮБХХ	Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр
ХААХОУС	Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сан
ХХААЯ	Хүнс Хөдөө Аж Ахуйн Яам
ХААИС	Хөдөө Аж Ахуйн Их Сургууль
ЭЗБС	Эдийн засаг бизнесийн сургууль
ХАА	Хөдөө аж ахуй
МАА	Мал аж ахуй
ЯБХ	Ядуурлыг бууруулах хөтөлбөр

Аймагууд:

БХ	Баянхонгор
БӨ	Баян-Өлгий
СҮ	Сүхбаатар
ХӨ	Хөвсгөл

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: УДИРТГАЛ

1.1. Энэхүү бүлэгт малчин өрхийн орлогыг нэмэгдүүлж амьжиргааг сайжруулах зорилгоор Монгол улсад хэрэгжсэн малжуулах арга хэмжээний үр дүн, түүнийг цаашид боловсронгуй болгох арга замыг тодорхойлсон судалгаа хийх болсон үндэслэл, судалгааны зорилго, зорилт, зохион байгуулалт, судалгаанд ашигласан тоо мэдээллийн талаар өгүүлсэн болно.

Оршил

1.2. Монгол улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжин өмч хувьчлал явагдсаны үр дүнд малчид аж ахуй эрхлэх, өмч эзэмших эрхтэй субьект болон хувирсан билээ. Статистикийн мэдээнээс үзвэл 2000 оны байдлаар улсын нийт малын 96.7 хувь нь хувийн хэвшилд хамрагдаж, нэг малчин өрхөд дунджаар 135 толгой мал ногдож байв. Түүнчлэн аминдаа малтай нийт өрхийн 30,9 хувь нь 100 аас дээш толгой малтай болжээ. Гэвч сүүлийн жилүүдэд манай орны нутаг дэвсгэрийг хамарсан ган, зудын гамшгийн улмаас малчин өрхийн амьжиргааны гол хэрэгсэл болох мал сүрэг ихээхэн хэмжээгээр хорогдлоо.

1.3. Тухайлбал, 1999-2000 оны өвөл, хаврын зуд нийт нутгийн 70% -ийг хамарч, 3,4 сая мал хорогдсон бөгөөд үүний уршгаар 2,3 мянган өрх малаа баржээ. 2000-2001 оны зуданд 4,2 сая том мал хорогдсон ба үүний дээр их цас, хүйтний улмаас хээл хаясан мал, хорогдсон төлийн тоог нэмбэл дээрхи тоо бараг 50 орчим хувиар нэмэгдэнэ.

1.4. Жил дараалан болж байгаа ган, зудын уршгаар малчин өрхийн нилээд хэсэг нь мал цөөнтэй эсвэл огт малгүй болж ядуу, эмзэг бүлэгт хамрагдах болов. Тэднийг малжуулах талаар Монгол улсын төсвөөс болон бусад олон улсын байгууллагаас тодорхой хэмжээний хөрөнгө зарцуулж байгаа боловч энэ арга хэмжээ тэр бүр үр дүнд хүрч чадахгүй байна. Зөвхөн өнгөрсөн жилийн зуданд Япон улсаас 10 сая ам доллар, бусад эх үүсвэрээс 20 гаруй сая долларын хөрөнгийг зарцуулжээ.

1.5. Ядуурлыг бууруулах хөтөлбөр, Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын хөгжлийн сан, Олон улсын хүмүүнлэгийн байгууллагын шугамаар 7 аймгийн 61 сумын 3000 гаруй өрхөд олон мянган толгой малыг малжуулах зорилгоор зээлээр олгосон боловч энэ арга хэмжээний эцсийн үр дүн ямар байгаа, цаашид ийм арга хэрэглэх нь хэр үр дүнтэйг тооцоолж судлаагүй байна.

1.6. Үүний зэрэгцээ малжуулах асуудал, бэлчээрийн мал аж ахуйн талаар зарим эрдэмтэд, мэргэжилтэн, аж ахуйн нэгжийн удирдлагуудын дунд маргаантай асуудлууд өнөөг хүртэл үргэлжилсээр байна. Малжуулалт нь малгүй болон цөөн малтай болсон олон айл өрхийг малтай болгож тэднийг амьжиргааны эх үүсвэрээр нь хангадаг, дасаж дадсан мал аж ахуйн төрлийн бизнесийг дахин эрхлэх бололцоог олгодог зэрэг давуу талуудтай боловч, тэдний байгалийн бэрхшээлийг даван туулах тэмцлийг сулруулдаг, өөрийн хүч, хөрөнгө хөдөлмөрөөр бүтээгүй зүйлд хайнга хандаж, бэлэнчлэх сэтгэлгээнд сургадаг зэрэг сул талууд ажиглагдаж байна.

1.7. Мөн зарим малчдын хайхрамжгүй үйл ажиллагаа, мал маллах арга ухаан дутмаг, бэлэнчлэх сэтгэлгээнээс үүдэн малаа үрэгдүүлж, хорогдуулах, өвс тэжээл

хангалтгүй бэлтгэх, бусдад зарж бизнес хийх, дээд байгууллагуудаас дахин мал хүсэх зэрэг дутагдал ажиглагдсаар байна. Иймд малчин өрхийн амьжиргааг сайжруулах арга замыг зөв тодорхойлох зорилгоор малжуулалтын сургамж ба малчин өрхийн амьжиргааг дээшлүүлэх асуудлыг судлах явдал өнөөдрийн тулгамдсан чухал асуудал болоод байгаа билээ.

Судалгааны зорилго

1.8. Сүүлийн жилүүдэд дараалан болсон ган, зуд болон нийгмийн бусад олон хүчин зүйлүүдээс шалтгаалж малгүй болсон малчин өрхүүдийг малжуулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнг судлаж, цаашид тэдний амьдралыг дээшлүүлэх арга зам, малжуулах арга, хэлбэрийг тодорхойлсон зөвлөмж гаргахад уг төслийн зорилго оршино.

Зорилтууд

1.9. Энэ зорилгоо хэрэгжүүлэх үүднээс дараах зорилтуудыг дэвшүүлэн тавьсан. Үүнд:

1. Малжуулалтанд зарцуулсан хөрөнгө, малжуулсан арга хэлбэр, хамрагдсан өрхүүдээс мал нь өсч амжилттай ажиллаж байгаа болон мал нь хорогдсон айл өрхүүдийг тодорхойлох,
2. Малжуулах төсөлд хамрагдаад мал нь өссөн ба хорогдсон шалтгааныг малжуулсан арга, тэр үеийн цаг агаарын нөхцөл, хувь хүмүүсийн аж ахуй эрхлэх арга туршлага болон бусад хүчин зүйлтэй холбон судлах,
3. Малжуулалтыг хэрэгжүүлсэн болон түүнд оролцсон, үр дүнгий нь хүртсэн байгууллага, хүмүүсийн гол төлөөлөгчидтэй уулзаж, судалгаа хийх замаар малжуулалтын ололттой ба дутагдалтай талуудыг тодорхойлох,
4. Малжуулах төсөлд хамрагдаад мал нь өсч амжилттай ажиллаж байгаа болон тус бүс нутагт мал аж ахуйн үйлдвэрлэлийг амжилттай эрхэлж, аж амьдрал нь дээшилж байгаа малчин өрхүүдийн эрхэлж байгаа салбар, тэдгээрээс олох орлого, хэрэглээний бүтэц, хэмжээг судлах,
5. Малчин өрхийн жилд үйлдвэрлэж байгаа бүтээгдэхүүн, орлогын хэмжээнд байгаль, цаг уурын эрсдэл, аж ахуй эрхлэх арга туршлага, хувь хүний овсгоо бусад хүчин зүйлс хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлох.
6. Малжуулалт нь малчин өрхийн орлогыг нэмэгдүүлэх болон ядуурлаас хамгаалах замаар тэдний амьжиргааг баталгаатай болгоход туслалцаа үзүүлж хөдөө аж ахуйн бүтээмжийг ерөнхийд нь нэмэгдүүлэхэд эерэг нөлөө үзүүлсэн эсэхийг тодорхойлох,
7. Засгийн газар, хандивлагчдийн санхүүжүүлсэн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн механизм, зохион байгуулалтыг зэрэгцүүлэн үзэж малжуулалтын хүрээнд болон нийт малын өсөлтөд онцгой үр дүнд хүрсэн хөтөлбөр байгаа эсэхийг судлах.

Судалгааны зохион байгуулалт

1.10. Санхүү эдийн засгийн Яамны дэргэдэх Ядуурлын судалгааны нэгж нь ядуурлыг бууруулах чиглэлээр судалгаа явуулж, дүн шинжилгээ хийх, тэдгээрийн дүгнэлтийг үндэслэн Засгийн газарт бодлогын зөвлөмж өгөх үүргийнхээ дагуу 2003

оны 1-р сард зарласан "Малжуулалтаар малчин өрхүүдийн орлогыг нэмэгдүүлж амьжиргааг баталгаажуулах стратегийн үр дүнг үнэлэх нь" төслийн тендерт шалгарснаар бидний судалгааны ажил эхэлсэн юм.

Судалгааны ажлыг дараах үндсэн 5 үе шатаар явуулсан. Үүнд:

1. Холбогдох байгууллагуудаас урьд өмнө хийгдсэн судалгааны баримт материалуудыг судлаж дүгнэх,
2. Судалгааны ажлын арга зүй боловсруулах,
3. Мэдээлэл цуглуулах,
4. Мэдээлэл боловсруулах
5. Тайлан бичих.

1.11. Баримт материал цуглуулах, уншиж, судлах эхний үе шатанд малжуулалт, ган, зудын эрсдэл, хөдөөгийн ядуурал, малчин өрхийн амьжиргааг сайжруулах арга замтай холбоотой Монгол улсын засгийн газрын тогтоол шийдвэр, хөтөлбөр, журзаавар, Монгол улсын Засгийн газар болон Олон улсын байгууллагуудын хөрөнгөөр санхүүжигдэн хэрэгжсэн төслийн тайлан, семинар, бага хурлын материал, судалгаа, эрдэм шинжилгээний өгүүлэл зэрэг 40 гаруй материалыг уншиж судлав.

1.12. Судалгааны 2 дахь үе шатанд дээр судалсан материалд тулгуурлан судалгааны арга зүй боловсруулав. Судалгааны ажлын тайлан материалуудтай танилцан дэвшүүлсэн санал, дүгнэлтэд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр мэдээлэл цуглуулахад ашиглах анкетын судалгаа, асуулга, ярилцлагын асуудлууд, судалгааны хүснэгт, аргачлал зэргийг боловсруулсан.

1.13. Судалгааны 3 дахь үе шатанд судлаачдын багийг хөдөө орон нутагт томилолтоор ажиллуулж малжуулах ажлын явц, үр дүнгийн талаар тоо мэдээлэл цуглуулж, малжуулалтад хамрагдсан аймгийн дотроос судалгаа явуулах дараагийн шатны объект болох сумдыг, сонгон авсан сумдаас малжуулалтад хамрагдсан багийг, багаас өрхийг тодруулсан. Мөн сум багийн удирдах ажилтануудаас судалгаа авсан. Өөрөөр хэлбэл, судалгааг дараах дэс дараалалаар явуулсан.



Зураг 1.1. Судалгаа явуулах дэс дараалал

Малжуулалтад хамрагдсан ба хамрагдаагүй өрхөөс ярилцлагын хэлбэрээр, малжуулах арга хэмжээ хэрэгжүүлсэн аймаг, сум, багийн удирдлагаас анкетийн судалгаа бөглүүлэх хэлбэрээр судалгаа авсан байна. Малжуулах арга хэмжээг хэрэгжүүлсэн байгууллага, тэр үед ажиллаж байсан хүмүүстэй уулзаж, ярилцлага явуулж, анкетийн судалгаа бөглүүлсэн.

1.14. Судалгааны 4 дэх үе шатанд судалгаанд хамрагдсан 4 аймгийн 17 сумын малжуулалтанд хамрагдсан ба хамрагдаагүй өрхийн мэдээллүүдийг янз бүрийн шинжээр нь бүлэглэх, харьцуулах зэрэг аргуудаар нөлөөлсөн хүчин зүйлүүдийг тодорхойлох, малжуулалт явуулсан онцлог шинж чанар, давуу ба сул талуудыг илрүүлэх, судалгааны дүгнэлтүүдийг олон хувилбараар боловсруулах, түүнээс оновчтойг нь сонгоход хүснэгт, диаграмм, төсөл тооцооны аргуудыг хэрэглэв.

1.15. Судалгааны 5 дахь үе шатанд судалгааны багийн гишүүд тайлангийн бүтцийг 3 удаа бүрэлдэхүүнээрээ хэлэлцэн эцсийн хувилбарыг боловсруулсан юм. Эцсийн тайлангийн өмнө Ядуурлын судалгааны нэгжид 4 удаа явцын тайланг хүлээлгэн өгсөн бөгөөд энэ үе шатанд тайлангийн эхний хувилбарыг бэлтгэх, англи хэл дээр орчуулах, тайланг хэвлэх, олшруулах, засвар өөрчлөлт хийх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн болно.

1.16. Судалгааны явцад Ядуурлын судалгааны нэгж 2 удаа төслийн багийн гишүүд, холбогдох байгууллагуудын ажилтнуудыг оролцуулан ярилцлага хийсэн бөгөөд уг ярилцлагаас гарсан санал, дүгнэлтүүдийг эцсийн тайлан бичихдээ харгалзан үзсэн болно. Үүнээс гадна малжуулах арга хэмжээний үр дүн, дэвшүүлэх санал дүгнэлтүүдийн талаар Дундговь, Завхан аймгийн удирдах ажилтануудтай ярилцлага хийж, тэдний санал дүгнэлтүүдийг эцсийн тайланд тусгасан. Мөн Ядуурлын судалгааны нэгжээс зохион байгуулсан салбарын тэргүүлэх эрдэмтэд, холбогдох байгууллагын хүмүүсийг оролцуулсан семинар дээр уг төслийн явц, үр дүнгийн тухай илтгэл хэлэлцүүлэхэд гарсан санал, зөвлөмжүүдийг төгсгөлийн тайланд тусгасан болно.

Судалгаанд ашигласан тоо мэдээ

1.17. Судалгаанд хамрагдах аймгуудыг сонгосон шалгуур үзүүлэлтүүдэд тулгуурлан дараах аймаг, сум, малчин өрхүүдийг судлав.

1. Байгалийн ба эдийн засгийн бүсийн байршил, ган зудын давтамж, малын хорогдолын хэмжээ зэргээр нь ялгаатай Завхан, Баянхонгор, Дунговь, Хөвсгөл аймгуудыг судалгааны нэгж болгон сонгож авсан юм.
2. Эдгээр аймгуудаас нийт 17 сумыг сонгон авсаны дотор Дундговь, Баянхонгор, Хөвсгөл аймаг тус бүрээс 4 сум, Завхан аймгаас 5 сум судалгаанд хамрагдсан байна.
3. Судалгааны явцад малжуулах арга хэмжээнд хамрагдсан 185, хамрагдаагүй 178, нийт 353 өрх хамрагдсаны дотор аймаг бүрээс дундажаар 73-100 малчин өрхөөс санал асуулга авсан байна.
4. Дундговь аймгаас малжуулах арга хэмжээнд хамрагдсан 49 өрх, малжуулалтанд хамрагдаагүй 24 өрхийг судалсаны дотор малаа өсгөсөн 19, малын тоо нь хэвийн байгаа 5, хорогдуулсан буюу огт малгүй болсон 22 өрх,
5. Хөвсгөл аймгаас малжуулах арга хэмжээнд хамрагдсан 50 өрх, малжуулалтанд хамрагдаагүй 50 өрхийг судалсаны дотор малаа өсгөсөн 28, малын тоо нь хэвийн байгаа 10, хорогдуулсан буюу огт малгүй болсон 12 өрх, ,
6. Завхан аймгаас малжуулах арга хэмжээнд хамрагдсан 42 өрх, малжуулалтанд хамрагдаагүй 50 өрхийг судалсаны дотор малаа өсгөсөн 4, малын тоо нь хэвийн байгаа 11, хорогдуулсан буюу огт малгүй болсон 27 өрх,
7. Баянхонгор аймгаас малжуулах арга хэмжээнд хамрагдсан 44 өрх, малжуулалтанд хамрагдаагүй 54 өрхийг судалсаны дотор малаа өсгөсөн 18, малын тоо нь хэвийн байгаа 7, хорогдуулсан буюу огт малгүй болсон 22 өрх байна.
8. Малжуулалтыг хэрэгжүүлж байх үед түүнтэй холбоотой чухал албан

тушаалд ажиллаж байсан аймаг, сум, багийн засаг дарга, засаг даргын орлогч, өрхийн амьжиргааны чадавхийг дээшлүүлэх төслийн зохицуулагч, мал эмнэлэг, үржлийн албаны улсын байцаагч, мал зүйч зэрэг нийт 57 хүнээс судалгаа авчээ.

9. Малжуулах арга хэмжээг хэрэгжүүлсэн байгууллага болох төрийн 2, төрийн бус 2, олон улсын 9, нийт 13 байгууллагын удирдах ажилтан, төслийн зохицуулагч нартай уулзаж ярилцсан байна.
10. Судалгаанд хамрагдсан 4 аймаг, судалгааны үндсэн 4 обектоос нийт дүнгээр 433 хүнтэй уулзаж ярилцан мэдээлэл цуглуулсанаас 83,8% нь малчин өрхийн аж ахуй байлаа. (Хүснэгт 1.1)

Хүснэгт 1.1

Судалгаанд хамрагдагсадын тоо

Судалгааны обьект	Завхан	Баянхонгор	Дундговь	Хөвсгөл	Нийт
Малжуулалтанд хамрагдсан өрх	42	44	49	50	185
Малжуулалтанд хамрагдаагүй өрх	50	54	24	50	178
Аймаг, сум, багийн удирдлага	8	15	19	15	57
Малжуулалтыг хэрэгжүүлсэн байгууллагын удирдлага	2	3	2	6	13
Бүгд дүнгээр	102	116	94	121	433

11. Судалгааны үндсэн обектуудаас гадна судалгаа явуулахад Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн Хөтөлбөр, Санхүү, Эдийн засгийн Яам, Ядуурлын судалгааны нэгж, Хүнс, Хөдөө Аж Ахуйн Яамын холбогдох газар, хэлтэсүүд, Үндэсний статистикийн газарын тоо материал болон Хөдөө аж ахуйн их сургууль, Эдийн засаг бизнесийн сургуульд хийж гүйцэтгэсэн малжуулалт ба хүн амын ядуурал, амьжиргааны түвшний талаархи судалгааны материалуудаас тоо баримт ашигласан болно.

Анкет, асуулгын судалгааны үндсэн агуулга

Судалгаанд хамрагдах нэгж бүр дээр анкетийн судалгааны асуултыг тус бүрийн онцлогийг харгалзан ялгавартай боловсруулсан.

1.18. Малжуулах арга хэмжээнд хамрагдсан өрхийн анкетийн судалгааны асуултын агуулга

1. Өрхийн байдал: Ам бүлийн тоо, бүрэлдэхүүн, мал малласан хугацаа, тухайн орон нутагт амьдарсан хугацаа,
2. Мал аж ахуй эрхлэх нөхцөл: Нутгийн байршил, өвөлжөө хаваржаа, бэлчээрийн хангамж, малаа хорогдуулахын өмнө ба малжуулах үед байсан малын тоо, малын төрөл,
3. Малжуулах шалтгаан: Малаа хорогдуулсан шалтгаан, малжуулалтад яаж хамрагдсан, малжуулахын өмнөх ба дараахь үеийн сэтгэл санааны

байдал,

4. Малжуулалт: Малжуулах арга хэмжээнд яаж хамрагдсан, хаанаас малжуулсан, ямар арга хэлбэрээр малжуулсан, хэдий хэмжээний мал хөрөнгө хүлээн авсан,
5. Малжуулалтын дараахь үр дүн: Одоо ямар хэмжээний мал хөрөнгөтэй болсон, мал өссөн эсвэл хорогдсон шалтгаан, одоо өр зээл байгаа эсэх,
6. Малжуулалтын дараахь бодол санал: Малжуулах арга хэмжээ зөв явагдсан уу, Малжуулах арга хэмжээ аваагүй бол яах байсан бэ, ирээдүйд яах төлөвлөгөөтэй байна,
7. Малчин өрхийн амьжиргааг сайжруулах талаар таны бодол санал: Малчин өрхийн одоогийн амьдралын хэв маягийг та юу гэж үнэлдэг вэ, хот суурин газрын өрхийн амьдралтай харьцуулахад ямар гэж боддог вэ, малчин өрхийн амьжиргааг сайжруулахын тулд төр, засаг, хувь хүмүүс юу хийх ёстой вэ, та өөрийгөө яая гэж бодож байна

1.19. Малжуулах арга хэмжээнд хамрагдаагүй өрхийн анкетийн судалгааны асуултын агуулга

1. Өрхийн байдал: Ам бүлийн тоо, бүрэлдэхүүн, мал малласан хугацаа, тухайн орон нутагт амьдарсан хугацаа,
2. Мал аж ахуй эрхлэх нөхцөл: Нутгийн байршил, өвөлжөө хаваржаа, бэлчээрийн хангамж, зудын өмнө ба дараа үед байсан малын тоо, төрөл,
3. Малжуулах шалтгаан: Малжуулалтад хамрагдсан өрхүүдийн малаа хорогдуулсан шалтгаан, малжуулалтад яаж хамрагдсан, малжуулахын өмнөх ба дараахь үеийн тэдний сэтгэл санааны байдал,
4. Малжуулалтын талаарх таны ойлголт: Малжуулах арга хэмжээнд яаж хамрагдсан, хаанаас малжуулсан, ямар арга хэлбэрээр малжуулсан, хэдий хэмжээний мал хөрөнгө өгсөн,
5. Малжуулалтын дараахь үр дүн: Малжуулах арга хэмжээний дараа авсан малаа өсгөсөн эсвэл хорогдуулсан шалтгаан ,
6. Малжуулалтын дараахь бодол санал: Малжуулах арга хэмжээ зөв явагдсан уу, Малжуулах арга хэмжээ аваагүй бол тэд яах байсан бэ, танайд яагаад мал өгөөгүй вэ,
7. Малчин өрхийн амьжиргааг сайжруулах талаар таны бодол санал: Малчин өрхийн одоогийн амьдралын хэв маягийг та юу гэж үнэлдэг вэ, хот суурин газрын өрхийн амьдралтай харьцуулахад ямар гэж боддог вэ, малчин өрхийн амьжиргааг сайжруулахын тулд төр, засаг, хувь хүмүүс юу хийх ёстой вэ, та өөрөө ирээдүйд яая гэж бодож байна;

1.20. Малжуулах арга хэмжээнд хамрагдсан аймаг, сум, багийн удирдлагаас авсан анкетийн судалгааны асуултын агуулга

1. Анкетийн судалгаанд оролцогчийн тодорхойлолт: Малжуулах арга хэмжээг хэрэгжүүлэх үед болон одоо хийж байгаа ажил, албан тушаал, мэргэжил,
2. Малжуулах арга хэмжээний талаархи ойлголт: Малчдын малаа хорогдуулсан болон малжуулах арга хэмжээ авах болсон шалтгаан, малжуулалтыг ямар байгууллагаас ямар арга хэлбэрээр явуулсан, ямар

болзол хангасан малчдыг уг арга хэмжээнд хамруулсан, малжуулалт хир зэрэг шударга явагдсан, аймаг, сум, багийн удирдлага малжуулалтад ямар үүрэгтэй оролцсон,

3. Малжуулалтын дараахь үр дүн: Малжуулах арга хэмжээ хир зэрэг зөв явагдсан, малжуулах арга хэмжээ аваагүй бол ядуурсан малчид яах байсан бэ, малжуулалтыг яаж явуулсан бол илүү зөв байсан бэ, цаг агаарын хүндрэлийн улмаас гарсан хохирлын дараа цаашид ямар арга хэмжээ авах ёстой вэ
4. Малчин өрхийн амьжиргааг сайжруулах талаар таны бодол санал: Малчин өрхийн одоогийн амьдралын хэв маягийг та юу гэж үнэлдэг вэ, хот суурин газрын өрхийн а мьдралтай харьцуулахад ямар гэж боддог вэ, малчин өрхийн амьжиргааг сайжруулахын тулд төр, засаг, хувь хүмүүс юу хийх ёстой вэ;

1.21. Малжуулах арга хэмжээг зохион байгуулсан байгууллага, хүмүүсээс авсан анкетийн судалгааны асуултын агуулга

1. Анкетийн судалгаанд оролцогчийн тодорхойлолт: Малжуулах арга хэмжээг хэрэгжүүлэх үед болон одоо хийж байгаа ажил, албан тушаал, мэргэжил, малжуулах арга хэмжээг хаана хэдий өрхийн хэмжээнд хэрэгжүүлсэн, уг ажлын үр дүнг ямар хэлбэрээр тайлагнаж, хяналт үнэлгээ өгсөн,
2. Малжуулах арга хэмжээний талаархи ойлголт: Малчдын малаа хорогдуулсан болон малжуулах арга хэмжээ авах болсон шалтгаан, малжуулалтыг ямар арга хэлбэрээр явуулсан, ямар болзол хангасан малчдыг уг арга хэмжээнд хамруулсан, малжуулалт хир зэрэг шударга явагдсан, аймаг, сум, багийн удирдлага малжуулалтад ямар үүрэгтэй оролцсон,
3. Малжуулалтын дараахь үр дүн: Малжуулах арга хэмжээ хир зэрэг зөв явагдсан, малжуулах арга хэмжээ аваагүй бол ядуурсан малчид яах байсан бэ, малжуулалтыг яаж явуулсан бол илүү зөв байсан бэ, цаг агаарын хүндрэлийн улмаас гарсан хохирлын дараа цаашид ямар арга хэмжээ авах ёстой вэ,
4. Малчин өрхийн амьжиргааг сайжруулах талаар таны бодол санал: Малчин өрхийн одоогийн амьдралын хэв маягийг та юу гэж үнэлдэг вэ, хот суурин газрын өрхийн амьдралтай харьцуулахад ямар гэж боддог вэ, малчин өрхийн амьжиргааг сайжруулахын тулд төр, засаг, хувь хүмүүс юу хийх ёстой вэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ: СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

2.1. Энэ бүлэгт судалгааны материалд боловсруулалт хийсэн дэс дараалал, мэдээлэл цуглуулахад хэрэглэсэн арга, судалгааны үндсэн нэгжүүдийн тодорхойлолт, аймаг, сум, баг, малчин өрхүүдийг сонгосон шалгуурууд, судалгааны төлөөлөх чадварын талаар авч үзсэн болно.

Судалгааны материалд боловсруулалт хийсэн арга зүй

2.2. Судалгааны ажлыг дараах үе шатаар явуулсан. Үүнд:

1. Судалгаанд ашиглах тоо мэдээ цуглуулах,
2. Судалгааны материалд боловсруулалт хийх,
3. Дүгнэлт, санал гаргах.

2.3. Судалгаанд статистикийн олон шатат санамсаргүй түүврийн аргыг ашиглан мэдээлэл цуглуулах дараахь аргуудыг хэрэглэсэн. Үүнд:

1. Баримт бичиг судлах арга,
2. Анкетийн судалгаа,
3. Ярилцлага, сурвалжлага,
4. Оролцооны арга.

2.4. Судалгааны үндсэн нэгжээр малжуулалт болон малчин өрхийн амьжиргааны талаар дүгнэлт гаргаж чадах дараах үндсэн объектуудыг сонгон авсан. Үүнд:

1. Малжуулалтад хамрагдсан өрх,
2. Малжуулалтад хамрагдаагүй, хөндлөнгийн ажиглагч өрх,
3. Малжуулах арга хэмжээнд хамрагдсан аймаг, сум, багийн удирдлага,
4. Малжуулах арга хэмжээг зохион байгуулсан байгууллага, хүмүүс.

2.5. Малжуулалтанд хамрагдсан өрх гэдэг ойлголтод ган, зуд, байгалийн гэнэтийн аюул зэрэг давагдашгүй хүчин зүйлийн улмаас амьжиргааны үндэс болсон мал сүргээ алдаж, цаашид хэвийн амьдрах аргагүй болсон болон угаасаа цөөн малтай, ядуу бөгөөд энэ байдлыг арилгах зорилгоор төр, олон нийтийн болон олон улсын байгууллагуудаас буцалтгүй, урт хугацааны зээлийн хэлбэрээр мал буюу түүнийг худалдан авах хөрөнгө авсан өрхүүдийг хамааруулж байна. Малжуулах арга хэмжээнд хамрагдсан өрхийг үйл ажиллагааны эцсийн үр дүнгээр нь дараахь гурван бүлэгт хуваж судалсан болно. Үүнд:

- Малжуулах арга хэмжээний дараа малаа өсгөж, амьдралаа хэвийн түвшинд хүргэсэн буюу малжуулах арга хэмжээг үр дүнтэй ашигласан өрх
- Малжуулах арга хэмжээний дараа мал нь хэвийн хэмжээндээ байгаа өрх,
- Малжуулах арга хэмжээний дараа малаа өсгөж чадаагүй буюу огт малгүй болсон өрх.

2.6. Малжуулалтад хамрагдаагүй, хөндлөнгийн ажиглагч өрх гэдэгт түүвэр судалгаанд хамрагдсан аймаг, сум, багийн нутагт малжуулах арга хэмжээнд хамрагдсан өрхүүдтэй ойр зэргэлдээ, адил нөхцөлд мал аж ахуй эрхлэн амьдардаг,

малжуулах арга хэмжээнд хамрагдаагүй өрхийг оруулна. Малжуулалтад хамрагдсан ба хамрагдаагүй өрхийн судалгаанд анкетийн арга, ярилцлагын аргуудыг ашиглав.

2.7. Малжуулах арга хэмжээнд хамрагдсан аймаг, сум, багийн удирдлагад малжуулах арга хэмжээг хэрэгжүүлэх үед ба одоо ажиллаж байгаа эдгээр шатны засаг дарга, түүний орлогч, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, нийгэм, хөдөө аж ахуйн ажил хариуцсан албаны ажилтнуудыг хамруулсан.

2.8. Малжуулах арга хэмжээг зохион байгуулсан байгууллага, хүмүүс гэдэг ойлголтод малжуулах арга хэмжээг санхүүжүүлсэн, уг ажлыг гардан гүйцэтгэсэн хяналт үнэлгээ хийсэн байгууллага, түүний ажилтнуудыг хамруулав. Малжуулах арга хэмжээнд хамрагдсан аймаг, сум, багийн удирдлага, малжуулах арга хэмжээг зохион байгуулсан байгууллага, хүмүүсийн судалгаанд ярилцлага, анкетийн арга, баримт бичиг судлах аргуудыг ашиглав.

Түүвэрлэлт

2.9. Малжуулах арга хэмжээ нь олон аймаг, сум өрхийг хамарсан өргөн хүрээтэй үйл ажиллагаа байсан учир бүгдийг нэлэнхүйд нь хамаруулахад төвөгтэй юм. Иймд судалгааны баг судалгаанд шаардлагатай тоо баримт цуглуулахдаа арга зүйд дурьдсаны дагуу түүвэр судалгааны арга ашигласан.

Аймгийн сонголт

2.10. Зудад нэрвэгдсэн 13 аймгаас 4 аймгийг судалгааны үндсэн объект болгон сонгон авлаа. Судалгаанд хамруулах аймгийг сонгохдоо урьд хийгдсэн тайлан, судалгааны тоо мэдээнд тулгуурласан зорилтот түүврийн аргыг ашиглав. Ингэхдээ дараах шалгуур үзүүлэлтүүдийг ашигласан болно. Үүнд:

- хохирлын хэмжээ,
- малжуулах төсөлд хамрагдсан сум,өрх, малын тоо,
- байгалийн бүсийн ялгаа,
- ган,зудын давтамж,
- төсөл хэрэгжүүлсэн байгууллагын ялгаа.

Хүснэгт 2.1

Малжуулалтын судалгаанд хамруулсан аймгийн сонголт

Аймаг	Хохирлын Хэмжээний түвшин	Төсөлд хамрагдсан		Төсөл хэрэг-жүүлсэн гол байгууллага	Байга-лийн бүс	Ган, Зудын Давтамж
		Сум	Олго-сон мал			
Дундговь	Их (602,5мян.мал) (21.2 т.б төг)	10	234321	ЯБХ	Говь	Их
Завхан	Дунд (361.8 мян.мал) Зэрэг (13,6 т.б. төг)	8 11	27030	ЯБХ “Санкей”сонин	Ойт Хээр	Бага
Баянхонгор	Бага (146,4 мян.мал) (5,2 т.б. төг)	4 7	10848	ЯБХ “Санкей”сонин	Говь Хээр	Их
Хөвсгөл	Бага (51,5 мян.мал) (2,6 т.б. төг)	20	31539	ХААХОУ-ын сан, Английн түншлэлийн хөтөлбөр	Өндөр	Нэрвэг-Дээгүй

Ийнхүү говийн бүсэд байршилтай, ган зудын давталт ихтэй, зудад хамгийн их хохирсон Дундговь аймаг, говь хээрийн бүсэд байршилтай ган, зудын давталт ихтэй, олон жил дараалан малын хорогдолтой байсан Баянхонгор аймаг, ойт хээрийн бүсэд байршилтай сүүлийн жилүүдэд дараалан ган болсон Завхан аймаг, өндөр уулын бүсэд байршилтай, ган зуданд төдийлөн нэрвэгдээгүй (харин 2000 онд зуд болсон) Хөвсгөл аймгуудыг судалгааны обьект болгон сонгож авлаа.

Хүснэгт 2.2

Хохирлын түвшингийн судалгаа

Хохирлын түвшин тогтоох шалгуур үзүүлэлтүүд			Судалгаанд хамрагдсан аймгуудын хохирлын түвшин							
Хохирлын түвшин	Түвшинг тогтоох шалгуур		Дундговь		Завхан		Баянхонгор		Хөвсгөл	
	1[1]	2[2]	1	2	1	2	1	2	1	2
Бага	36.6-225.2	1.7-10.7					146.4	5.9	51.5	2.1
Дунд зэрэг	225.2-413.8	10.7-19.7			361.8	14.9				
Их	413.8-602.5	19.7-28.6	602.5	28.6						

1- Хорогдсон малын тоо, мянган толгойгоор 2- Оны эхний малын хорогдлын хувь

Хохирлын хэмжээний түвшинг хорогдсон малын тоог гол болгон, оны эхний малын хорогдлын хувийг харгалзан их, дунд зэрэг, бага гэсэн 3 зэрэглэлээр тогтоон ашигласан болно.

Судалгаанд хамрагдах сумдын сонгох

2.11. Судалгааны нэгжүүдийг сонгоход зорилтот болон санамсаргүй түүвэрлэлтийн аргыг хэрэглэв. Тухайлбал, аймаг, сумдыг зорилтот түүврийн аргаар сонгосон бөгөөд судалгаа авсан аймаг, сумдын удирдлагууд, мэргэжилтэнүүдээс тухайн үед ажлаа гүйцэтгэж байсан хүмүүсээс санамсаргүй байдлаар судалгаа авсан болно.

2.12. Сумдыг судалгаанд хамруулахдаа дараах шаардлагуудыг удирдлага болгосон болно. Үүнд:

- Судалгаанд хамрагдаагүй бусад сумдыг төлөөлөх чадвартай байх,
- Малжуулах арга хэмжээний онцлогийг илрүүлэх боломж бүрдүүлэх,
- Малжуулалтын явц, үр дүнгийн талаар аль болох олон хувилбар бүхий өрхийг судалгаанд хамруулах,
- Нийт өрхөөс аль болох олон өрхийг хамарсан байх.

2.13. Дээрх шаардлагуудыг удирдлага болгон судалгаа явуулах сумыг сонгох арга зүйн дагуу дараах үзүүлэлтээр зэрэгцүүлэлт хийсэн болно.

- Малжуулалтад хамрагдсан өрхийн тоо,
- Малжуулалтад зарцуулсан хөрөнгө,

- Нэг өрхөд ногдох санхүүжилтийн хэмжээ,
- Малжуулалтын дараах үр дүн,
- Малжуулалтыг хэрэгжүүлсэн онцлог.

2.14. Судалгааны дүн, аймгийн удирдлагын санал дүгнэлтээс үндэслэн Дундговь аймгаас Хулд, Дэлгэрхангай, Эрдэнэдалай, Сайнцагаан, Завхан аймгаас Идэр, Яруу, Эрдэнэхайрхан, Сантмаргац, Цэцэн-Уул, Баянхонгор аймгаас Гурванбулаг, Заг, Галуут, Баян-Овоо, Хөвсгөл аймгаас Хатгал, Түнэл, Их-Уул, Бүрэнтогтох гэсэн 17 сумдыг сонгон авч малжуулах төсөлд хамрагдсан ба хамрагдаагүй малчин өрх, баг сумын удирдах ажилтан, мэргэжилтнүүдээс холбогдох судалгаа авсан болно.

2.15. Тухайлбал, Дундговь аймгийн малжуулах төсөлд хамрагдсан нийт сумдаас судалгаанд хамрагдах сумдыг дараах байдлаар сонгожээ. (Хүснэгт 2.3)

Хүснэгтээс харахад, нэг өрхөд цөөн мал өгөх замаар олон өрхийг малжуулалтанд хамруулсан Хулд, малжуулалтанд хамгийн өргөн хамрагдсан (99 малчин өрх, 96 сая төгрөг) Эрдэнэдалай, малжуулах үйл ажиллагааны үр дүн хэвийн байгаа Сайнцагаан, малжуулалтаар олгосон мал их хорогдсон Дэлгэрхангай сумдыг сонгон судалгаанд хамруулсан байна.

Хүснэгт 2.3

Дундговь аймгийн судалгаанд хамруулах сумын сонголт

Сумын Нэр	Малжуулалтанд хамрагдсан		Нэг өрхөд ногдох санхүүжилт, сая төгрөг	Малын тооны өсөлт /малжуулалтын өмнөхөөс/	Малжуулалттай холбогдсон онцлог шинж
	өрхийн тоо	Санхүүжилт, сая төгрөг			
Дэлгэрцогт	35	20,0	0,57	- 22,8	
Дэрэн	20	12,0	0,60	40,8	
Гурвансайхан	50	40,0	0,80	56,6	
Өлзийт	33	32,0	0,97	11,0	
Луус	32	24,0	0,75	24,8	
Хулд	79	34,0	0,43	31,1	Нэг өрхөд цөөн мал өгөх замаар олон өрхийг хамруулсан.
Дэлгэрхангай	49	46,0	0,94	- 3,8	Малжуулалтын үр дүн хангалтгүй, малын тоо буурсан
Сайхан-Овоо	55	40,0	0,73	16,7	
Эрдэнэдалай	99	96,0	0,97	0,2	Малжуулалтад хамгийн өргөн хамрагдсан
Сайнцагаан	85	66,0	0,78	25,1	Хэвийн дунджийг харуулж байгаа
Дүн	537	410,0	0,76*	18.2*	

*- дундаж

Судалгаанд хамрагдах малчин өрхийн сонголт

2.16. Судалгаанд хамрагдах малчин өрхийг сонгохдоо малжуулалтанд хамрагдсан өрхүүдийг сумын удирдлага, малжуулах хөтөлбөрийг хариуцан ажиллаж буй мэргэжилтнүүдийн саналаар дээр дурдсан 3 ангилалд багтах өрхүүдийг зорилтот түүврийн аргаар сонгон судалсан. Малжуулалтанд хамрагдаагүй өрхүүдийг санамсаргүй түүврийн аргаар сонгосон. Мэдээлэл цуглуулах явцад зарим хүндрэл тохиолдож байв. Тухайлбал, Завхан аймгийн Сантмаргац суманд судалгаанд

хамрагдах өрхүүдийг сумын удирдлагатай зөвлөлдөн сонгоод сонгосон нэг өрхөд очихын тулд талдаа 120 км явах тохиолдол хүртэл байлаа.

Судалгааны төлөөлөх чадвар

2.17. Судалгааны түүврийн төлөөлөх чадварыг мэдээлэл цуглуулсан аймаг сумдын хувийн жингийн аргаар судалсан болно.

Хүснэгт 2.4

Судалгааны төлөөлөх чадвар

Төсөл хэрэгжүүлэгч	Аймаг			Сум		
	Хамрагдсан	Судалгаанд сонгосон	Хамрах хувь (%)	Хамрагдсан	Судалгаанд сонгосон	Хамрах хувь (%)
Ядуурлыг бууруулах хөтөлбөр	5	3	60.0	35	12	34.3
ХАА-г хөгжүүлэх олон улсын сан	2	1	50.0	35	4	11.4

Судалгаанаас үзвэл, ядуурлыг бууруулах хөтөлбөрт хамрагдсан 5 аймгийн 60%, 35 сумын 34,3% нь, ХАА-г хөгжүүлэх олон улсын сангийн 35 сумын 11,4% нь судалгаанд хамрагдсан байгаа нь судалгааны төлөөлөх чадвар нилээд өндөр байгааг харуулж байна. Мөн эдгээрээс гадна малжуулалтыг зохион байгуулсан бусад байгууллагууд, тухайлбал, Ерөнхийлөгчийн хөдөөг хөгжүүлэх сан, Английн түншлэлийн хөтөлбөр, Японы “Санкей” сонины газар, Английн хүүхдийг ивээх сангийн малжуулах хөтөлбөрт хамрагдсан аймаг, сумууд хамрагдсан юм.

ГУРАВДУГААР БҮЛЭГ: МАЛЖУУЛАЛТЫН ШАЛТГААН

3.1. Энэхүү бүлэгт Монголын малчдын нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдлыг судалсаны зэрэгцээ бэлчээрийн мал аж ахуйн онцлог, түүний давуу ба сул талуудыг тодорхойлон малжуулах арга хэмжээг явуулах болсон гол ба гол бус шалтгаануудыг тодруулсан. Мөн энэ бүлэгт Завхан аймгийн Идэр, Эрдэнэхайрхан сумын жишээгээр малчин өрхийн орлого, зарлагын тооцоог хийж 200-300 толгой малтай малчин өрхийн мөнгөн орлого нь зардлаа нөхөх боломжтой байгааг тогтоосон болно.

Монголын малчдын нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдал

3.2. 1990-ээд оноос Монгол улс зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэнээр сангийн аж ахуй, хөдөө аж ахуйн нэгдлийн мэдэлд байсан төрийн болон төржсөн хоршооллын өмчийг хувьчилж тэдний оронд хувийн мал бүхий малчин өрхүүд бий болсон билээ. Үндэсний статистикийн газрын судалгаанаас үзэхэд 2002 оны байдлаар улсын хэмжээнд бүгд 243234 малтай өрх байгаагийн 175911 өрх нь дан ганц малаар амьжиргаагаа залгуулдаг малчин өрх байгаа юм. Эдгээр малчин өрхүүдэд 389765 малчин ажиллаж байна. Малчдын тал илүү хувийг 16-35 насны залуучууд эзэлж байна. Хөдөөгийн малчин өрхүүд дэд бүтэц харьцангуй сул хөгжсөн хөдөө нутагт бие биенээсээ олон арван километрийн алсад таван төрлийн малаа бүс нутгийн онцлогт тохируулан эрхлэн амьдарсаар ирсэн түүхтэй билээ. Малчин өрхийн нийгэм ахуйн нөхцөл нийгмийн хөгжлийг даган өөрчлөгдсөөр байна. Тухайлбал, цахилгаан гэрэл, телевизор хэрэглэдэг, хувийн мотоцикл, автомашин, трактортой өрхийн тоо олширч байна. Мөн өмч хувьчлал явагдах үед амьжиргаа сайтай малчин өрхийн зарим хэсэг нь ирээдүйнхээ бизнест ашиглах зорилготой хөрөнгө хуримтлуулахын тулд хуучин нэгдэл, сангийн аж ахуйнг мэдэлд байсан хямд үнэтэй трактор, ачааны машин худалдан авах болсон юм.

Хүснэгт 3.1

Малчин өрхийн нийгэм эдийн засгийн зарим үзүүлэлтүүд (мян.өрх)

Үзүүлэлтүүд	1999	2000	2001	2002
Цахилгаан гэрэлтэй	25,7	20,4	24,8	24,1
Телевизортой	30,9	24,6	29,2	29,4
Бүх төрлийн автомашинтай	12,8	16,6	17,6	18,4
Трактортой	3,0	2,8	2,8	2,7
Мотоциклтэй	29,8	31,7	33,9	32,6

Малчин өрхийн нийгэм, ахуйн нөхцөлд гарч байгаа өөрчлөлтийг дээрх хүснэгтээр харуулав. (Хүснэгт 3.1) Хүснэгтээс харахад нийт малчин өрхийн 1.3 хувь нь цахилгаан хэрэглэдэг, 1.4 хувь нь телевизортой, 1.6 хувь нь автомашинтай байна. Эндээс үзэхэд малчин өрхийн ихэнх нь нийгэм, ахуйн наад захын хэрэгцээгээр хангагдаж чадаагүй байна.

3.3.Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний салбарт гарсан дэвшилттэй өөрчлөлт бүр нь өнөөдөр малчны хүүхдийг ерөнхий боовсролын сургуульд үнэ төлбөргүй сургах, сумын хүн эмнэлгээр үйлчүүлэх боломж олголоо. Малчин өрхүүд нь хөдөө аж ахуй дахь аж ахуйн нэгжийн анхдагч хэлбэр, мал аж ахуйн бүтээгдэхүүнийг голлон үйлдвэрлэгч болж улсын эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэх болов . Монголын малчин өрхүүд ашиг шим багатай нутгийн монгол мал эрхэлдэг учраас цөөн малтай малчин өрхүүдийн ихэнх нь амиа аргацаасан, хэрэглээний шинжтэй аж ахуй байна.

3.4. Монгол улсын үндэсний статистикийн газрын судалгаанаас үзэхэд 2002 оны байдпаар нийт малтай өрхийн 88 хувь нь буюу 203.8 мянган өрх 200-гаас доош малтай байна. 10-50 хүртэл малтай өрхийн тоо сүүлийн жилүүдэд өсч түүнээс дээш малтай өрхийн тоо буурах хандлагатай байна.

3.5. Хөдөө аж ахуйн их сургуулийн эдийн эасаг, бизнесийн сургууль дээр 2000-2002 онд хийгдсэн “Малчин өрхийн статус” нэртэй судалгааны төслийн төгсгөлийн тайланд 200-300 толгой малтай малчин өрхүүдийг зөвхөн өөрсдийн дотоодын хэрэгцээг хангадаг амиа аргацаасан түүнээс дээш малтай өрхийг бизнесийн шинжтэй гэж үзэж байна. Үүнийг батлах зорилгоор 300-гаас доош малтай малчин өрхүүдийн одоо байгаа малын тоо, түүний бүтэц, нэг малаас авах ашиг шимийн норматив дундаж хэмжээ, мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнэ, малчин өрхөөс авсан өрхийн хэрэглээ, мал аж ахуйн үйлдвэрлэлийн зардлын тухай тоо мэдээллийг ашиглан малчин өрхийн орлого, зардлыг тооцож үзэв.

Хүснэгт 3.2

Малчин өрхийн орлого, зардлын тооцоо

(Завхан аймгийн Идэр, Эрдэнэхайрхан сумын жишээн дээр)

Малын тоо, толгойгоор	50	100	150	200	300
Мал аж ахуйн нийт мөнгөн орлого, мян.төг	610.4	666.4	952.4	1263.7	1353.7
Малчин өрхийн нийт зардал, мян.төг	1049.4	1105.7	1169.8	1260.4	1329.3
Үүнээс :Мал аж ахуйн үйлдвэрлэлийн зардал, мян. төг	112.7	169.0	233.1	323.7	392.6
Ашиг, алдагдал, мян.төг	-439.0	-439.3	-217.4	+3.4	+24.4

Хүснэгтээс харахад, малчин өрхийн малын тоо 150 толгойгоос доош байхад мал аж ахуйгаас орох нийт мөнгөн орлого нь малчин өрхийн нийт хэрэглээ ба мал аж ахуйн үйлдвэрлэлийн зардлыг нөхөж чадахгүй байна. Харин 200-300 толгой малтай малчин өрхийн мал аж ахуйн нийт мөнгөн орлого нь зардлаа нөхөх боломжтой байгаа боловч ашиг багатай (3,4-24,4 мянган төгрөг) байна. Малчин өрхийн ниит зардалд 4 - 5 ам бүлтэй нэг малчин өрх дунджаар 936,7 мянган төгрөгийг өрхийн хэрэглээнд зарцуулахаар тооцсон болно.

3.6. Үүнээс үзвэл, судлаачдын 200-300 толгойгоос доош тооны малтай малчин өрхүүд амиа аргацаасан, хэрэглээний шинжтэй аж ахуй гэж үзэж байгаатай бидний тооцоо тохирч байна. Ингэж үзвэл манай улсын нийт малчин өрхийн 69,1 хувийг 100-гаас доош малтай өөрсдийн амьжиргаагаа ч залгуулах чадваргүй ядуу, нэн ядуу өрхүүд эзэлж байна. Иймд ядуу, нэн ядуу гэж тооцогдож байгаа малчин өрхийн амьжиргааг сайжруулах гол арга нь тэдний амьжиргааны гол хэрэгслэл

болох нэг өрхөд байх малын тоог өсгөх явдал гэдэг нь ойлгомжтой байна. Гэвч малын чанарыг сайжруулах, үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, малчдыг сургалтанд хамруулж, боловсрол, соёлын түвшинг дээшлүүлэх нь малчдын амьжиргааг сайжруулахад ихээхэн үүрэгтэй нь тодорхой юм.

Бэлчээрийн мал аж ахуйн онцлог, давуу ба сул талууд

3.7. Мал аж ахуй бол манай хөдөө аж ахуйн үндсэн салбарын нэг бөгөөд Монгол улсын үндэсний статитикийн газрын мэдээнээс үзэхэд 2002 оны байдлаар хөдөө аж ахуй нийт бүтээгдэхүүний 78.9 хувийг үйлдвэрлэж, хөнгөн, хүнсний аж үйлдвэрийн салбарын түүхий эдийн 60 орчим хувийг нийлүүлж, хүн амын хүнсний хангамжийн 70 гаруй хувийг хангаж байна. Манай улсад байгаль эдийн засгийн нөхцөлөөс болж тус орны янз бүрийн бүсэд мал аж ахуйг эрхлэн хөтлөх систем харилцан адилгүй хөгжсөөр ирсэн юм. Зах зээлийн эдийн засгийн харилццаа хөгжиж байгаа өнөө үед ч бэлчээрийн аж ахуй уламжлалт аж ахуй хэвээрээ хадгалагдсаар байна.

3.8. Монгол орны мал аж ахуйд ноёрхож байгаа бэлчээрийн маллагааны систем нь тус орны байгаль, газарзүйн .өвөрмөц нөхцөлтэй уялдан тогтсон мал маллагааны арга, малчдын олон жилийн хөдөлмөрийн дадал заншил болсон зүйл учир бэлчээрийн мал аж ахуйг цаашид боловсронгуй болгох асуудлыг авч үзэхдээ дээрх онцлогийг харгалзан үзэх хэрэгтэй. Бэлчээрийг зөв ашиглах нь бэлчээрийн мал аж ахуйн бүтээмж, үр ашгийг дээшлүүлэх чухал нөхцлийн нэг мөн.

3.9. Одоо манай орны хөдөө аж ахуйн нийт эдэлбэр газрын 90 гаруй хувь нь байгалийн хадлан, бэлчээр байна. Манай байгалийн бэлчээрийн өвс ногоо нь витамин, эрдэс бодисоор баялаг, малын өсөлт хөгжилтийг түргэсгэж, ашиг шимийг нэмэгдүүлэх чанар бүхий чухал бодисыг агуулж байдгаараа сайн чанарын хямд тэжээлд тооцогддог. Түүнчлэн манай ихэнх бэлчээрийн га-ийн ургац их биш боловч жирийн бэлчээрийн нэг кг хуурай бодис нь шинж чанар, биологийнхоо хувьд хүчит тэжээлтэй тэнцдэг /"Эдийн засаг, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн удирдлагын үндэс" УБ.1977 он/.

3.10. Бэлчээрт ийнхүү сайн тал байгаа боловч ургац нь тачирхан, ялангуяа өвөл, хаврын улиралд ургамлын шимт чанар буурдаг учраас бэлчээрийн малд ууараг, дутагдах явдал гардаг бөгөөд бэлчээрийн ургамлын ургацын хэмжээ жил жилийн цаг агаарын байдлаас хамаарч ерөнхийдөө тогтвортой биш байдаг зэрэг дутагдалтай талууд байдаг юм.

3.11. Түүнээс гадна улс орон зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж нийт мал сүргийн 97 орчим хувь нь малчдад хувьчлагдан очсон учир бэлчээрийн мал аж ахуйн хөгжилд нилээд эерэг, сөрөг өөрчлөлтүүд гарлаа. Тухайлбал, бэлчээр хадлангийн талбай, уст цэгийг малчдын эзэмшилд өгөөгүй байгаагаас малчдын дунд хадлан бэлчээрийн талаар маргаан гарч тэжээл бэлтгэхэд нь хүндрэл учруулж байгаагийн зэрэгцээ бэлчээр талхлагдах гол шалтгаан болж байна. Үүний зэрэгцээ бэлчээрийг малчид эзэмшихгүй байгаагаас бэлчээр эзэнгүйдэж, түүнийг сайжруулах, ургацыг нэмэгдүүлэх талаар тодорхой ажил хийх боломж бүрдэхгүй байна. Дээрхи байдал нь бэлчээрийн мал аж ахуйд сөргөөр нөлөөлж байгаа өөрчлөлтүүдийн нэг юм. 1998 онд явуулсан бэлчээрийн доройтлын судалгаагаар /"Монгол дахь ядуурлыг бууруулах стратеги" илтгэл НҮБХХ УБ 2001 он/ газар нутгийн зөвхөн 1,7% нь л огт доройтолд ороогүй байгааг тогтоожээ.

3.12. Иймд бэлчээрийн мал аж ахуйн талаар судалгаа хийсэн эрдэмтэд (1999-2000 оны зудын сургамж судалгааны тайлан төсөл. МОН/00/302. УЦУ, орчины шинжилгээний газар. /ЖЭМР, ХХК, УБ 2000 он/ 261-264-р тал)-ийн бодол дүгнэлттэй санал нэг байна.

3.13. Тухайлбал, бэлчээрийн мал аж ахуйн үйлдвэрлэлд гарсан давуу талыг бэхжүүлэх, сул талын нөлөөллийг бууруулах, мал аж ахуйг тогтвортой хөгжүүлэх стратегийн үзэл баримтлалыг төслийн менежментийн шинжлэх ухааны үүднээс цоо шинээр авч үзэх шаардлага урган гарч байгаа юм.

3.14. Дээрх төслийн тайлан, бэлчээрийн мал аж ахуйн талаар өмнө бичигдсэн бүтээлүүдийг үндэслэн бэлчээрийн мал аж ахуйн давуу ба сул талыг дараах байдлаар нэгтгэн харуулав.

Хүснэгт 3.3

Бэлчээрийн мал аж ахуйн давуу ба сул талууд

Давуу тал	**Сул тал**
• Монголын газарзүйн онцлог, байгаль цаг уурын эрс тэс нөхцөлд сайн дасан зохицсон. Малыг жилийн турш бэлчээрээр малладаг учир хөрөнгө оруулалт их шаарддаггүй, энгийн байр, хашаа хороо ашигладаг. • Хямд өртөгтэй бэлчээрийн өвс тэжээл хэрэглэдэг. • Малчид нь тухайн бүс нутгийн онцлогт тохируулан мал маллах өвөрмөц арга барил, туршлага эзэмшсэн. • Монгол малын үржүүлэг нь бэлчээрийн маллагааны өвөрмөц нөхцөлд зохицон дассан, нарийн нягт ажиллагаа шаарддаггүй онцлогтой. • Малчид байгалийн цэвэр агаар “хүн-мал-бэлчээр”-ийн харилцан сайн зохицсон шүтэлцээнд амьдардаг. • Малчид мал хариулах нутаг усаа сонгох, тэжээл, ашиг шимийг нь авах, тэдгээрийг борлуулах талаар өөрсдөө шийдвэр гаргах бүрэн эрх эдэлдэг. Малчин өрхийн хөдөлмөрийн чадвартай бүх хүмүүс мал аж ахуйн үйлдвэрлэлд оролцохоос гадна тэтгэвэрт гарсан өндөр настай өтгөс буурлууд болон сургуулийн өмнөх ба сургуулийн насны хүүхдүүд оролцдог. • Экологийн цэвэр бүтээгдэхүүн үйлдэрлэдэг.	• Эрсдэл ихтэй, байгаль цаг уурын хараат байдалд оршдог. • Орчин үеийн үйлдвэрлэлийн тэргүүний техник, технологи нэвтрүүлэхэд бэрхшээлтэй. • Цаг агаарын бэрхшээлийн үед өвс хадлан, нэмэгдэл тэжээлээр хангах я зайлшгүй шаардлагатай. Энэ нөхцөлд зардал харьцангуй их гардаг. • Дэлхийн бусад орон бүс нутгийн малчид, тариаланчдын шилдэг, өвөрмөц арга барилыг хэрэглэх боломж харьцангуй хязгаарлагдмал. • Ашиг шим, бүтээмж багатай ихэнх тохиолдолд өөрийнхөө дотоод хэрэгцээг хангахад чиглэгдсэн, амиа аргацаасан хэв шинжийн аж ахуй гэж заримдаа нэрлэдэг. • Малчид байгалийн хатуу ширүүн нөхцөлд амьдардаг, нүүдлийн соёл иргэншилийн сул талыг агуулсан хэв шинжтэй. • Шийдвэр гаргахдаа ихэвчлэн өнгөрсөн үеийн туршлагад тулгуурладаг тул шийдвэр гаргах орчин үеийн арга зүйг бага эзэмшсэн байдаг. • Зах зээлийн шаардлагад нийцсэн, эрүүл ахуй, ариун цэврийн бүх шаардлаг хангасан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэж, борлуулах боломж харьцангуй сул.

Малжуулах арга хэмжээг явуулах болсон шалтгаан

3.15. Хөдөө аж ахуйн салбарын хувьчлалын үр дүнд мал малчдад очсоноор, мал аж ахуй эрхлэж байсан улс, хоршооллын том аж ахуйн оронд гол төлөв амиа аргацаасан шинжтэй жижиг өрхийн аж ахуйнууд бий болсон юм. Эдгээр өрхийн аж ахуйн үйл ажиллагаа нь урьдаас тодорхойлсон зорилго, зорилт, төлөвлөгөө тооцоогүй явагдаж, зах зээлийн нөхцөлд аж ахуй эрхлэх арга, туршлага дутагдалтай байсны улмаас хөдөөгийн ядуурлын түвшин цөөхөн жилийн дотор асар хурдтай нэмэгдэхэд хүргэжээ.

3.16. Үүний зэрэгцээ хөдөө аж ахуйн нэгдэл, сангийн аж ахуйн мал сүргийг малчдад хувьчлахдаа сүргийн бүтэц, малын ашиг шимт чанарыг нь харгалзахгүйгээр тоо толгойн хувьд ихээхэн ялгаатай олгосон нь малчдыг хөрөнгө чинээний хувьд ялгаатай болоход хүргэсэн юм. 1990 оны эхнээс дунд үе хүртэл улс орон “шилжилтийн” хэмээх үеийг даван туулж улсын эдийн засаг бүхэлдээ уналтын шатанд орсныг дагалдан нийгмийн янз бүрийн давхарга, түүний дотор хөдөөгийн малчин өрхийн ядуурал нэмэгдсэн юм.

3.17. Мөн хот суурин (ялангуяа сумын төвд) газарт шилжилтийн үеийн бэрхшээлтэй холбоотойгоор үйлдвэрлэл унаж, ажлын байр багассанаар мал маллаж амьжиргаагаа авч явахаас өөр аргагүй “шинэ үеийн” малчдын тоог эрс нэмэгдүүлжээ. 1999 оны эцэс гэхэд малчин өрхийн тоо 189.9 мянгад хүрч малын тоо 1990 онд 25.8 сая байснаа 1999 онд 33.5 сая болтлоо өссөн билээ. Гэвч сүүлийн жилүүдэд дараалан болсон ган зудын уршгаар малын тоо ихээхэн хорогдож 2002 оны байдлаар 23.9 малтай болсоны зэрэгцээ малын үржил, селекцийн ажил, мал заазлалт зэрэг арга хэмжээг орхигдуулснаар чанар муутай малын тоо эрс нэмэгджээ.

Шигтгээ 1



Зураг 3.1. Малжуулалтын шалтгаан

3.18. Малыг хувьчилсны дараа улсын нийт малын тоо нь ерөнхий дүнгээрээ өсч байсан боловч нэг өрхөд ноогдох малын тоо төдийлөн өсөөгүй юм. Статистикийн мэдээгээр 2002 оны байдлаар нийт малчин өрхийн 88 хувь нь 200-гаас доош малтай, 65 хувь нь 100-гаас доош малтай болжээ. Хэт жижиг өрхүүд өвс тэжээл бэлтгэх, нүүдэл, тээвэр хийх, мал эмнэлгийн болон бусад үйлчилгээ авах, бүтээгдэхүүнээ борлуулах зах зээлд хүрэх, байгалийн болон үнийн эрсдэлийг даван туулахад хүчин

мөхөсдөж байгаа бөгөөд малчид ядууран хөдөөд нэн эмзэг давхаргыг үүсгээд байна.

Ган зудын бэрхшээл

3.19. Сүүлийн жилүүдэд ихэнх нутгаар агаарын температур олон жилийн дундажаас 1-6 градусаар дулаан болж, хур бороотой өдөр цөөрөн, гангийн аюул нүүрлэх болжээ. Үүний улмаас жижиг гол, горхи ширгэж мал ундны усаар гачигдах, халуун хуурай нөхцөлийн улмаас хортон шавьж ихсэх , Архангай, Хөвсгөл, Завхан аймагт бэлчээр их хэмжээгээр түймэрт шатаж өвсний нөөц улам багассан зэрэг нь мал аж ахуйн үйлдвэрлэлд сөргөөр нөлөөлсөн байна.

3.20. Судлаач Г.Бизъяагийн тооцоолсноор 1921 оноос хойш манай оронд 29 удаа их, бага зуд болжээ. Эдгээр зудуудын хамарсан нутаг дэвсгэр, үхэж үрэгдсэн малын тоо, цасны зузаан, хүйтний эрч зэрэг бүх л үзүүлэлтүүдээрээ ялгаатай боловч 1928, 1944, 1967, 1976 онуудын зуд онцгой хүнд байжээ. Тухайлбал 1944-1945 оны өвлийн зуданд нийт 9 сая орчим мал хорогдож, 1976-1977 оны зуд манай орны нийт нутаг дэвсгэрийн 90%-ийг хамарч бараг 6 сарын туршид үргэлжилсэн байна. 1993 оны тахиа жилийн зуд Завхан, Баянхонгор, Говь-Алтай аймгийн 30 сумын нутаг дэвсгэрийг хамарч 2,8 сая мал, 1996-1997 оны зуд 11 аймгийн 39 сумыг хамран 1,1 сая толгой мал хорогдож байжээ.

Хүснэгт 3.4

Зудын хохирол, сүүлийн жилүүдийн байдлаар

Үзүүлэлтүүд	1999-2000	2000-2001
Хамарсан нутаг дэвсгэрийн хэмжээ,	13 аймаг 157 сум	8 аймаг 114 сум
Хорогдсон малын тоо (сая толгой)	3.4	4.8
Малын үнэлгээ (тэр бум төгрөгөөр)	91.7	129.4
Хамгийн олон мал хорогдсон аймгуудын хорогдсон малын тоо (мянган толгой) Дундговь Өвөрхангай Завхан Говь-Алтай	 602.5 516.4 361.8 36.6	 557.8 222.8 90.5 687.2

3.21. 1999-2000 оны өвлийн зуд нийт нутгийн 70%-ийг хамарч, 3,4 сая мал хорогдсон бөгөөд үүний уршигаар 2,3 мянган өрх хотоо харлуулж малаа баржээ. 2000-2001 зуданд 4,2 сая том мал хорогджээ.

3.22. Сүүлийн жилүүдэд гарсан байгаль, цаг агаарын бэрхшээл малчин өрхийн амьжиргаанд ноцтой нөлөөлж, өмнө нь ядуу болон нэн ядуу, байсан өрхүүдийн аж байдлыг нь улам доройтуулсан байна. 1999-2002 оны зудад 13 аймгийн 157 сум нэрвэгдэж, 11 сая мал хорогдож, нийт 12000 өрх малгүй болж амьжиргаанаасаа салжээ.

Малчдын ядуурал

3.23. Мал сүрэг хувьчлагдсанаар мал аж ахуйд ажлын байр их хэмжээгээр нэмэгдсэн боловч цөөн малтай малчин өрхийн ихэнх нь ядуу болон нэн ядуу

өрхүүдэд тооцогдож, мал аж ахуйгаараа амьжиргаагаа залгуулж чадахгүй байгаа төдийгүй хүн амын өсөн нэмэгдэж буй хүнсний хэрэгцээ, үндэсний үйлдвэрлэлийн түүхий эдийн бэлтгэн нийлүүлэлтэнд дорвитой хувь нэмэр үзүүлж чадахгүй байгаа юм. Үүний зэрэгцээ байгалийн сөрөг үзэгдлийн давтамж ихэссэнтэй холбоотойгоор амьдралын баталгаагаа алдсан малчин өрхийн тоо олширч хөдөөд ажилгүйдэл, ядуурал ихэссээр байна.

Байгалийн нөөцийн хомсдол

3.24. Зудын хор хохирлын зэрэгцээгээр дэлхийн цаг агаарын ерөнхий өөрчлөлтөөр нөхцөлдсөн хуурайшилтаас үүдэлтэй бэлчээр, усны хомсдол, төвлөрсөн хот, суурин, зах зээлийн ойролцоох аймаг, сумуудын нутаг дахь бэлчээрийн даац буурсан зэрэг нь малын хорогдолд нөлөөлж хөдөөгийн хүн амын ядуурлыг нэмэгдүүлэх, амьжиргааны түвшинг бууруулах нэмэлт шалтгаан болсон байна.

3.25. Судлаачдын тогтоосоноор манай улсын бэлчээрийн ашиглаж болох талбай 127 сая га бөгөөд бараг тэн хагас нь усны хангамжийн муугаас шалтгаалж ашиглагдахгүй буюу дутуу хагас ашиглагдаж байна. Мөн 5,1 сая га бэлчээр ой хээрийн түймэрт шатаж, 2,0 сая га-д үлийн цагаан огтоно тархаж, 6000 га талбай царцаанд идэгдсэн байна.Бэлчээр бол Монгол улсын эдийн засагт бараг тэн хагас нь шууд ба шууд бусаар үр шимийг нь ашиглан хүртэж байдаг байгалийн үнэт баялаг, нөөц юм.

Бэлчээрийн даацын бууралт

3.26. Сүүлийн 70 жилийн дотор малын тоо 50 орчим хувиар өссөн байхад бэлчээрийн талбай 20 гаруй хувиар багасч 1 малд 1980 онд 2,4 га хөдөө аж ахуйн эдэлбэр газар ногдож байсан бол одоо 1,5 га хүрэхгүй болсон. Газар зүйн тоон мэдээллийн системд тулгуурлан явуулсан судалгаагаар манай орны бэлчээрийн 78,3 хувь нь дунд ба хүчтэй талхдалд орсон гэж тооцжээ. Судалгаанаас үзэхэд сүүлийн 40 гаруй жилийн хугацаанд их талхлагдсан бэлчээр (нийт бэлчээрийн 21%)-ийн ургац 5 дахин буурч ургамлын зүйлийн тоо 6 дахин цөөрсөн байна.

3.27. Манай орны нийт бэлчээрийн талбайн даацыг хонин толгойд шилжүүлсэнээр 62,5 сая мал бэлчээрлүүлэх даацтай гэж тооцоолдог бөгөөд бэлчээрийн даац хэтрэлт нь бэлчээрийн хомсдолын үндсэн шалтгаан гэж үзэж байна. Төв суурин газрын орчим дах бэлчээрийн даац хэтэрч талхлагдаж байгаа бол дэд бүтцээс алслагдмал газрын бэлчээр зохих түвшинд ашиглагдахгүй байна.

Шигтгээ 2

“Газрын тухай” хуульд хүн бүр хүссэн бэлчээрээ үнэ төлбөргүйгээр ашиглах эрхтэй буюу бэлчээр нь нийтэд нээлттэй өмч хэмээн тодорхойлсон нь үр шимтэй бэлчээрийн даацыг хэтрэхэд хүргэсэн нэг шалтгаан болсон.

Зах зээлийн арга ухаан дутагдах

3.28. Зах зээлийн нөхцөлд ажиллах чадвартай мал аж ахуйг дэмжих үйлчилгээний болон худалдаа бэлтгэлийн тогтолцоог орлох хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний борлуулалтын ба маркетингийн тогтолцоо бий болоогүй байхад малыг

хувьчилсанаар үйлдвэрлэлийн, үнийн, борлууллтын болон санхүүгийн бүхий л эрсдэлийг шинээр бий болсон зах зээлийн нөхцөлд аж ахуй эрхлэх ямарч туршлагагүй өрхийн жижиг аж ахуй дангаараа үүрэх болсон юм. Гэтэл манай диилэнхи малчдын зах зээлийн шинэ нөхцөлд аж ахуйэрхлэх, бизнесийн үйл ажиллагаа явуулах дадлага, туршлага хомс байсан нь малчин өрхийн амьдралын түвшин доройтоход хүргэсэн нэг гол хүчин зүйл болжээ.

3.29. Хөдөө аж ахуй үйлдвэрлэлийг амжилттай хөгжүүлэхэд үндсэн салбарын зэрэгцээгээр үйлдвэрлэлийн бус хүрээний салбарын хөгжил чухал үүрэгтэй байдаг. Харин манай улсад өмч хувьчлал явагдсаны дараа үйлдвэрлэлийн дэд бүтцэд чухал нөлөөтэй мал эмнэлэг, үржлийн салбарыг 1997 онд хувьчилсан боловч тухайн салбарын үйлчилгээ нь малчдад бүрэн хүрч чадахгүй байснаас олон мал хорогдоход хүрсэн юм. Ийнхүү зах зээлийн нөхцөлд зохицсон мал эмнэлэг, үржлийн алба, зам, тээвэр, харилцаа холбоо үйлчилгээний салбаруудыг хөгжүүлэх асуудал өнөөдөр ч тулгамдсан асуудал хэвээрээ байна.

3.30. Мөн зах зээлийн шинэ нөхцөлд зохицон ажиллах чадвар шинэ тутам хөрөнгө малтай болсон малчин өрхүүдэд дутагдаж тэд мал аж ахуйн бүтээгдэхүүнийг борлуулах, аж ахуйг эрхлэн хөтлөх талаар мэдлэг хомстой байсны улмаас мал хөрөнгийг ихээхэн хэмжээгээр үрэн таран хийсэн нь малгүй өрхүүдийг бий болгож хөдөөд ажилгүйдэл, ядуурал нэмэгдэх бас нэг шалтгаан болсон юм.

3.31. Ингэж малаа олноор хорогдуулсан малчид мал худалдан авах мөнгөгүй, барьцааны хөрөнгөгүйн улмаас банкнаас зээл авч чадахгүй болсон нь төрөөс тэдгээрийн амьжиргааг сайжруулах асуудалд анхаарал тавьж малжуулах замаар зохих тусламж дэмжлэг үзүүлэхийг шаардах болсон нь малжуулах гол шалтгаан болсон байна.

3.32. Малжуулах арга хэмжээ авах болсон шалтгааныг тогтоох зорилгоор аймаг сумын удирдах ажилтан малчдаас судалгаа авсан юм.

Хүснэгт 3.5

Малжуулах болсон шалтгаан

а. Удирдах ажилтан

Малжуулах шалтгаан	Тоо	Хувь
Ган зудад мал их хорогдсон	33	37.1
Байгалийн гэнэтийн аюулд нэрвэгдсэн	9	10.1
Малын өвчин гарсан	0	0.0
Огт малгүй ба цөөн малтай айлын тоо олширсон	19	21.3
Ажилгүйдлийг багасгах шаардлага гарсан	11	12.4
Малчдыг дэмжих засгийн газрын бодлого	17	19.1
Нийт дүнгээр	89	100.0

Орон нутгийн удирдах ажилтнуудаас авсан анкетын судалгаанаас үзэхэд, малжуулах арга хэмжээ авсан үндсэн шалтгааныг ган зудад малаа их хорогдуулсан (37.1%), ган зудын улмаас огт малгүй ба цөөн малтай айлын тоо олширсон (21.3%), малчдаа дэмжих Засгийн Газрын бодлого байсан (19.1%) гэж үзсэн байна.

б. Малчид

Малжуулалт явуулсан шалтгаан, малчдын үзэж байгаагаар (саналын хувийн жингээр)	Малжуулалтанд хамрагдсан			Малжуулалтанд хамрагдаагүй өрх
	Малаа өсгөсөн өрх	Малын тоо хэвийн байгаа	Хорогдуулсан огт малгүй болсон	
Ган, зудад малаа хорогдуулсан	37.2	37.7	28.6	37.9
Угаасаа цөөн малтай байсан	36.7	37.7	79.2	9.2
Амьдрал нэн ядуу гэж тооцогдсон учраас	23.8	20.8	49.1	24.6

Харин малжууллтанд хамрагдсан малчин өрхийн дийлэнхи хэсэг нь ган зудад малаа хорогдуулсан [28.6-37.7],уулаасаа цөөн малтай байсан [36.7-79.2], амьдрал нэн ядуу гэж тооцогдсон [20.8-49.1] гэж хариулжээ. Малжуулалтад хамрагдаагүй өрхүүд ган зудад малаа хорогдуулж амьдрал ядуу өрхийн тоо нэмэгдсэнийг малжуулалтын шалтгаан гэж үзэж байна. Малжуулалтад хамрагдаж мал аваад малаа хорогдуулсан, эсвэл огт малгүй болсон өрхүүдийн бодлоор малжуулалтын гол шалтгаан нь уулаасаа цөөн малтай (79.2%), амьдрал нэн ядуу гэж тооцогдсон (49.1%) байна.

3.33. Энэ бүхнээс үзэхэд ган, зудад малаа хорогдуулж уулаасаа цөөн малтай малчин өрхүүдийн амьдрал доройтож цөөн малтай ба огт малгүй болсон малчин өрхийн тоо олширсон тул Засгийн газраас малчдаа дэмжих зорилгоор уг арга хэмжээг зохион байгуулжээ гэж дүгнэж байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: МАЛЖУУЛАХ ҮЙЛ ЯВЦ

4.1. Энэ бүлэгт малжуулах арга хэмжээг зохион байгуулсан байгууллага, тэдгээрийн малжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлсэн онцлог, малчин айл өрхийг сонгосон шалгуур, малжуулалтыг зохион байгуулсан арга хэлбэрийг судлан, уг арга хэмжээнд хамрагдсан аймаг, сум, өрхүүд, судалгааны обьект болох аймгуудад хэрэгжүүлсэн малжуулах үйл явцын талаархи мэдээллүүдийг эмхтгэн тусгасан болно. Мөн судалгаанд хамрагдсан малчин өрхүүдийн болон удирдлагаас авсан санал асуулгад үндэслэн малжуулалтанд хамруулах малчин өрхүүдийг сонгосон шалгуур ба малжуулалтанд аймаг сум багийн удирдлагын гүйцэтгэсэн үүргийг тодорхойлсон.

Малжуулах арга хэмжээнд хамрагдсан аймаг сум, өрх, малын тоо

4.2. Малжуулалт нь байгалийн гамшиг, малын өвчин, зэрэг давтагдашгүй эрсдэлийн улмаас мал, хөрөнгөө алдсан өрх, хувь хүнд зээл, барьцааны журмаар хөрөнгө олгож амьжиргаа болон бизнесийн үйл ажиллагаанд нь бий болсон хүндрэлээс гаргахад нь туслах чиглэлтэй арга хэмжээ юм. Монголд малжуулалт нь саяхан бий болсон цоо шинэ зүйл биш юм. Түүхийн үүднээс авч үзвэл, баячуул, жасын мал сүрэг маллагчид нь малч ухаантай, хөдөлмөрч нэгэнд нь хэдэн мал тасалж хөлсөөр маллуулан үр төлөөс нь өмчинд үлдээх замаар малжуулдаг байсан байжээ. Харин Монгол улс зах зээлийн харилцаанд шилжсэнээс хойш хөдөөд ядуурал нэмэгдэх хандлагатай болсоныг харгалзан олон улсын зээлийн хөрөнгөөр ядуу малчдыг малжуулах хөтөлбөр анх удаа 1990-ээд оны дундаас эхэлсэн ажээ. Малжуулах үйл ажиллагааг манай оронд 1996 оноос Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн зээлийн хөрөнгөөр Архангай аймагт эхэлсэн хөтөлбөр анхдагч нь байсан бөгөөд өнөөдрийн байдлаар давхардсан тоогоор нийт 17 аймгийн 114 сум, 4567 малчин өрх малжуулах хөтөлбөрт хамрагдаад байна.

Хүснэгт 4.1

Малжуулах арга хэмжээг зохион байгуулсан байгууллага, хамрагдсан аймаг, сум, өрхийн тоо

	Аймгийн нэр	Малжуулсан он	Хамрагдсан сум	Хамрагдсан өрх	Олгосон малын тоо	Нийт санхүүжилт /сая.төг/
Ядуурлыг бууруулах хөтөлбөр	Дундговь	2000	10	537	23432	442.21*
	Өвөрхангай	2000	8	377	17914	333.20*
	Баянхонгор	2000	4	172	10848	106.08*
	Завхан	2000	8	378	27030	254.80*
	Увс	2000	5	198	15826	158.71*
	Дүн		35	1662	95050	1295.00*
ХАА-г хөгжүүлэх олон улсын сан	Хөвсгөл	2000	11	442	13539	233.7
		2001	20	506	18000	337.0
	Архангай	2000	15	916	22780	493.8
		2001	3	213	6595	149.4
	Дүн		35	2077	60914	1213.9
Дэлхий зөн	Булган	2000	6	70	1995	64.2
		2001	6	50	1500	55.0
	Дүн		6	120	3495	119.2
”Санкей”сонин	Завхан	2000	11	188	11855	145.0
	Баянхонгор	2000	7	134	9427	117.3
	Дүн		18	322	21282	262.3
Английн түншлэлийн хөтөлбөр	БХ,Дорнод БӨ,ХӨ,Увс,Сү	1997	20	473	11225	119.0
Ерөнхийлөгчийн хөдөөг дэмжих сан	Завхан	2000	1	10	724	10.0
Нийт дүн			115	4664	192690	1724.4 1295.0*

*- мянган ам долларaар

Зураг 4.1

МАЛЖУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНД ХАМРАГДСАН АЙМГУУД



СУДАЛГААНД ХАМРАГДСАН АЙМГУУД

Зураг 4.2



ТАНИХ ТЭМДЭГ

- Аймгийн төв
- Хот
- Улсын хил
- Судалгаанд хамрагдаагүй аймаг
- Судалгаанд хамрагдсан аймаг

М 1:10 000 000

Судалгаанд хамрагдсан аймаг сумдын нэрс		
№	Аймаг	Сум
1	Завхан	Цэцэн-уул, Сант маргад, Яруу, Идэр, Эрдэнэхайрхан
2	Баянхонгор	Гурван булаг, Заг, Галуут, Баян-Овоо,
3	Хөвсгөл	Хатгал, Түнэл, Их-Уул, Бүрэнтогтох,
4	Дундговь	Хулд, Дэлгэрхангай, Эрдэнэдалай, Сайнцагаан

Судалгаанд хамрагдсан аймгуудын малжуулах үйл явц

4.3. Судалгаанд хамрагдсан аймгуудаас Хөвсгөл аймагт Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангаас, Завхан, Баянхонгор, Дундговь аймагт Ядуурлыг бууруулах хөтөлбөрөөс малжуулсан бөгөөд аймаг бүрт явагдсан малжуулалт нь хэрэгжүүлсэн байгууллага, хариуцан ажиллаж байсан ажилтнуудын ажлын арга барил, аймгуудын байгаль, цаг уурын нөхцөл зэргээс шатгаалан өөр өөрийн онцлогтой байлаа.

Дундговь аймагт хэрэгжсэн малжуулах арга хэмжээний тойм

4.4. 1999-2000 оны зудад Дундговь аймаг малаа ихээр хорогдуулж олон малчин өрхийн амьжиргааны эх үүсвэр алдагдсан нь малжуулах арга хэмжээг хэрэгжүүлэх үндсэн шалтгаан болсон байна. Тус аймагт 2000 онд Дэлхийн банкны зээлээр зудад хүчтэй нэрвэгдсэн 10 сумын 537 өрхийг малжуулахад 410,0 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан байна. Энэ арга хэмжээний хүрээнд нийт 25268 малыг 5 жилийн хугацаатай зээлийн хэлбэрээр олгосон бөгөөд 527 өрхийн нийт 2588 хүн амыг хамарчээ.

Хүснэгт 4.2

Дундговь аймгаас малжуулах төсөлд хамрагдсан байдал

Сум	Өрх	Ам бүл	Малын төрөл					
			Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Дэлгэрцогт	35	172	1329		3	9	858	459
Дэрэн	20	105	878		7	31	580	260
Гурвансайхан	50	247	2531	1	46	7	1575	902
Өлзийт	33	173	1710				874	836
Луус	32	178	1330		10		787	533
Хулд	79	363	2046		6		892	1148
Дэлгэрхангай	49	222	2602		12		1414	1176
Сайхан-Овоо	55	227	2415		6		1305	1104
Эрдэнэдалай	99	494	6245		84	94	4003	2064
Сайнцагаан	85	407	4182		19	20	2787	1356
Дүн	537	2588	25268	1	193	161	15075	9838

4.5. Малжуулах төслөөр олгосон малын дотор эр сувай мал 7,6 хувь, эх мал 84,3 хувь, төл 8,1 хувийг тус тус эзэлж байна.

4.6. Дэлхийн банкны зээлээр санхүүжүүлсэн малжуулах арга хэмжээнд нийт өрхийн 4.3 хувийг малгүй өрх, 9.3 хувийг 10 хүртэл малтай өрх, 55.5 хувийг 11-50 толгой малтай өрх, 22,7 хувийг 51-100 толгой малтай өрх, 8,2 хувийг 100-аас дээш малтай өрхөд олгосон байна.

Хүснэгт 4.3

Малжуулалтанд хамрагдсан өрхийн малжуулалтанд хамрагдах үеийн малын тоо, өрхийн бүтцээр

Сум	Бүгд	Үүнээс малын тооны ялгаагаар				
		Малгүй	10 хүртэл	11-50	51-100	100-аас дээш
Дэлгэрцогт	100	2.9	2.,0	71.4	5.7	
Дэрэн	100	15.0	5.0	60.0	15.0	5.0
Гурвансайхан	100			56.0	44.0	
Өлзийт	100	9.0	6.1	78.8	6.1	
Луус	100	3.1	3.1	81.3	12.5	
Хулд	100	1.3	2.5	35.4	48.1	12.7
Дэлгэрхангай	100		18.4	71.4	10.2	
Сайхан-Овоо	100	7.3	9.1	72.7	10.9	
Эрдэнэдалай	100	3.0	5.0	20.3	38.4	33.3
Сайнцагаан	100	8.2	2.1	66.3	23.4	
Дүн	100	4.3	7.1	61.3	21.4	5.1

4.7. Судалгаанаас үзвэл, ихэнх сумд малгүй , цөөн малтай өрхийг малжуулах арга хэмжээнд хамруулахыг эрмэлзсэн боловч Хулд, Эрдэнэдалай, Гурвансайхан сумдаас олон малтай нэлээд өрх малжуулах арга хэмжээнд хамрагдсан байлаа.

4.8. Малжуулах арга хэмжээг Дундговь аймагт өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих төслөөс зохион байгуулан явуулсан байна. Уг арга хэмжээг хэрэгжүүлэх үед түр ажилтнууд ажиллуулсан бөгөөд одоо сум бүрд малжуулах ажлын байдлыг сумын албан хаагчдын нэг нь ажил хавсрах замаар хариуцаж байна. Малжуулах арга хэмжээг дээрээс боловсруулж ирүүлсэн заавар, аргачлалын дагуу явуулжээ. Аймгийн ядуурлыг бууруулах зөвлөл (хуучин нэрээр) худалдан авах малын дээд үнийг тогтоох, малжуулах арга хэмжээний сургалт явуулах гэсэн хоёр үүрэгтэй оролцсон байна. Малжуулах ажил тухайн үедээ ямар ч зөрчил, асуудалгүй явагдаж өнгөрсөн байна. Харин малжуулах арга хэмжээний тайлан, малжуулалтын үр дүнгийн мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргах, хүргэх талаар зарим алдаа дутагдал гарч байсан байна.

4.9. Малжуулах төвлөрсөн арга хэмжээний зэрэгцээгээр зарим сумдад малжуулалтын өөр хэлбэрүүдийг хэрэглэсэн байна. Жишээ нь: Эрдэнэдалай сумын мянгат малчин Сампил өөрийн хамаатан садны 3 өрхөд мал өгөхийн хамт сүүлийн 3 жил дагуулан ажиллуулж өгсөн малыг нь өсгүүлж чадсан байна. Хулд сумын мянгат малчин Төмөрчулуун хамаатан садны хэдэн өрхийг илүү хямд үнэтэй малаар, заримыг нь зээлээр малжуулсан байна. Мөн зарим сумдад цөөн өрхийг сумын төсвөөс мөнгө гаргаж малжуулсан тохиолдол гарчээ. Эрдэнэдалай суманд сумаас санхүүжүүлж малжуулсан өрхийн талаар мэдээлэл авсан боловч тэд нь малаа өсгөж чадаагүй байв.

4.10. Малжуулах арга хэмжээнд хамрагдах хүсэлтэй малчид олон байсан боловч тэдний цөөн хэсгийг л уг арга хэмжээнд хамруулсан байна. Жишээ нь: Сайнцагаан сум малжуулах арга хэмжээнд хамрагдах хүсэлтээ гаргасан 200 малчнаас зөвхөн 85-ыг нь сонгож малжуулжээ. Сүүлийн жилүүдэд малчдын амьжиргааны байдал доройтож , олон өрхийн малын тоо амьдралд нь хүрэлцэхгүй болжээ. Үүний улмаас малжуулах арга хэмжээ авч өгөхийг малчид, аймаг сумын удирдлага хүсч байна. Үнэн хэрэгтээ түрүүчийн малжуулах арга хэмжээний үр дүн хангалтгүй байгаа

боловч хөдөөгийн ядуурсан малчдын амьжиргааг сайжруулахад малжуулахаас өөр арга зам байхгүй байгаа юм. Энэ нь малжуулах арга хэмжээг хэрэгжүүлэх арга хэлбэрийг илүү боловсронгуй болгохыг шаардаж байна.

Завхан аймагт хэрэгжсэн малжуулах арга хэмжээний тойм

4.11. 1999-2000 оны зудад Завхан аймаг малаа ихээр хорогдуулж, олон малчин өрхийн амьжиргааны эх үүсвэр алдагдсан нь малжуулах арга хэмжээ хэрэгжүүлэх шалтгаан болсон байна. Тус аймагт ган, зудад хүчтэй нэрвэгдэж, амь зуулгын хэдэн малтай үлдсэн буюу огт малгүй болсон малчин өрхүүдийг малжуулахад дараах байгууллага, сангууд оролцсон байна.

Хүснэгт 4.4

Малжуулах төслийг хэрэгжүүлэгчид

	Санхүүжүүлэгч	Санхүүжилтийн хэмжээ, сая төг	Хамрагдсан сум	Төсөл эхэлсэн	Хугацаа Жилээр
1	Дэлхийн банк	313,8	8	2000	5
2	Санкей сан (Япон)	120,9	11	2000	5
3	Ерөнхийлөгчийн сан	10,7	1	2001	2

4.12. Тухайлбал, 2000 онд Дэлхийн банкны зээлээр зудад хүчтэй нэрвэгдсэн 8 сумын 380 өрхийг малжуулахад 313,8 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан байна. Энэ арга хэмжээний хүрээнд нийт 27123 толгой малыг 5 жилийн хугацаатай зээлийн хэлбэрээр олгосон байна. Мөн энэ онд Япон улсын Санкей сангийн санхүүжилтээр 2000 онд 11 сумын 180 өрхөд 120.9 сая төгрөгийг эргүүлэн төлөх болзолтойгоор мал худалдан авах зээл олгосон бол 2001 онд Яруу суманд Монгол улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит сангаас 11 өрхөд 10.7 сая төгрөгийн санхүүжилт хийж малжуулжээ.

4.13. Малжуулах төсөлд тус аймгийн 20 сумын 571 малчин өрхөд 39702 толгой малыг худалдан авах зориулалттай зээл олгож энэ арга хэмжээнд гадаад болон дотоод эх үүсвэрээс нийт 445.7 сая төгрөгийг зарцуулжээ.

4.14. Дэлхийн банкны зээлээр санхүүжүүлсэн малжуулах арга хэмжээний хувьд бодод шилжүүлсэнээр 10-аас доош тооны малтай, мал маллах арга туршлагатай, зээлээ төлөх чадвартай эсвэл хөндлөнгийн баталгаатай, өөрийн өвөлжөө, хаваржаатай малчин өрхийг малжуулахаар журам гаргасан боловч энэ нь зарим талаар Завхан аймагт зөрчилдсөн байлаа. Тухайлбал, судалгаанд хамрагдсан өрхийн 11% өөрийн өвөлжөөгүй, 15% нь өөрийн хаваржаагүй байсны дээр зарим суманд малжуулалтанд хамрагдах болзолтой өрхүүдийг сонгон шалгаруулахдаа танил тал, ах дүүгээрээ нийлэн багийн хуралд зонхилох хувийг эзлэн шийдвэр гаргуулсан байв.

Хүснэгт 4.5

Малжуулах төсөлд хамрагдсан байдал

Сум	Өрх	Малын төрөл					Санхүүжилт сая төгрөг
		Бүгд	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	
Нэг. Дэлхийн банкны зээлээр							
Алдархаан	34	2669	13	16	1211	1429	31,03
Сантмаргац	70	3668	6		2410	1252	42,20
Сонгони	33	2777	2	1	2634	140	32,73
Улиастай	57	2229	17	24	1810	378	31,65
Шилүүстэй	26	1563	1	3	1539	20	17,70
Эрдэнэхайрхан	69	6246	11	15	4877	1343	67,80
Яруу	50	4402	24	30	3903	445	49,88
Цэцэн-Уул	41	3569			2661	908	40,81
Дүн	**380**	**27123**	**74**	**89**	**21045**	**5915**	**313,83**
Хоёр. Санкей сангийн зээлээр							
Цагаанчулуут	10	800			800		7,97
Завханмандал	10	800			800		7,97
Идэр	10	800			800		7,97
Тосонцэнгэл	10	800			800		7,97
Цагаанхайрхан	10	800			800		7,97
Шилүүстэй	15	1200			1200		11,96
Их-Уул	10	730			730		7,96
Отгон	15	810			810		11,96
Баянхайрхан	10	802	4	4	691	103	6,17
Нөмрөг	10	820			820		7,97
Улиастай	70	3493			3448	45	34,57
Дүн	**180**	**11855**	**4**	**4**	**11699**	**148**	**120,4**
Гурав. Ерөнхийлөгчийн сан							
Яруу	11	724	10	10	482	222	11,0
Нийт дүн аймгийн хэмжээгээр	**571**	**39702**	**88**	**103**	**33226**	**6285**	**445,2**

4.15. Судалгаанаас үзвэл, Идэр, Яруу, Эрдэнэхайрхан сумд малгүй, цөөн малтай өрхийг, Сантмаргац, Цэцэн-Уул сумд харьцангуй олон малтай өрхийг малжуулах арга хэмжээнд хамруулсан ба өрхийн сонголт харилцан адилгүй явагдсан байна.

Хүснэгт 4.6

Нэг өрхийн малын тооны өөрчлөлт, сумын дундажаар

	Сумын нэр	Малын тоо			Санхүүжилт Мянган төгрөгөөр
		Малжуулахын өмнө	Малжуулал таар авсан	Малжуулсаны дараа	
1	Сантмаргац	113	55	104	639.3
2	Яруу	18	86	33	1000.0
3	Эрдэнэхайрхан	33	90	75	1007.8
4	Цэцэн-Уул	120	86	51	930.8
5	Идэр	37	80	37	1000.0

4.16. Тухайлбал, Сантмаргац суманд 466 малтай өрх, Цэцэн-Уул суманд 200-аас дээш тооны малтай нэлээд өрх малжуулах арга хэмжээнд хамрагдсан байлаа. Малжуулах арга хэмжээний үед сумдууд нэг өрхөд хонь, ямаа голдуу дундажаар 80-90 толгой мал өгсөн байхад Сантмаргац сум олон өрхийг хармуулах зорилгоор дундажаар 55 толгой мал өгч нэг өрхийн зээлийн төлбөрийн хэмжээ нь бусад сумаас харьцангуй бага буюу өрхийн дунджаар 639,3 мянган төгрөг болсон байна.

4.17. Малжуулах арга хэмжээг Завхан аймагт мөн өрхийн амьжиргааны чадавхийг дэмжих төслөөс зохион байгуулан явуулсан байна. Уг арга хэмжээг хэрэгжүүлэх үед сум бүрт багийн засаг дарга оролцсон түр ажилтнууд ажиллуулсан бөгөөд одоо сум бүрд малжуулах төслийн ажлыг сумын ХАА-н ажилтан хариуцаж байна. Малжуулах арга хэмжээг дээрээс боловсруулж ирүүлсэн заавар аргачлалын дагуу явуулжээ.

4.18. Малжуулах арга хэмжээний дараа малчин өрхийн малын тоо сумын дунджаар 1,6 4 дахин буурсан байна. Малжуулах арга хэмжээ явагдсан 2000 оны өвөл, хавар Завхан аймгийн ихэнх суманд цас их хэмжээгээр орж цаг хатуурсанаас айл айлаас цуглуулан өгсөн тарга хүч муутай мал их хэмжээгээр хорогдож малжуулах арга хэмжээний үр дүнг бууруулжээ. Малчдын ярьж байгаагаар уг арга хэмжээ нь зөв зүйтэй үйл ажиллагаа байсан боловч цаг үеэ төдийлөн сайн олоогүй байна. Тухайлбал, малжуулахаар өгсөн малыг Цэцэн-Уул суманд аль хэдий нь цас дарсан байсан 12 сард тараасан нь хотондоо туугаад ирэх хооронд л үхэж хорогдож эхэлж байсан гэж ярьж байв.

4.19. Малжуулах арга хэмжээний дараа малгүй болсон ба малынхаа ихэнхийг хорогдуулсан айл өрхүүд сум, аймгийн төвд суурьшин, зарим хэсэг нь Улаанбаатар хот болон бусад аймагт ах дүүгээ бараадан амьжиргаагаа залгуулахаар албан бусаар шилжсэн байна.

Хүснэгт 4.7

Малгүй ба малаа хорогдуулсан айл өрхийн шилжилт хөдөлгөөн

	Сумын нэр	Огт малгүй болсон өрх	Шилжин суурьшсан газар			
			Улаанбаатар	Улиастай	Сумын төв	Бусад
1	Сантмаргац	12	4	1	5	1
2	Яруу	19	5	16	3	2
3	Эрдэнэхайрхан	6	5	24	4	4
4	Цэцэн-Уул	4	1	4	5	1
5	Идэр	2			7	
	Бүгд	43	15	45	24	8

Хүснэгтээс харахад, судалгаанд хамрагдсан 5 сумын дүнгээр огт малгүй болж малжуулах төслийн үйл ажиллагаа зогссон 43 малчин өрх байна. Малжуулалтанд хамрагдсан нийт өрхийн 16,1% нь буюу 92 малчин өрх шилжин суурьшжээ.

4.20. Малжуулах төвлөрсөн арга хэмжээний зэрэгцээгээр Завхан аймгийн Хоршоологчдын холбооны (хуучин нэрээр) дэргэдэх "Дөрвөлжин таван эрдэнэ", хоршоо огт малгүй 60 айл өрхийг малжуулсан. Мөн "Завхан-Өсөх Ирээдүй" хоршоо гишүүдийнхээ хөрөнгөөс малын эрүүл мэндийг хамгаалах сан байгуулан түүнээс малжуулах арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөж байна.

Баянхонгор аймагт хэрэгжүүлсэн малжуулах арга хэмжээний тойм

4.21. Баянхонгор аймаг малжуулах төслийг ерөнхийдөө 1998 оны 6-р сараас 2000 оны 8-р сарын хугацаанд хэрэгжүүлсэн байна. Тус аймаг 20 сумтай өндөр уул, ойт хээр, хээр тал, говийн бүсэд хамрагдана. Малжуулах төслийг үндсэндээ 4 байгууллагаас санхүүжүүлсэн байна. Үүнд:

1. Дэлхийн банк,
2. Английн хүүхдийг ивээх сан,

3. Японы “Санкей сонины газар”,
4. Баянхонгор аймгийн “Малын буян” төсөл.

4.22. Тус аймагт нийтдээ зуданд нэрвэгдсэн 20 сумын 453 өрхийг малжуулахад 319,9 сая төгрөгийн хөрөнгө зарцуулсан байна. Энэ арга хэмжээний хүрээнд нийт 27689 толгой малыг 6 жилийн хугацаатайгаар зээлийн хэлбэрээр олгосон бөгөөд 1665 ам бүлийг хамарчээ.

Хүснэгт 4.8

Баянхонгор аймгийн малжуулах төсөлд хамрагдсан байдал

Сум	Өрх	Малын төрөл					Санхүүжилт сая төгрөг
		Бүгд	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	
Нэг. Дэлхийн банкны зээлээр							
Гурванбулаг	48	3312			2952	360	33,1
Жаргалант	12	1195			1195		11,4
Баянбулаг	54	2569			2368	201	25,8
Заг	58	3772			3421	351	37,6
Дүн	**172**	**10848**			**9936**	**912**	**107,9**
Хоёр. Санкей сонины газар							
Галуут	10	765		25	561	179	10,0
Гурванбулаг	29	2000			1845	155	20,0
Жаргалант	20	1938			1698	240	20,0
Хүрээмарал	11	724			482	207	10,0
Баянбулаг	18	1000	24	11	1000		10,0
Заг	40	2000			1950	50	20,0
Баянлиг	11	1000			183	817	10,0
Дүн	**139**	**9427**	**24**	**36**	**7719**	**1648**	**100,0**
Гурав. Английн хүүхдийг ивээх сан							
Гурванбулаг	10	300			300		3,0
Хүрээмарал	10	300			300		3,0
Баянбулаг	10	300			300		3,0
Заг	10	300			300		3,0
Дүн	**40**	**1200**			**1200**		**12,0**
Дөрөв. “Малын буян”							
Галуут	14	1023	13	35	535	440	14.0
Эрдэнэцогт	16	405	4	157	165	79	16.0
Гурванбулаг	1	52	3	4	45		1.0
Жаргалант	2	200			200		3.2
Баян-Овоо	21	1689	18	18	1534	119	21,0
Өлзийт	10	760	1	35	328	396	11.0
Бөмбөгөр	2	91			55	96	2.0
Хүрээмарал	2	200			100	100	2.0
Баянбулаг	2	98	2	6	65	25	2.0
Заг	2	128	5	10	90	23	2.0
Жинст	4	352	20		120	212	4.0
Баянговь	1	117	5		15	97	2.0
Шинэжинст	2	264	2	2		260	2.0
Баян-Өндөр	7	100			50	50	2,0
Баянцагаан	2	224		2	41	181	4,0
Баацагаан	9	283			81	202	2.8
Бууцагаан	5	228		8	127	93	9,0
Дүн	**102**	**6214**	**73**	**277**	**3551**	**2315**	**100,0**
Бүгд	**453**	**27689**	**97**	**313**	**22406**	**4875**	**319,9**

4.23. Баянхонгор аймагт малжуулах арга хэмжээг явуулсан нэг онцлог бол эхний жилүүдэд говийн аймгуудын зуншлага сайн, малын тэвээрэг ч харьцангуй сайн байсан тул малжуулалтыг ган, зуд 2 жил дараалан болсон аймгийн хойд талын сумдуудад хэрэгжүүлэхээр аймгийн удирдлагууд шийдвэрлэсэн байна. Иймд

бид Баянхонгор аймгийн Гурванбулаг, Заг, Галуут, Баян-Овоо сумдыг сонгосон юм.

4.24. Баянхонгор аймагт дунджаар 65-70 толгой хонийг нэг өрхөд өгч малжуулах арга хэмжээ авсан, гэхдээ тодорхой тооны малтай өрхүүдэд мал өгч байсан нь малын өсөлтөнд төдийлөн нөлөө үзүүлээгүй. Одоо эдгээр өрхүүдийн мал нь өсөөд түрээсээр авсан эхнийхээ 25 малыг олон малчид эргүүлэн байгууллагадаа өгч хоёрдах малжуулалтыг хийж байна. Ялангуяа Гурванбулаг, Заг суманд малжуулалтын үйл ажиллагаа бүртгэл тооцоо, хяналт зохион байгуулалтын хувьд илүү сайн байсныг цохон тэмдэглэхийг хүсч байна. Тухайлбал, малжуулалтад хамрагдсан өрхүүдийг жилд 2 удаа эргэж, үр дүнгий нь тооцож байжээ. Эдгээр сумдад малжуулалтын үр дүнгийн хүснэгт хөтөлж байсан нь хяналтын сайн механизм болсон байна. Харин Галуут сум малжуулалтанд харьцангуй бага хамрагдсан бөгөөд зөвхөн аймгийн "Малын буян" төслөөс 14 өрхийг малжуулалтанд хамруулсан байна.

Хүснэгт 4.9

Судалгаанд хамрагдсан өрхийн малын тоо

Малын тоо		Бүгд	Нэг өрхийн малын тоо	Малын бүтэц, хувиар
Малжуулалтын өмнө	Бүгд	2968	67	
	Тэмээ	45	1	1,4
	Адуу	494	11	16,4
	Үхэр	470	11	16,4
	Хонь	1200	27	40,2
	Ямаа	759	17	25,6
Малжуулалтаар авсан	Бүгд	2781	63	
	Хонь	2494	56	89,9
	Ямаа	287	7	10,1
Малжуулалтын дараах	Бүгд	4488	102	
	Тэмээ	9		
	Адуу	444	11	10,7
	Үхэр	420	9	8,8
	Хонь	2230	51	50,0
	Ямаа	1385	31	30,5

4.25. Хүснэгтээс харахад судалгаанд хамрагдсан 44 өрхийн нэг өрхөд ногдох малын тоог малжуулалтын өмнөх ба дараах үеэр нь харьцуулан тооцоход 51.2 хувиар өссөн ба малын бүтцэд төдийлөн өөрчлөлт гараагүй байна.

Хөвсгөл аймагт хэрэгжүүлсэн малжуулах арга хэмжээний тойм

4.26. Тус аймагт 1999 оноос Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангаас цөөн малтай амьжиргааны түвшин дорой ядуу өрхүүдийг малжуулж 13 сумын 1777 өрхөд 1080573,9 мянган төгрөгний мал олгожээ. Энэ арга хэмжээний хүрээнд зээлээр олгосон малыг 9 жилийн хугацаатай зээлийн хэлбэрээр, бод малыг 6 дахь, бог малыг 3 дахь жилээс нь эхлэн эргүүлж төлөх болзолтойгоор олгосон байна. Мөн Английн түншлэлийн хөтөлбөрөөс Хатгал, Чандмань-Өндөр сумын 129 өрхөд 19250,0 мянган төгрөгний 2229 толгой малыг 3 жилийн хугацаатай, 3 жилд 5 хувийн хүүтэй зээлийн хэлбэрээр олгожээ. Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын

сангаас малжуулагдсан нийт өрхийн 37,19 хувь нь 20-30 малтай, 34,3 хувь нь 10-20 малтай, 21,5 хувь нь 30-аас дээш малтай , үлдсэн хувь нь 10-аас доош малтай өрхүүд байв .

Хүснэгт 4.10

Малжуулалтанд хамрагдсан өрхүүдэд олгосон
малын тоогоор хийсэн бүлэглэлт

Он	Хамрагдсан өрх	Үүнээс малын тооны ялгаагаар				
		0-5	5-10	10-20	20-30	30-аас дээш
1999	78	1	8	49	15	5
2000	364	24	36	132	103	69
2001	578	9	21	210	121	147
2002	757	2	22	219	352	162
Дүн	1777	36	87	610	591	383

4.27. Судалгаанаас үзвэл, ихэнх сумууд 10-аас дээш малтай, хөрөнгийн баталгаа бүхий ядуу өрхүүдийг малжуулах арга хэмжээнд хамруулахыг эрмэлзсэн байна.

4.28. Түүнээс гадна Английн түншлэлийн хөтөлбөрөөс Хөвсгөл аймгийн Хатгал тосгон, Чандмань-Өндөр сумуудад малжуулах арга хэмжээг зохион байгуулан явуулсан байна. Энэ төслийн малжуулалтыг явуулсан арга хэлбэр, малчдыг сонгосон шалгуурууд түрүүчийн төслийхтэй үндсэндээ адил байв. Малжуулах арга хэмжээг хэрэгжүүлэх үед аймаг, суманд төсөл хэрэгжүүлэх баг бүрдүүлж ажиллуулсан байна. Одоо аймаг дээр ажиллаж буй төсөл хэрэгжүүлэх баг аймгийн хэмжээнд малжуулалтыг үргэлжлүүлэн зохион байгуулах, түүний явцад хяналт тавьж гарсан дутагдлыг арилгах арга хэмжээ авах, сургалт явуулах, малжуулалтаар авсан малыг вакцинжуулах, сумын малжуулах ажлын явцыг удирдан чиглүүлэх, малчдын нөхөн төлбөрийг барагдуулах сумуудаар санхүүжилтийг хуваарилах зэрэг ажлуудыг хариуцан гүйцэтгэж байна.

4.29. Малжуулах арга хэмжээг аймгийн удирдлага, хэрэгжүүлэгч байгуулагын боловсруулсан заавар аргачлалын дагуу явуулжээ. Малжуулах ажил ямар ч зөрчилгүй явагдсан байна. Харин малжуулах арга хэмжээний тайлан, мэдээллийг хугацаанд нь гаргаж өгөхгүй хожимдуулах явдал гарч байсан байна.

4.30. Хөвсгөл аймагт дээрхи хоёр төслөөс гадна Их хурлын гишүүн Б.Гүндалай Дархадын зарим сумын малчдыг малжуулж малжуулалтанд хамрагдах өрхүүдийг сугалаагаар сонгожээ. Их хурлын гишүүний явуулсан малжуулалтын асуудлыг хариуцсан байгууллага, хүмүүс аймаг дээр олдоогүй тул энэ тухай мэдээллийг цуглуулж чадаагүй болно.

4.31. Малжуулах явцад малжуулах арга хэмжээнд хамрагдах хүсэлтэй малчид олон байсан боловч тэдний цөөн хэсэг нь л уг арга хэмжээнд хамрагдсан байна. Ер нь Хөвсгөл аймагт малжуулалт нилээд нарийн хяналт , зохион байгуулалттай явагдсан байна. Тухайлбал, сумын малжуулалтыг хэрэгжүүлсэн байгууллагаас улирал бүр малжуулалтад хамрагдсан өрхийн малыг нэг бүрчлэн тоолж, гэрээний биелэлтийг гаргаж байжээ.

4.32. Хөвсгөл аймгийн малжуулах төслийхөн малжуулалтын үр дүнг сайжруулах зорилгоор аймгийн удирдлага, холбогдох мэргэжилтнүүд, малжуулалтыг зохион байгуулахад оролцсон аймаг, сумын холбогдох хүмүүс,

малжуулалтаар мал авсан малчдыг сургалтанд хамруулж, малчдын малжуулалтаар авсан малыг сумын төсвөөс үнэ төлбөргүй вакцинжуулах, малжуулах хөрөнгөөс даатгалд хамруулах зэрэг ажлуудыг зохион байгуулсан байна.

4.33. Хөвсгөл аймагт малжуулалтаар мал авсан өрхүүдийг даатгалд хамруулах зорилгоор шаардлагатай материал бүрдүүлэхэд нь туслах, даатгалын ач холбогдлыг ойлгуулах чиглэлээр сургалт явуулжээ.

4.34. Хөвсгөл аймгийн хэмжээнд малжуулах төслийнхний зохион байгуулсан сургалтыг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 4.11

Зохион байгуулсан сургалт

Он	Сургалтын тоо	Хамрагдсан хүний тоо	Зохион байгуулсан газрын тоо /давхардсан тоогоор\
1999	14	920	16
2000	58	2680	58
2001	28	1420	28
2002	44	2339	44
Дүн	144	7359	146

4.35. Малжуулалтын үр дүн Хөвсгөл аймагт малжуулалтыг явуулсан тухайн жилийн байгаль, цаг уурын байдлаас ихээхэн хамаарсан байв. Тухайлбал, 1999, 2000 онд малжуулалтанд хамрагдсан өрхүүдийн мал дээрх онуудад болсон зудаас хамаарч их хорогдсон байв. Харин 2001, 2002 онд мал авсан өрхүүдийн ихэнх нь малаа өсгөсөн байлаа. Гэвч малжуулалтанд хамруулах өрхийг зөв сонгож чадаагүйгээс малжуулалтын үр дүн зохих хэмжээгээр доошилсон гэж удирдах ажилтан, холбогдох хүмүүс ярьж байна. Малжуулалтын үр дүнг дээшлүүлэх талаар хийсэн ажлууд, малжуулалтанд хамрагдсан өрхийн өөрсдийнх хичээл зүтгэлийн үр дүнд малын өсөлт тогтвортой байгаа, малаа зохих түвшинд өсгөж байгаа, бага хэмжээгээр малаа хорогдуулж байгаа өрхийн тоо өсч анхаарал татсан өрхийн тоо цөөрөх хандлагатай болсон байна.

Хүснэгт 4.12

Хөвсгөл аймаг дахь малжуулалтын үр дүнгийн судалгаа

Он	Малжуулалтанд хамрагдсан өрхүүд				
	Нийт	малын өсөлт тогтвортой байгаа	малын өсөлт зохих түвшинд байгаа	малаа бага хэмжээгээр хорогдуулсан	анхаарал татсан өрхийн тоо*
1999	78	49	12	8	9
2000	364	249	32	26	57
2001	578	488	60	21	9
2002	757	222	511	22	2
Дүн	1777	1008	615	77	77

*- анхаарал татсан өрх- малаа нилээд хэмжээгээр хорогдуулан цөөн малтай болж зээлээ эргүүлэн төлөх найдвар муутай болсон өрх

4.36. Хүснэгтээс харахад анхаарал татсан өрхийн тоо 2000 онд 57 байсан нь 2000 оны зудаар олон өрх малаа хорогдуулсантай холбоотой юм. Хөвсгөл аймагт явагдсан малжуулах арга хэмжээний үр дүнд малжуулалтанд хамрагдсан өрхүүдийн орлого ерөнхийдөө өссөн байна. Үүнийг Хөвсгөл аймгийн малжуулах төслийн багийхны малжуулалтанд хамрагдсан өрхүүдийн орлогоор хийсэн бүлэглэлтээс харж болно. Бүлэглэлтийг хийхдээ амьжиргааны баталгаажих доод түвшингээс дээш, доош гэж хоёр ангилаад, доош амьжиргаатай өрхийг нэг хүнд ногдох орлогоор нь 5580 хүртэл төгрөгийн орлоготой, 5580-14700 төгрөгийн орлоготой гэж дотор нь хоёр хуваасан байна.

Хүснэгт 4.13

Малжуулалтанд хамрагдсан өрхүүдийн орлогоор хийсэн бүлэглэлт

Он	Өрхийн тоо	14700 төгрөгнөөс дээш орлоготой		5580-14700 төгрөгийн орлоготой		5580 хүртэл төгрөгийн орлоготой	
		Төсөлд ороход	2002 оны эцэст	Төсөлд ороход	2002 оны эцэст	Төсөлд ороход	2002 оны эцэст
1999	78	1	15	20	50	51	13
2000	364	27	74	130	212	207	78
2001	578	54	91	268	378	256	109
2002	757	10	12	1257	321	490	424
Дүн	1777	92	192	1675	961	1004	624

4.37. Хүснэгтээс харахад, төсөлд хамрагдсан өрхийн оны эцсийн орлого төсөлд орох үеийнхээс өсч , орлого өндөртэй өрхийн тоо ч он оноор нэмэгдсэн байна. Энэ бүхнээс үзвэл малжуулалт малчин өрхийн амьжиргааг дээшлүүлэхэд чухал нөлөө үзүүлсэн байна. Аймаг, сумын удирдах ажилтан, мэргэжилтнүүд, малжуулалтыг хэрэгжүүлсэн байгууллага, хүмүүсээс авсан судалгаанаас үзэхэд хөдөөгийн ядуурсан малчдын амьжиргааг сайжруулахад малжуулалт чухал нөлөө бүхий арга хэмжээ болсон байна. Харин малжуулах арга хэмжээг хэрэгжүүлэх арга хэлбэр, шалгуурыг илүү боловсронгуй болгохын зэрэгцээ нэн ядуу малчин өрхийн амьжиргааг хэрхэн сайжруулах вэ гэдэг асуудал анхаарал татсан чухал асуудлын нэг байна.

4.38. Судалгаанд хамруулах сумдыг сонгохдоо бусад аймгуудтай адил шалгуураар сонгосон боловч төсөл хэрэгжүүлсэн нэг суманд аль болох олон төсөл хэрэгжсэн байх гэсэн нэмэлт шалгуур хэрэглэсэн болно.

Хүснэгт 4.14

Судалгаанд хамруулах сумын сонголт

Сум	Малжуулалтанд хамрагдсан		Нэг өрхөд ноогдох		Хэрэгжүүлсэн байгууллага
	Өрхийн тоо	зарцуулсан хөрөнгө	Санхүүжилт Мян.төг	Малын тоо	
Бүрэн тогтох	111	76555,5	689,69	47,5	ХААХОУС
Хатгал	42	23337,0	555,64	20,2	ХААХОУС
	27	5909,0	218,85	24,25	Английн түншлэлийн хөтөлбөр
Их уул	82	52782,0	643,4	47,3	ХААХОУС
Түнэл	94	58500,0	590,42	24,8	ХААХОУС

Судалгаанд хамрагдах сумуудыг сонгохдоо малжуулалтын үр дүн нь харьцангуй сайн байгаа Их уул, муу байгаа Түнэл, дунд зэрэг байгаа Бүрэнтогтох сум, хоёр төсөл хэрэгжсэн Хатгал тосгоныг малжуулалтыг хэрэгжүүлсэн төслийн багийн гишүүд, аймгийн удирдлагатай зөвлөлдсөний үндсэн дээр сонгосон болно.

4.39. Судалгаанд хамруулах багийг сумын удирдлага, малжуулах төслийн орон нутгийн төлөөлөгч, бусад мэргэжлийн хүмүүсийн саналыг харгалзан сонгосон болно. Харин малжуулалтанд хамрагдсан ба хамрагдаагүй өрхийг санамсаргүй түүврийн аргаар сонголоо.

Малжуулах арга хэмжээг зохион байгуулсан байгууллагууд

4.40. Малчин өрхийн амьжиргааг сайжруулахад чиглэгдсэн малжуулах арга хэмжээг дээр өгүүлснээр дараах байгууллагууд хэрэгжүүлсэн юм. Үүнд:

- Ядуурлыг бууруулах хөтөлбөр
- Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сан
- Японы"Санкей" сонин
- Английн түншлэлийн хөтөлбөр
- Ерөнхийлөгчийн хөдөөг дэмжих сан
- Дэлхийн зөн

4.41. Дотоод, гадаадын эдгээр байгууллагаас гадна аймаг, сумын төсөв,олон арван компани хоршоо, хувь хүмүүс малжуулах арга хэмжээнд зохих хувь нэмэр оруулсан байна.

Ядуурлыг бууруулах хөтөлбөр

4.42. Хөдөөгийн ядуу амьдралтай айл өрхүүдийг малжуулах төслийг 1997 оноос Баянхонгор, Дорнод, Баян-Өлгий, Сүхбаатар аймгийн нийт 16 суманд туршилтын журмаар хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд энэ төслийн үр дүнд цөөн малтай буюу огт малгүй 366 ядуу өрхийг малжуулжээ. Энэ нь 3 жилийн хугацаатай, малын толгойгоор олгогдох зээл байсан бөгөөд уг төсөлд хамрагдсан нэг өрхөд 150000-300000 төгрөгийн өртөг бүхий эрүүл, удам сайтай төллөх бог малыг зээлээр олголсон байжээ.

4.43. 1999-2000 оны өвөл Монголд тохиолдсон зудын хохирлыг арилгах зорилгоор зудад нэрвэгдэн малаа олноор нь хорогдуулж амьжиргааны нөхцөл нь дордсон малчин өрхүүдийг малжуулах төслийг 5 аймагт хэрэгжүүлэхээр Монгол улсын ерөнхий сайд асан, Ядуурлыг бууруулах үндэсний хорооны дарга Р.Амаржаргалын 2000 оны 4-р сарын 28 өдрийн 02 тоот тушаалаар шийдвэрлэжээ. Уг тушаалаар малжуулах төслийн хөрөнгийн дараах байдлаар хуваарилсан байна.

Хүснэгт 4.15

Байгалийн гамшигийн улмаас малгүй буюу цөөн малтай болсон өрхүүдийг малжуулах төслийн хуваарь

	Аймгийн нэр	Хорогдсон мал (мянган толгойгоор)[1]	Нийт малд хорогдсон малын эхлэх хувь	Олгосон зээл (мянган ам долларaар)
1	Дундговь	557,8	34,15	442,21
2	Өвөрхангай	420,3	25,73	333,20
3	Завхан	321,4	19,68	254,80
4	Увс	200,2	12,26	158,71
5	Баянхонгор	133,8	8,19	106,08
Дүн		1633,5	100,0	1295,00

[1]- 2000 оны 04 сарын 17-ны байдлаар

4.44. Ядуурлыг бууруулах хөтөлбөрийн хүрээнд 5 аймгийн 35 сумын 1662 өрхөд 95050 толгой малыг 5 жилийн хугацаатай олгожээ. Уг арга хэмжээнд зарцуулсан хөрөнгө нь 1395,5 сая төгрөг болсон байна. Энэхүү төсөлд хамрагдсан 1728 өрхийн дотор огт малгүй 246 өрх, 10-30 толгой малтай 686 өрх, 50-100 толгой малтай 552 өрх, 100-аас дээш толгой малтай 65 өрх байлаа. Малжуулалтанд хамрагдсан нийт өрхийн 73 нь өрх толгойлсон эмэгтэй тэргүүлэгчтэй өрх байлаа.

Хүснэгт 4.16

Ядуурлыг бууруулах хөтөлбөрөөр малжуулсан аймаг, сум, малын тоо

Аймаг	Малжуулалтанд хамрагдсан		Нийт олгосон малын тоо	Нэг өрхөд ноогдох малын тоо
	Сум	өрх		
Дундговь	10	537	23432	43
Өвөрхангай	8	377	17914	47
Баянхонгор	4	172	10848	63
Завхан	8	378	27030	71
Увс	5	198	15826	79
Дүн	35	1662	95050	55

4.45. Уг төслөөр нэг өрхөд олгосон малын тоо 45-100 толгой, зээлийн төлбөр нь 600,0 1000,0 мянган төгрөг байлаа. Олгосон нийт малын 74,2% хонь, 25% нь ямаа, үлдэх 0,8% нь бод мал байжээ.

Хүснэгт 4.17

Малжуулалтаар олгосон малын дундаж тоо, бүтэц

Малын төрөл	Нийт малын тоо ба бүтэц		Нэг өрхийн малын тоо, толгойгоор
	толгойгоор	Хувь	
Тэмээ	2	0.0002	0.001
Адуу	406	0.42	0.23
Үхэр	273	0.28	0.15
Хонь	70527	74.2	40.8
Ямаа	23842	25.0	13.8
Бүгд	95050	100.0	55

4.46. Нийт олгосон малын 99,2% нь бог мал үүнээс 74,2% нь хонь байжээ. Харин нэг өрхөд дундажаар 41 хонь, 13 ямаа, 1 бод нийт 55 толгой ногдож байв.

4.47. Малжуулах төсөлд хамрагдах малчин өрхүүдийг орон нутгийн иргэдийн оролцоотойгоор сумын Ядуурлыг бууруулах зөвлөл сонгон авч 1 өрхөд ам бүлийн тоог нь харгалзан 100 хүртэл тооны толгой малыг 5 жилийн хугацаатайгаар, жилийн 6%-ийн хүүтэйгээр гэрээ байгуулан олгожээ. Малчин өрх эхний 2 жилд зээлийн төлбөрийг хийхгүй бөгөөд 3,4 дэх жилд тус бүр зээлийн 30%, 5 дахь жилд 40%-ийг төлөх нөхцөлтэй гэрээ хийсэн байна.

Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сан (IFAD)

4.48. Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн “Хөвсгөл,Архангай аймгийн хөдөөгийн ядуурлыг бууруулах төсөл”-ийн хүрээнд ядуурсан малчдыг малжуулах зорилгоор 2 жил дараалан тус 2 аймгийн 49 сумын 2011 өрхөд нийт 60914 мал худалдан авч олгожээ. Үүнээс 2000 онд 2 аймгийн 26 сумын 1358 өрхөд 36319 мал, 2001 онд 2 аймгийн 23 сумын 719 өрхөд 24595 мал өгчээ.

Хүснэгт 4.18

Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн малжуулалтын судалгаа

	Аймгийн нэр	Малжуул-сан он	Хамрагд-сан сум	Хамрагд-сан өрх	Олгосон малын тоо	Нийт санхүүжилт (сая.төг)
ХААХОУ Сан	Хөвсгөл	2000	11	442	13539	233.7
		2001	20	506	18000	337.0
	Архангай	2000	15	916	22780	493.8
		2001	3	213	6595	149.4

4.49. Уг төслийн санхүүжилтэнд 1213,9 сая төгрөг зарцуулсан байна. Энэ төсөл нь малын толгойгоор олгогдох зээл байсан бөгөөд бог малыг 6 жилийн дараа, үхрийг 9 жилийн дараа авсан малаа бүрэн төлж барагдуулах нөхцөлтэй байв. 2002 оноос уг төсөл нь өргөжиж Булган, Хэнтий аймгуудыг нэмж хамруулах болжээ.

4.50. ХААХОУ-ын сангаас Засгийн газартай байгуулсан "Дамжуулан зээлдүүлэх" гэрээний дагуу хэрэгжиж байна.

Японы "Санкей" сонины газар

4.51. 2000 онд Япон улсын "Санкей" сонины 245,1 сая төгрөгийн санхүүжилтийг Монгол улсын Засгийн газрын 2000 оны 5-р сарын 31 өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн Хүнс, хөдөө аж ахуйн яамны сайдын 2000 оны 6 сарын 2-ны өдрийн А/84 дугаар тушаалаар ган, зудад их хэмжээгээр өртөж, малгүй болон цөөн малтай өрхийн тоо олширсон Баянхонгор, Завхан аймгуудад малжуулалтанд зарцуулахаар шийдвэрлэжээ. Ингэхдээ төслийн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, төслийн хэрэгжилтэнд хяналт тавих, зээлийг буцаан төлүүлэх ажлыг улсын мал эмнэлэг, үржлийн алба, аймагт хөдөө аж ахуйн газрын мал эмнэлэг үржлийн алба удирдан зохион байгуулахаар шийдвэрлэжээ.

4.52. Төсөлд хамрагдах сум, тэдгээрт ноогдох санхүүжилтийн хэмжээг мөн энэ тушаалаар батлаж, малжуулалтанд хамрагдах өрхүүдийг сумын Тамгын газар сонгож нэг өрхөд дунджаар 80 толгой бог малыг олгох бодлого барьсан байна.

Хүснэгт 4.19

"Санкей" сонины газрын малжуулалтын дүн

Аймгийн нэр	Хамрагдсан сумын тоо	Олгосон малын тоо толгойгоор	Нийт санхүүжилт сая төгрөгөөр
Завхан	10	11855	145,1
Баянхонгор	7	9427	100,0

4.53. Япон улсын "Санкей" сонины газар Завхан аймгийн 10 суманд 11,8 мянган толгой мал буюу 145,1 сая төгрөгийг, Баянхонгор аймгийн 7 суманд 9,4 мянган толгой мал буюу 100 сая төгрөгийг малжуулалтанд зарцуулж нийт 322 малчин өрх уг арга хэмжээнд хамруулсан байна. Малжуулалтын дүнгээс үзэхэд нэг өрхөд олгосон малын тоо нь Завхан аймагт 65 толгой, Баянхонгор аймагт 67,8 толгой байгаа нь олон айлыг малжуулах бодлого баримталсантай холбоотой юм.

4.54. Аймаг бүрт малжуулах зөвлөлийг мал эмнэлэг үржлийн албаны дэргэд байгуулж, малжуулалтын үр дүнг хагас, бүтэн жилээр тооцож холбогдох газарт тайлангаа өгч байх, төслийн мөнгөний хүүг ашиглан ашгийн үржлийн албаны мэдэлд эргэлтийн сан байгуулах гэсэн заалтуудыг баримталжээ. Малжуулах төслийн зөвлөл нь төсөлд хамрагдсан сумдын малжуулах ажлыг зохион байгуулах, төслийн хэрэгжилтэнд хяналт тавих, тайлан мэдээнд дүгнэлт өгч холбогдох байгууллагад тайлагнаж, төсөл хэрэгжүүлэх явцад гарсан тулгамдсан асуудлыг шийдвэрлэж байх үүрэг зорилготой ажиллажээ.

4.55. Харин төсөл хэрэгжүүлэх сумдын мал эмнэлэг, үржлийн хоршоод нь төсөлд хамруулах малчин өрхийг сонгон шалгаруулахдаа орон нутгийн төр, захиргааны байгууллагатай хамтран зөвшилцөж тодорхойлолт, шийдвэр гаргуулан тэдний оролцоотойгоор сонгож байсан байна.

4.56. Төсөлд хамрагдсан малчин сүргийн эргэлтээр тооцож гаргасан зохистой бүтэц бүхий малыг хүлээн авч, өсгөн үржүүлж ашиг шимийг нь ашиглахын зэрэгцээ үндсэн зээлийг 3 дахь жилд 30%, 4 дэх жилд 30%, 5 дахь жилд 40%, мөн зээлийн

хүүг 6% -иар бодож гуравдагч жилээс төлбөрийг хийж байхаар гэрээ байгуулжээ. Малжуулалтаар олгосон малын сүргийн эргэлтийг 5 жилээр хийж тооцооны дагуу малаа өсгөн үржүүлсэнээр анх авсан 80 толгой хониноос 5 жилийн хугацаанд 150 толгой малын зарлага гаргаж, 175 толгой хоньтой болно гэж тооцоолон сурталчилж байжээ.

Шигтгээ 3

Завхан аймагт "Санкей" сонины санхүүжилтээр нийт 122,5 сая төгрөгөөр 11855 толгой мал худалдан авч, малжуулалтаар олгосон малын даатгалд 8,7 сая төгрөгийг шилжүүлж, 1 дэх жилийн 6% хүү 8,7 сая төгрөгөөр мал эмнэлэг үржлийн албаны дэргэд сан байгуулжээ. Малжуулах төсөлд хамрагдсан сумдад 10-15 өрхийг малжуулсан боловч Улиастай сумын иргэдээс малжуулах төсөлд хамруулж өгөхийг хүссэн өрхийн тоо 259 байсныг харгалзан үзэж бусад 10 суманд хуваарилсан хөрөнгөөс нэг жилийн хүүтэй тэнцэх хэмжээний 8,7 сая төгрөгөөр нэмж малжуулан нийт 73 өрхийг малжуулж байсан байна.

Английн түншлэлийн хөтөлбөр

4.57. Малжуулах арга хэмжээг анх 1998 оноос эхлэн Английн түншлэлийн хөтөлбөрийн санхүүжилтээр Баян-Өлгий, Баянхонгор, Дорнод, Баян-Өлгий, Хөвсгөл, Увс, Сүхбаатар аймгийн нийт 19 сумын цөөн малтай буюу огт малгүй 473 ядуу өрхийг хамруулан туршилтын журмаар хэрэгжүүлсэн байна. Түүний санхүүжилтэнд 119 сая төгрөг зарцуулжээ. Энэ төсөл нь 3 жилийн хугацаатай, малын толгойгоор олгогдох зээл байсан бөгөөд эмзэг бүлгийн орлого нэмэгдүүлэх жижиг зээлийн зарчмыг баримтлан хэрэгжүүлжээ. Тус малжуулах төсөлд хамрагдсан нэг өрхөд 150,0-300,0 мянган төгрөгийн өртөг бүхий эрүүл, чанар сайтай төллөх бог малыг зээлээр олгосон байна. Малжуулах уг арга хэмжээний хүрээнд нийт 11225 мал худалдан авч өгсөн байна.

Ерөнхийлөгчийн хөдөөг хөгжүүлэх сан

4.58. Монгол улсын Ерөнхийлөгч өөрийн төрсөн нутаг болох Завхан аймгийн Яруу суманд малаа хорогдуулсан буюу огт малгүй болсон малчин өрхийг малжуулах зорилгоор 2001 онд хөдөөг хөгжүүлэх сангаас 11 сая төгрөгийн хөрөнгөөр 11 өрх айлыг малжуулж 724 толгой мал олгожээ.

Бусад байгууллага, хүмүүс

4.59. Мөн Японы Төрийн бус байгууллагаас Хандивласан 1,6 сая төгрөгийн хөрөнгөөр Өмнөговь аймгийн 3 өрхийг малжуулсан байна.

4.60. Улсын Их Хурлын зарим гишүүд өөрийн төрсөн нутаг, сонгодсон тойрогийнхоо малчин өрхүүдийг малжуулж байсан тохиолдол бий.

Малжуулах айл өрхийг сонгосон шалгуур

Ядуурлыг бууруулах хөтөлбөр

4.61. Ядуурлыг бууруулах хөтөлбөрийн хүрээнд малжуулах арга хэмжээг тодорхой болзол, заавар аргачлалын дагуу явуулжээ. Уг хөтөлбөрөөр малжуулах арга хэмжээнд хамрагдах малчдыг дараах шалгуураар сонгожээ.

Өрх сонгох шалгуур үзүүлэлтүүд:

- Тухайн суманд засаг захиргааны харъяалалтай (сумын төв орохгүй) байнга оршин суудаг,
- 1999-2000 оны гамшигт нэрвэгдэж бодод шилжүүлснээр 10 хүртэл малтай үлдсэн буюу огт малгүй болсон (хонь 6, ямаа 8, тэмээ 1.5, үхэр, адуу 1),
- Мал маллах туршлагатай. МАА-н үйлдвэрлэл байнга эрхлэх чадвартайг нь багийн иргэд хүлээн зөвшөөрч төсөлд хамруулахыг багийн иргэдийн нийтийн хурлаас дэмжсэн байх,
- Өрхийн дотор мал маллах 2 буюу түүнээс дээш хөдөлмөрийн чадвартай гишүүнтэй,
- Өвөлжөө, хаваржаагаар малаа хангах боломжтой,
- Байгалийн эрсдэлээс хамгаалах боломж бүрдсэн буюу бүрдүүлэх нөхцөлтэй,
- Зээлээр авсан малыг өсгөн үржүүлж, гэрээгээр хүлээсэн үүргийн дагуу зээлээ хугацаанд нь буцаан төлөх хуваарь, шаардлагыг өрхийн гишүүд бүгд хүлээн зөвшөөрсөн байх,
- Банк болон бусад байгууллагад өргүй, одоо хууль хяналтын байгууллагаас хянагдаж , шалгагдаагүй.

Зээлээр олгогдох малд тавигдах шаардлага

- Ямар нэгэн өвчин, эмгэггүй, эрүүл болох нь мал эмнэлэгийн үзлэг, шинжилгээгээр тогтоогдсон,
- Омог үүлдрийнхээ ашиг шимийн дундаж түвшинг хадгалсан,
- Зээлээр олгогдох үржлийн хээлтүүлэгч нь мэргэжлийн байгууллагаар анги чанарын баталгаа хийгдсэн, үржлийн малын гэрчилгээтэй байх,
- Хээлтэгч нь 2-4 настай залуу байх.

4.62. Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангийн малжуулах хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтүүд

Өрх сонгох шалгуур үзүүлэлтүүд

- Сумын ядуу өрхийн судалгаанд орсон байх,
- Мал маллах дадлага туршлагатай, удам дамжсан малчин байх,
- Өрхийн дотор хөдөлмөрийн чадвартай 2-оос доошгүй хүн байх,
- Жилийн 4 улирлын бэлчээр нутагтай, хашаа саравчтай, бэлчээрийн даац хүрэлцээтэй, усан хангамжаар дутагдахгүй байх,
- Хот айлын гишүүн хөдөлмөрийн нэгдсэн хуваарьт тодорхой үүрэгтэй оролцдог,
- Ямар нэгэн байгууллага, иргэдэд өр төлбөргүй хууль хяналтын байгууллагад холбогдолгүй,
- Иргэний бүртгэлийн ямар нэгэн зөрчилгүй,
- Бодод шилжүүлсэнээр 10-25 толгой малтай,

- Цаг агаарын бэрхшээлтэй үед эрсдэлээс малаа хамгаалах чадвартай,
- Малын халдварт өвчний голомтгүй
- Сүүлийн 3 жил дараалан малаа өсгөсөн байх гэсэн шаардлагууд тавигджээ.

Зээлээр олгогдох малд тавигдах шаардлага

Худалдан авах малын сонголт: Үржлийн үхэр, хонь

Монгол үхэр:

- Амьдын жин нь 5-р сард 3-4 настай үнээ 190-230 кг, 4 дээш настай бол 240 кг-аас доошгүй байх,
- Сүүний гарц өдрийн саам нь 4 литрээс багагүй, тослог 4,2 хувь байна

Сарлаг:

- Сарлаг 3-4 настай үнээ 170-200 кг, 4 дээш настай үнээ 210 кг доошгүй жинтэй, сүүний гарц нь 3 литр, тослог нь 5,8-6,2 хувиас багагүй байна.

Монгол хонь:

- 5-р сард охин төлөг 28 кг, 3-аас дээш насны эм хонь нь 36 кг-аас дээш байна. Ноос нь завсрын үсгүй жижиг ноостой.
- Ноосны гарц төлөг 1 кг, эм хонь 1,2-1,3 кг-аас багагүй байна.

Монгол ямаа:

- 5-р сард охин борлон 22-24 кг, бүдүүн эм ямаа 30 кг-аас доошгүй амьдын жинтэй.
- Борлон 3,4 сард 200-210 грамм, нас гүйцсэн эм ямаа 260-270 граммаас багагүй ноолууртай байна.
- Мал авахдаа нэг бүрчлэн үзлэг хийж, жигнэж, номер зүүнэ.

Малчин ядуу өрхүүдийг малжуулалтанд хамруулах шалгуур үзүүлэлтүүд

4.63. Судалгааны гол зорилго нь малжуулах төсөлд хамрагдсан өрхүүдийг ямар шалгуураар сонгосоныг тогтоох явдал байсан тул малжуулах төслийг хэрэгжүүлсэн аймаг, сумын удирдлага, малжуулалтанд хамрагдсан ба хамрагдаагүй малчдаас энэ тухай асуудлаар судалгаа авсан юм.

Хүснэгт 4.20

Малжуулалтанд хамруулах өрхийг сонгосон шалгуур, удирдлагын бодлоор

Өрхийн ангилал	Тоо	Хувь
Огт малгүй ядуу, нэн ядуу өрх	16	20.8
Цөөн малтай, амьжиргааны түвшин доогуур өрх	33	42.9
Ган, зудад малаа хорогдуулж, орлогын эх үүсвэргүй болсон өрх	28	36.3
Нийт дүнгээр	77	100.0

Судалгаанд оролцогсон аймаг сумдын удирдах ажилтнуудын 36.3% нь ган зудад малаа хорогдуулж орлогын эх үүсвэргүй болсон өрхийг сонгон малжуулсан, 63.7% нь цөөн малтай амьдралын түвшин доогуур өрхийг малжуулах төсөлд хамруулсан гэж хариулсан байна.

Хүснэгт 4.21

Малжуулах арга хэмжээнд хамруулсан шалгуур
(Малчдын санал хувиар)

Арга зам	Малжуулалтанд хамрагдсан			Малжуулалтанд хамрагдаагүй өрх
	Малаа өсгөсөн өрх	Малын тоо хэвийн байгаа	Хорогдуулсан огт малгүй болсон	
Багаас нэр дэвшүүлсэн	40.7	32.7	33.3	44.8
Сумаас нэр дэвшүүлсэн	1.8	0.0	12.9	9.2
Өөрөө хүсэлт тавьсан	55.6	65.3	44.2	30.4
Танил нөхөд хөөцөлдөж өгсөн	1.8	2.0	0.7	8.0
Малжуулах байгууллага судалж олсон	0.0	0.0	8.8	5.6

4.64. Малжуулалтанд хамрагдсан өрхүүд ихэнх тохиолдолд өөрөө хөөцөлдөж орсон гэж бодож байхад малжуулалтанд хамрагдаагүй өрхүүд сум, багаас нэр дэвшүүлж оруулсан гэж үздэг байна. Малжуулах арга хэмжээний хэрэгжилтэнд танил тал, найз нөхөд, “ар өврийн хаалга” байгаагүй гэж малжуулалтад хамрагдсан өрхүүд нотолж байхад малжуулалтад хамрагдаагүй өрхүүд зарим нэг тохиолдол байсныг (8.0%) үгүйсгэхгүй байна.

4.65. Дээрх судалгаануудаас харахад малжуулалтанд хамруулах малчин өрхийг сонгосон шалгуур нь ган зудад малаа хорогдуулж, орлогын эх үүсвэргүй болсон өрх болон цөөн малтай, амьжиргааны түвшин доогуур өрх байсан бөгөөд уг өрхүүдийн ихэнхийг сум багаас нэр дэвшүүлэн зарим хэсэг нь өөрөө санал тавин хөөцөөлдсөн ба малжуулах байгууллагын олж тогтоосон нь тун бага хувийг эзэлж байна. Харин малжуулах ажлыг хэрэгжүүлэхэд сум, багийн удирдлага ихэээхэн үүрэг гүйцэтгэжээ.

Хүснэгт 4.22

Удирдлагын гүйцэтгэсэн үүрэг

Удирдлагын үүргүүд	Тоо	Хувь
Аймгийн		
Дүрэм боловсруулсан	13	20.0
Хамрагдах сумдыг тогтоосон	37	60.0
Зохих байгууллагуудтай тохиролцсоны үндсэн дээр хөрөнгийн Эх үүсвэр шийдвэрлэсэн	13	20.0
Сумын		
Дүрэм тодотгох	15	12.9
Малжуулалтанд хамрагдах баг, өрхийг тогтоох	30	25.9
Хөрөнгийн эх үүсвэр хуваарилах	14	12.1
Худалдаж авах малын тоо нас, хүйс чанарыг тогтоох	17	14.7
Мал нийлүүлэх байгууллага хүмүүстэй гэрээ хийх	23	19.7
Малжуулалтын үйл ажиллагаанд хяналт тавих	17	14.7
Баг		
Өрх бүрийн малын гүйцэтгэлийн тооллого явуулах	17	18.3
Малжуулалтанд хамрагдах малчдын нэрсийг гаргаж өгөх	37	39.8
Мал хуваарилж өгөх, толгойн тоо өсөлтөнд хяналт тавих	27	29.0
Нутаг бэлчээр хуваарилах	12	12.9

4.66. Малжуулах төслийг хэрэгжүүлэхэд аймгийн удирдлагын үндсэн үүрэг нь малжуулалтанд хамрагдах сумдыг тогтоох (59.7%), сумдын удирдлагын үндсэн үүрэг нь малжуулалтанд хамрагдах баг өрхийг тогтоох (25.8%), мал нийлүүлэх байгууллага, хүмүүстэй гэрээ хийх (19.8%), харин багийн удирдлагын үндсэн үүрэг нь малжуулалтанд хамрагдах малчин өрхийн нэрсийг зохих дүрэм, зааврын дагуу гаргаж өгөх (39.9%), мал хуваарилах (29.3%) явдал байсан байна.

Хүснэгт 4.23

Малжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлсэн аймаг, сумдын онцлог, давуу ба сул талууд

Аймаг	Төсөл хэрэгжүүлсэн байгууллага	Давуу тал, онцлог	Сул тал
Дундговь	Дэлхийн банк	5 жилийн хугацаатай зээлийн хэлбэрээр мал олгосон ба олгосон малын дотор эр сувай мал өгсөн. Малгүй цөөн малтай өрхийг малжуулахыг эрмэлзсэн. Олон малтай зарим өрх хамаатан садандаа хямд үнээр мал өгөх, зарим нь тэднийг дагалдуулан ажиллуулж малжуулсан. Зарим тохиолдолд сумын төсвөөс мөнгө гаргаж малжуулсан.	Малжуулах арга хэмжээний тайлан, малжуулалтын үр дүнгийн мэдээллийг хугацаанд нь гаргах, хүргэх талаар зарим алдаа дутагдал гарч байсан. Зарим сумын олон малтай өрхүүдийг малжуулсан. Гэтэл цөөн малтай өрхүүд малжуулалтанд хамрагдах хүсэлт гаргасан боловч тэд бүрэн хамрагдаж чадаагүй.
Завхан	Дэлхийн банк “Санкей” сонин Ерөнхийлөгчийн хөдөөг хөгжүүлэх сан	5 жилийн хугацаатай зээлийн хэлбэрээр мал олгосон. Цөөн малтай буюу огт малгүй өрхийг малжуулсан. Бодод шилжүүлсэнээр 10-аас доош тооны малтай, мал маллах туршлагатай өрхийг малжуулах журам хэрэглэсэн.	Өвөлжөө хаваржаагүй нилээд өрхийг малжуулж зөрчил гаргасан. Малжуулалтанд хамрагдах болзолтой өрхүүдийг сонгон шалгаруулахдаа танил тал, ах дүүгээрээ нийлэн багийн хуралд зонхилох шийдвэр гаргуулж байсан.
Баянхонгор	Дэлхийн банк “Санкей” сонин Английн хүүхдийг ивээх сан “Малын буян” төсөл	6 жилийн хугацаатайгаар зээлийн хэлбэрээр олгосон. Малжуулалт явуулсан онцлог зөвхөн ган, зуд болсон хойд талын сумдад хэрэгжүүлсэн. Тодорхой тооны малтай өрхүүдэд мал өгсөн. 1 айлд хамгийн олон мал өгсөн. 3 жилийн хугацаатай, 5 хуьийн хүүтэй зээлээр олгосон.	Багийн хурлаар малжуулалтыг хэлэлцүүлэх нь танил тохой ихтэй хүмүүс малжуулалтанд хамрагдаж байна. Иймд сумдын удирдлага багаас гарч ирсэн хүмүүсийг нягтлан үзэж өөрчилж байх. Галуут сум ганц ч гадны төсөлд хамрагдаагүй дутагдал гарсан.
Хөвсгөл	Хөдөө аж ахуйг хөгжүлэх олон улсын сан Английн түншлэлийн хөтөлбөр	9 жилийн хугацаатайгаар зээлийн хэлбэрээр бод малыг 6 дахь, бог малыг 3 дахь жилээс нь эхлэн эргүүлж төлөх болзолтойгоор олгосон. Ихэнхи сум 10 дээш малтай хөрөнгийн баталгаатай өрхийг малжуулахад анхаарсан. 3 жилийн хугацаатай 5 хувийн хүүтэй олгосон. Малжуулалтыг харьцангуй сайн зохион байгуулсан. Малжуулсан өрхийн малыг вакцинжуулах, даатгалд хамруулах ажлыг сайн хийж байсан.	Зөрчил багатай хэрэгжүүлсэн. Харин малжуулах арга хэмжээний тайлан мэдээллийг хугацаанд нь гаргаж өгөөгүй дутагдал байсан. Малжуулалтанд хамрагдах айлыг зөв сонгож чадаагүйгээс үр дүн буурсан.

ТАВДУГААР БҮЛЭГ : МАЛЖУУЛАЛТЫН ҮР ДҮН, ТҮҮНД НӨЛӨӨЛСӨН ХҮЧИН ЗҮЙЛС

5.1. Энэхүү бүлэгт малжуулалтанд хамрагдсан малчин өрхүүдийг малжуулалтын дараах байдлаар малаа өсгөсөн, малын тоо хэвэндээ байгаа, хорогдуулсан ба огт малгүй болсон гэсэн ангилалд хуваан тэдгээрийн малын тоо, орлого, хэрэглээнд гарч байгаа өөрчлөлтийг малжуулалтын өмнө ба дараах үеэр харьцуулан дүгнэлт өгсөн болно. Мөн малчин өрхүүдийн малаа өсгөсөн ба хорогдуулсан шалтгааныг анкетын судалгааны асуулгад тулгуурлан судлав. Үүний зэрэгцээ малчин өрхүүдийн бүтээмжийг малжуулалтын дараах ба өмнөх байдлаар тооцлоо.

Малжуулалтад хамрагдсан өрхийн малын тоо, бүтэц

5.2. Малжуулалтын үр дүнд үнэлэлт өгөх зорилгоор малжуулалтанд хамрагдсан өрхүүдийн малын тоо, түүний бүтцэд гарсан өөрчлөлтийг малжуулалтанд хамрагдаагүй өрхийнхтэй зэрэгцүүлж үзэв. Малжуулалтанд хамрагдсан 185 өрхийг судалгаанд хамруулсанаас 2003 оны байдлаар малаа өсгөсөн өрх (37.3%) нь дунджаар 134 толгой малтай, малын тоо хэвийн хэмжээнд байгаа өрх (17.8%) нь 84 толгой малтай, малаа хорогдуулсан өрх (44.9%) нь дунджаар 57 толгой малтай байгаа бол малжуулалтанд хамрагдаагүй нэг өрхийн малын дундаж тоо нь 129 байна (5.1-р хүснэгт).

Хүснэгт 5.1

Судалгаанд хамрагдсан өрхийн малын дундаж тоо, толгойгоор

Малын төрөл	Малжуулалтанд хамрагдсан			Малжуулалтанд хамрагдаагүй өрх
	Малаа өсгөсөн өрх	Малын тоо хэвийн байгаа	Хорогдуулсан, огт малгүй болсон	
Малын тоо, бүгд	134.2	84.3	56.6	129.0
Тэмээ	0.3	0.4	0.2	4.6
Адуу	7.8	5.9	3.8	11.8
үхэр	9.3	5.7	2.6	11.8
Хонь	60.3	35.8	26.0	57.4
Ямаа	56.5	36.5	24.0	43.4

5.3. Судалгаанд хамрагдсан нэг өрх малжуулах арга хэмжээний өмнө дунджаар 52 толгой малтай байсан бөгөөд малжуулах арга хэмжээгээр нэг өрхөд 48 толгой мал олгож, нийт 100 толгой малтай болсон байна. Малжуулах арга хэмжээг хэрэгжүүлэх үед улсын дундаж нэг малчин өрхөд 135 толгой мал ногдож байжээ. Малжуулалтаар мал аваад түүнээ өсгөж чадсан өрхүүдийн малын тоо нь хэвийн нөхцөлд ажиллаж байгаа малжуулалтад хамрагдаагүй өрхүүдийн малын дундаж хэмжээнд хүрч чадсан байна. Энэ баримт малжуулалт бол малчин өрхийн амьжиргааг сайжруулах нэн чухал арга хэмжээ болохыг харуулж байна.

5.4. Судалгаанаас үзэхэд малжуулалтаар мал аваад түүнээ өсгөж чадсан өрхүүдийн малын тоо нь малжуупаптанд хамрагдаагүй өрхийн малын тоонд хүрч чадсан байна. Энэ баримт нь малжуулалтаар мал аваад өсгөж чадвал малчин өрхийн амьжиргааг улсын дундаж хэмжээнд хүртэл сайжруулах боломж байгааг харуулж байна.

5.5. Малжуулалтанд хамрагдсан өрхийн малын сүргийн бүтэц малжуулалтанд хамрагдаагүй өрхийнхтэй ерөнхийдөө адил байна.[хүснэгт 5.2]

Хүснэгт 5.2

Судалгаанд хамрагдсан өрхийн малын тооны бүтэц, %

Малын төрөл	Малжуулалтанд хамрагдсан			Малжуулалтанд хамрагдаагүй өрх
	Малаа өсгөсөн өрх	Малын тоо хэвийн байгаа	Хорогдуулсан, огт малгүй болсон	
Малын тоо, бүгд	100.0	100.0	100.0	100.0
Тэмээ	0.2	0.5	0.4	3.6
Адуу	5.8	7.9	6.7	9.1
үхэр	6.9	6.8	4.6	9.1
Хонь	44.9	42.5	45.9	44.5
Ямаа	42.2	42.3	42.4	33.7

Малжуулалтын үр дүнгийн талаарх үнэлэлт

5.6. Судалгаанд оролцсон удирдах ажилтнууд, төсөл хэрэгжүүлэгчид малчдын аль аль нь малжуулах арга хэмжээг илүү өндрөөр үнэлж байна. Тухайлбал, малжуулалтанд хамрагдсан өрхийн 80.3-95.5% малжуулах арга хэмжээг цаг үеэ олсон, зөв арга хэмжээ байсан гэж үнэлсэн байна. Харин малжуулах арга хэмжээнд хамрагдаагүй өрхийн 28.2% нь зөв арга хэмжээг буруу зохион байгуулсан, 11.5% нь нэг их оновчтой арга хэмжээ биш байсан гэж шүүмжлэлтэй ханджээ. Малаа хорогдуулсан, огт малгүй болсон өрхүүд нийтээрээ зөв арга хэмжээ байсан гэж үзэхгүй (19.7%) байна. Энэ хандлага нь үр дүн буурах тусам өсч байна. Тэд малжуулалт нь зөв арга хэмжээ байсан боловч буруу зохин байгуулсан гэж үзэж, сум, орон нутгийн удирдлагын зүгээс эхний ээлжинд туслалцаа, дэмжлэг үзүүлэх хэрэгтэй байсан гэж хариулж байгаа юм.

Хүснэгт 5.3

Малжуулах арга хэмжээ зөв эсэхэд өгсөн үнэлэлт, хувийн жингээр

Үнэлгээ	Малжуулалтанд хамрагдсан			Малжуулалтанд хамрагдаагүй өрх
	Малаа өсгөсөн өрх	Малын тоо хэвийн байгаа	Хорогдуулсан огт малгүй болсон	
Цаг үеэ олсон зөв арга хэмжээ байсан	95.5	87.5	80.3	60.3
Зөв арга хэмжээ боловч буруу зохион байгуулсан	4.5	9.4	18.3	28.2
Нэг их оновчтой арга хэмжээ биш	0.0	3.1	1.4	11.5

5.7. Малжуулах арга хэмжээ хир зэрэг шударга явагдсаныг малжуулах арга хэмжээг хэрэгжүүлсэн аймаг, сум, багийн удирдлагаас судлахад 49.2% нь шударга явагдсан, 33.3% нь малжуулалтанд хамрагдвал зохих өрхүүдийг жигд хамруулж чадаагүй, 6.3% нь шударга бус явагдсан, 9.5% нь малжуулах цаг хугацааг зөв олоогүй гэжээ.

Хүснэгт 5.4

Малжуулалтаар авсан малын тооны өөрчлөлт

Малын төрөл		Аймагууд				Бүгд
		Завхан	Хөвсгөл	Дундговь	Баянхонгор	
Малжуулалтын өмнө	Тэмээ	13		24	45	82
	Адуу	171	155	134	494	954
	Үхэр	206	218	55	470	949
	Хонь	1407	361	829	1200	3797
	Ямаа	943	623	683	759	3008
	Бүгд	**2740**	**1357**	**1725**	**2968**	**8790**
Малжуулалтын дараа	Тэмээ	16		22	9	47
	Адуу	134	178	206	444	962
	Үхэр	59	337	72	420	888
	Хонь	1135	1598	1996	2230	6959
	Ямаа	1164	1954	2105	1385	6608
	Бүгд	**2508**	**4067**	**4401**	**4488**	**15464**
Малын тооны өсөлт, %		**-8.5**	**+200**	**+155.1**	**+51.2**	**+75.9**

5.8. Малжуулалтанд хамрагдсан малчин өрхүүдийн малын тоог малжуулалтын өмнө ба дараах байдлаар зэрэгцүүлэн үзэхэд нийт дүнгээрээ 75,9% өссөнийг аймаг тус бүрээр авч үзвэл, судалгаанд хамрагдсан малчин өрхийн малын тоо Хөвсгөл аймагт 3 дахин, Баянхонгор аймаг 51,2%, Дундговь аймаг 34,6% өссөн байхад Завхан аймагт 8,4% буурчээ. Малын тооны өсөлтийг малын төрлөөр нь авч үзвэл, тэмээ 42,7%, үхэр 6,5%-иар буурч, хонь, ямааны тоо бараг 2 дахин өсч адууны тоо хэвэндээ байна.

5.9. Малын тооны өөрчлөлттэй холбоотойгоор тэдний орлого хэрхэн өөрчлөгдсөнийг тооцов. Судалгаанд хамрагдсан малчин өрхүүдийн орлого малжуулалтын өмнөх үеийнхээс дунджаар 30,2% өссөн байгаа бөгөөд аймгуудаар тооцвол, Завхан аймгийн малчин өрхийн орлого малын тоо цөөрсөнтэй холбоотойгоор буурч, бусад амйгуудад өссөн байна. Малчин өрхийн орлогын бүтцийг малын төрлөөр нь малжуулалтын өмнөх ба дараах байдлаар дараах зургуудаар харуулав.

Зураг 5. Малчин өрхийн орлогын бүтэц



Дээрх зургаас үзэхэд малжуулалтын өмнө малчин өрхийн орлогын 47% үхрээс, 34% ямаанаас олж байсан бол малжуулалтын дараа малчин өрхийн орлогын ихэнх хувийг зөвхөн ямаанаас (59%) олох болжээ.

5.10. Малжуулалтын үр дүнг бүтээмжээр малжуулалтын өмнөх ба дараах үеэр тооцов. Бүтээмжийг тооцоход шаардлагатай мэдээлэл хангалттай бус байсантай холбоотойгоор зөвхөн хөдөлмөрийн бүтээмжийг тооцов. Тухайлбал, бүтээгдэхүүний үйлдвэрлэлд гардаг нийт ба тодорхой хөрөнгө , материалын зардал, хөдөлмөр зарцуулалтын хэмжээг нарийн тооцож бүртгэсэн анхдагч мэдээлэл малчин өрхүүдэд байхгүй байгаа нь бүтээмжийн бусад үзүүлэлтийг тооцох боломж олгоогүй юм. Ийм ч учраас хөдөлмөрийн бүтээмжийг тооцоход шаардлагатай хөдөлмөрийн зардлыг малжуулалтанд хамрагдсан өрхүүдийн хөдөлмөрийн чадвартай хүний тоогоор авсан юм. Хөдөлмөрийн бүтээмжийг тооцохдоо малжуулалтын өмнөх ба дараах үед малчин өрхийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг зах зээлийн өнөөгийн үнээр аймгуудаар нэгтгэн тооцож, малчин өрхүүдийн хөдөлмөрийн чадвартай малчдын тоонд хуваж тодорхойлов.

5.11. Хүснэгтээс харахад малчин өрхийн бүтээмж малжуулалтын дараа Завхан аймгаас (-34.9%) бусад аймгуудад 43,1-104,1% буюу дунджаар 34,7% өссөн байгаа нь өрхийн хөдөлмөрийн чадвартай хүний тоо тогтвортой байхад бүтээгдэхүүний үйлдвэрлэл өссөнтэй,харин Завхан аймагт хөдөлмөрийн бүтээмж буурсан нь.малын тоо хорогдсоноос бүтээгдэхүүний үйлдвэрлэл буурсантай холбоотой байна.

Хүснэгт 5.5

Малчин өрхийн бүтээмжийн өөрчлөлт

Бүтээгдэхүүний төрөл		Аймгууд				Дундаж
		Завхан	Хөвсгөл	Дундговь	Баянхонгор	
Малжуулалтын өмнө	Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, мянган төгрөг	18923.6	17704.0	11428.0	8648.0	14175.0
	Хөдөлмөрийн чадвартай хүний тоо	101	123	144	115	121
	Бүтээмж, төг	187.4	143.9	79.4	75.2	121.4
Малжуулалтын дараа	Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, мянган төгрөг	12.318.3	25.388.0	23.327.4	17.925.6	19.739.8
	Хөдөлмөрийн чадвартай хүний тоо	101	123	144	115	121
	Бүтээмж, төг	121.9	206.4	161.9	155.8	163.1
Бүтээмжийн өөрчлөлт, %		-34.9	+43.1	+104.1	+71.8	+34.7

5.12. Малжуулалт ядуурлыг бууруулахад хир нөлөөлж вэ гэдгийг тодорхойлох зорилгоор малжуулалтанд хамрагдсан малчин өрхүүдийг малын тоогоор нь 50 хүртэл, 50-100 хүртэл, 100-гаас дээш малтай өрх гэж бүлэглээд бүлэг бүрт хамрагдах өрхийн тоог малжуулалтын өмнөх ба дараах үеэр харьцуулан харуулав.

Хүснэгт 5.6

Малчин өрхийг малын тоогоор нь бүлэглэсэн бүлэглэлт

Өрхийн тоо		Аймагууд				Дүн
		Завхан	Хөвсгөл	Дундговь	Баянхонгор	
Малжуулалтын өмнө	Огт малгүй	3	-	-	-	3
	50 хүртэл	17	7	37	27	88
	51-100	15	21	7	12	55
	100 дээш	7	22	5	8	42
Малжуулалтын дараа	Огт малгүй	6	-	-	1	7
	50 хүртэл	17	32	17	7	73
	51-100	9	17	15	19	60
	100 дээш	10	1	17	20	48

Хүснэгтээс үзэхэд 50 хүртэл малтай өрхийн тоо малжуулалтын өмнөх үеийнхээс цөөрч, 50-100 хүртэл малтай ба 100 дээш малтай өрхийн тоо өссөн харагдаж байгаа нь малжуулалт ядуурлыг бууруулахад чухал нөлөө үзүүлсэнийг харуулж байна.

5.13. Үүнээс үзэхэд малжуулалт нь малчдын амьдралд тодорхой хэмжээгээр сайн нөлөө үзүүлсэн гэдэг нь тодорхой байна. Малжуулах арга хэмжээний үр дүнд малчин өрхийн орлого, хөрөнгө нэмэгдэж, хэрэглээ өссөнийг малжуулах арга хэмжээнд хамрагдсан малчид хүлээн зөвшөөрч байна. Гэхдээ малжуулалтын дараа малаа өсгөж чадаагүй буюу хорогдуулсан, огт малгүй болсон өрхүүдийн хувьд малжуулалтын үр дүнд сэтгэл дундуур байдаг явдал ажиглагдаж байна. Тухайлбал, малаа өсгөсөн өрхийн 42,9% нь өрхийн орлого өссөн , 32,2 %нь хэрэглээ өссөн, 20,1% нь хөрөнгө нэмэгдсэн гэж хариулжээ.

5.14. Харин малын тоо хуучин хэмжээндээ байгаа болон малаа хорогдуулсан өрхүүд өрхийн орлого, хэрэглээ өссөн гэж хариулж байгаа боловч 22.8-23.6 % нь урьдахаасаа өөрчлөгдөөгүй гэж хариулсан байна.

Хүснэгт 5.7

Малжуулах арга хэмжээний малчдын амьдралд нөлөөлсөн нөлөөлөл, саналын хувийн жингээр

Нөлөөлөл	Малжуулалтанд хамрагдсан		
	Малаа өсгөсөн өрх	Малын тоо хэвийн байгаа	Хорогдуулсан огт малгүй болсон
Өрхийн орлого нэмэгдсэн	42.9	35.1	29.7
Өрхийн хөрөнгө нэмэгдсэн	20.2	14.0	9.5
Хэрэглээ өссөн	32.2	22.8	20.3
Өртэй үлдсэн	1.3	5.3	16.9
Урьдахаасаа өөрчлөгдөөгүй	3.4	22.8	23.6

5.15. Малжуулах ажлын үр дүнг харуулах зорилгоор малжуулалтанд хамрагдсан ба хамрагдаагүй өрхүүдийн удаан эдэлгээтэй, үнэ цэнэтэй хөрөнгүүдийн хангамжийг судлаж үзлээ. Машин, мотоцикль, цахилгааны эх үүсвэр зэрэг нь үнэн хэрэгтээ өрхийн зайлшгүй хэрэглээний хэрэгслүүд боловч малчдын амьжиргааны түвшин доогуур байгаагаас тэр болгон худалдан авах чадваргүй байдаг юм.

Судалгаанаас үзвэл, мал хөрөнгийн хэмжээ нэмэгдэх тусам машин, мотоцикль, нар, салхины цахилгаан эх үүсвэр зэрэг хэрэглээний чанартай үнэ цэнэтэй хөрөнгө бүхий өрхийн хувийн жин нэмэгдэж байна.

Хүснэгт 5.8

Судалгаанд хамрагдсан малчин өрхийн хөрөнгийн хангамж
(нийт дүнд эзлэх хувийн жингээр)

Хөрөнгийн төрөл	Малжуулалтанд хамрагдсан			Малжуулалтанд хамрагдаагүй өрх
	Малаа өсгөсөн өрх	Малын тоо хэвийн байгаа	Хорогдуулсан огт малгүй болсон	
Машин	0.0	9.1	6.0	16.8
Мотоцикль	23.2	15.2	22.9	30.9
Нар, салхины цахилгаан үүсгүүр	11.6	0.0	4.8	10.7

5.16. Малжуулалтанд хамрагдсан өрхийн хөрөнгийн хангамж малын тоо нэмэгдэх тутам сайжрах хандлагатай байгаа боловч малжуулалтад хамрагдаагүй өрхийн хэмжээнд хүрээгүй байна. Харин малаа өсгөсөн өрхийн хувьд нилээд ойртжээ.

Хүснэгт 5.9

Судалгаанд хамрагдсан малчин өрхийн хөрөнгийн хангамж, аймгаар
(нийт дүнд эзлэх хувийн жингээр)

Хөрөнгийн төрөл	Дундговь	Завхан	Баянхонгор	Хөвсгөл
Машин	4.1	4.9	10.6	4.0
Мотоцикль	38.8	22.0	19.5	8.0
Нар, салхины цахилгаан үүсгүүр	10.2	4.9	7.3	4.0
Машин	8.3	22.0	20.4	12.0
Мотоцикль	33.3	32.0	20.4	40.0
Нар, салхины цахилгаан үүсгүүр	20.8	8.0	13.0	6.0

5.17. Бидний судалгаагаар малжуулалтад хамрагдаад авсан малаа хорогдуулсан ба огт малгүй болсон өрхийн машин, мотоциклийн хангамж өндөр байгаа нь ажиглагдсан юм. Энэ нь дараах шалтгаануудаар тайлбарлагдаж байна.Үүнд:

- Малжуулах өрхийг оновчтой бус сонгосноос зарим нь малжуулалтаар авсан малаа зарж, машин, мотоцикль авч унахыг урьтал болгосон
- Зарим нь мал маллаж чадахгүйгээ ойлгож, зээлээ дараа төлөх хөрөнгийн эх үүсвэр бий болгох зорилгоор машин, мотоцикль авсан.

Малчин өрхийн үнэ цэнэтэй хөрөнгийн хангамж орон нутгийн хэрэгцээ,

уламжлалаас хамааран аймгуудад харилцан адилгүй байдаг.

Шигтгээ 4.

Одооны машин унаж тансаглах дуртай залуучуудад мал өгсөнд орвол шууд машины нь өгчихвөл дээр юм даа. Мал нь маллаж чаддаг хүн дээрээ байвал өсч цржээд улсад хэрэгтэй.

Завхан аймгийн Цэцэн-Уул сумын өндөр настны яриа

5.18. Судалгаанаас үзвэл, Дундговь, Завхан аймагт мотоциклийг давуутай хэрэглэж байхад Баянхонгорт машиныг илүүд үздэг байна. Харин нар салхины цахилгаан үүсгүүрийн хангамж Дундговь, Баянхонгор аймагт илүү байгаа нь говийн бүсэд нар, салхи жилийн дөрвөн улиралд хангалттай байдгаар тайлбарлагдах юм.

5.19. Хэрвээ малжуулах арга хэмжээ аваагүй бол байгалийн гэнэтийн аюулд нэрвэгдэж амьжиргааны эх үүсвэрээсээ салсан малчдын нилээд хэсэг нь хот суурин газар руу нүүж амьдрал хайх (11.8-25.7%) байжээ. Ихэнх нь яахаа сайн мэдэхгүй байсан (36.2-44.1%) байна. Малжуулах арга хэмжээнд хамрагдаагүй хөндлөнгийн өрхүүдийн санал ч дээрхээс нэг их хол зөрөхгүй байна. Малжуулах арга хэмжээнд хамрагдаагүй хөндлөнгийн өрхүүдийн ах дүүгээ бараадаж амьдрах байсан байх гэсэн саналтай малаа хорогдуулсан малчид санал нийлэхгүй байжээ. Энэ нь хөдөөгийн малчдын хүний мал хариулж зарц болохгүй гэсэн бодлын илэрхийлэл болж байгаа юм.

Шигтгээ 5

"Манайх малаа өсгөж чадаагүй боловч сүүлийн гурван жил засгаас өгсөн малын буянгаар хоолтой ундтай, хүний зэрэгтэй амьдарч, хоёр хүүхдээ сургууль завсардуулахгүй явуулж ирсэн. Малчин бидэнд үүнээс илүү тус гэж юу байх вэ."

Завхан аймгийн Эрдэнэхайрхан сумын малчин эмэгтэйн яриа

Хүснэгт 5.10

Малжуулах арга хэмжээ аваагүй бол яах байсан бэ

Арга замууд	Малжуулалтанд хамрагдсан			Малжуулалтанд хамрагдаагүй өрх
	Малаа өсгөсөн өрх	Малын тоо хэвийн байгаа	Хорогдуулсан огт малгүй болсон	
Яахаа сайн мэдэхгүй байсан	38.4	44.1	36.2	28.4
Хот суурин газар руу нүүж ажил хийх байсан	13.7	11.8	25.7	11.9
Өөр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх байсан	6.8	2.9	9.5	6.0
Ах дүүгээ бараадаж амьдрах байх	4.1	8.8	6.7	11.9
Айлын мал хариулах байсан	8.2	5.9	9.5	7.5
Бусад	28.8	26.5	12.4	
Яах байсныг нь би сайн мэдэхгүй байна				34.3

5.20. Малчдын идэвхтэй хэсэг нь өөр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх (6.8-9.5%) бодолтой байжээ. Хөндлөнгийн ажиглагч өрхүүдийн хувьд малжуулах арга хэмжээ аваагүй нөхцөлд зудад малаа хорогдуулсан малчдын яах байсныг сайн мэдэхгүй (34.3%) гэж хариулжээ.

5.21. Бидний судалгаанд хамрагдсан өрхүүдээс малаа өсгөсөн өрхийн тоо аймаг бүрт харилцан адилгүй хувийн жинтэй байв. Тухайлбал, Малаа өсгөсөн өрхийн эзлэх хувийн жин Хөвсгөл аймагт хамгийн их буюу 58,3%, Дундговь, Баянхонгор аймагт 38,0%, харин Завхан аймагт 9,5% буюу нийт 4 өрх л малаа өсгөсөн байна.

Хүснэгт 5.11

Малжуулалтанд хамрагдаад малаа өсгөсөн өрхийн тоо

	Аймгууд				Бүгд
	Завхан	Хөвсгөл	Дундговь	Баянхонгор	
Судалгаанд хамрагдсан нийт өрх	42	48	49	47	186
Үүнээс малаа өсгөсөн өрх	4	28	19	18	69
Малаа өсгөсөн өрхийн эзлэх хувийн жин	9.5	58.3	38.7	38.2	37.0

5.22. Энэ нь байгаль цаг уурын нөхцөл, малжуулалт явуулсан улирлаас ихээхэн хамаарч байна. Өөрөөр хэлбэл, Завхан аймагт малжуулалтаар мал өгсний дараах жил ган, зуд болж зарим сумдад малыг 12-р сард өгсөн нь мал хорогдох гол шалтгаан болсон байна. Гэвч малжуулах төслийг хэрэгжүүлсэн арга хэлбэр, хугацаа төсөлд хамрагдах малчин өрхийг сонгосон шалгуур, малын чанар малжуулалтын үр дүнд ихээхэн нөлөө үзүүлсэн байна. Тухайлбал, Завхан аймагт малжуулсан хугацаа оновчтой бус байснаас малжуулах төсөл хамгийн үр дүнтэй явагдаж байгаа гэж удирдлага нь дүгнэж байгаа Сантмаргац суманд малжуулалтанд хамрагдсан 66 өрхөөс зөвхөн 10 өрхийн мал өссөн байв.

5.23. Малчдын малжуулалтаар авсан малаа өсгөсөн шалтгааныг тодруулах зорилгоор тэднээс малаа өсгөхөд ямар хүчин зүйл нөлөөлсөн бэ гэдэг асуулгаар судалгаа авсан юм

Хүснэгт 5.12

Малжуулалтаар авсан малаа өсгөсөн шалтгаан, хувийн жингээр

Шалтгаан	Малжуулалтанд хамрагдсан			Малжуулал-танд хамрагдаа-гүй өрх
	Малаа өсгөсөн өрх	Малын тоо хэвийн байгаа	Хорогдуул-сан огт малгүй болсон	
Цаг агаар сайхан байсан	25.6	30.0	6.7	0.0
Авсан малаа өсгөе гэж хичээл зүтгэл гаргасан	58.6	50.0	28.3	51.4
Ах дүү, нутгийн хүмүүс дэмжиж тусалсан	7.3	15.0	25.0	21.6
Баг, сумаас дэмжлэг үзүүлсэн	7.3	5.0	28.3	27.0
Бусад	1.2	0.0	11.7	0.0

Судалгаанаас үзэхэд малжуулалтаар авсан малаа өсгөсөн шалтгаан нь байгаль цаг агаар таатай байснаас гадна тэдний өөрсдийн хүчин зүтгэлтэй холбоотой байна. Малжуулалтанд хамрагдаагүй өрхүүд тэдний малаа өсгөхөд цаг агаар биш харин малчдын хичээл зүтгэл илүү нөлөөлсөн (51.4%) гэж хариулжээ. Малжуулалтаар авсан малыг зарим өрхүүд хорогдуулж, цөөн тооны айлууд огт малгүй болсон тохиолдол судалгаа авах явцад гарч байсан билээ.

5.24. Малжуулалтад хамрагдсан өрхийн малаа хорогдуулсан буюу огт малгүй болсон шалтгааныг илрүүлэх зорилгоор санал асуулга авахад тэдний 50.0-59.2 % нь байгалийн бэрхшээл тохиолдсон, 15.8-28.6 % нь өрхийн хэрэгцээнд хүрэлцэхгүй цөөн мал өгсөн хариулж байгаа боловч энэ талаар бусад хүмүүсийн бодол өөр байна.

Хүснэгт 5.13

Малжуулалтаар авсан малаа хорогдуулсан шалтгаан, саналын хувийн жингээр

Шалтгаан	Малжуулалтанд хамрагдсан			Малжуулал-танд хамрагдаа-гүй өрх
	Малаа өсгөсөн өрх	Малын тоо хэвийн байгаа	Хорогдуул-сан огт малгүй болсон	
Байгалийн бэрхшээл тохиолдсон	31.4	50.0	59.2	27.6
Туршлага дутагдсан	0.0	3.6	2.6	13.3
Тэжээл бэлдээгүй	21.1	3.6	6.6	11.2
Өөрийн өвөлжөө байгаагүй	5.3	0.0	0.0	0.0
Малд өвчин гарсан	10.5	0.0	2.6	3.1
Чанар муутай мал өгсөн байсан	5.3	7.1	5.3	18.4
Гэр бүлийн хэрэгцээнд хүрэхгүй цөөн мал байсан	26.4	28.6	15.8	7.1
Өөрсдийн залхуу арчаагүйгээс болсон	0.0	7.1	5.3	19.3
Зээлээ төлөх хугацаа болсноос эргүүлж зарсан	0.0	0.0	2.6	0.0

Тухайлбал, малаа өсгөсөн болон малжуулалтанд хамрагдаагүй өрхүүд үүнийг гол шалтгаан (15.8%, 27.6%) гэж үзэхгүй байна. Хөндлөнгийн ажиглагч өрхүүд малаа өсгөж чадаагүй шалтгаанд малчдын өөрсдийн залхуу, арчаагүй байдал (19.3%), чанаргүй малаар малжуулсан явдалтай (18.4%) холбон үзэж байна. Судалгаанд хамрагдсан өрхүүдээс малжуулалтаар авсан малаа хорогдуулсан өрх Завханд 27, Хөвсгөлд 12, Дундговьд 22, Баянхонгорт 22, нийт 83 байна.

5.25. Ер нь байгаль цаг уурын ижилхэн нөхцөлд байгаа атлаа тодорхой хүмүүс малаа өсгөөд байхад зарим нь хорогдуулна гэдэг бол яах аргагүй малчны үйл ажиллагаатай холбоотой юм. Эндээс үзэхэд малчдын малаа хорогдуулахад нөлөөлсөн гол хүчин зүйл нь байгаль цаг уурын бэрхшээл боловч малын хорогдолд дээрх бусад хүчин зүйлүүд нөлөөлсөн нь ч ойлгомжтой. Малчдын ядуурлын гол шалтгаан болсон ган, зудын өмнө малчид үнэхээр хүчин мөхөс байдаг уу, эсвэл малчдын үйл ажиллагаанаас хамаардаг уу гэдгийг гэдгийг тодруулах асуултуудыг судалгаанд хамрагдсан малчдаас асуухад ган зудад малаа хорогдуулж байгаагийн гол шалтгааныг цаг агаарын туйлын хүнд нөхцөл байсан гэж тэд ихэнхдээ үзэж байгаа

боловч малжуулалтанд хамрагдаагүй ба хамрагдаад малаа өсгөсөн өрхүүдийн хувьд энэ хувийн жин нь харьцангуй доогуур байгаа нь цорын ганц шалтгаан биш ээ гэдгийг харуулж байгаа юм.

5.26. Тэд тэжээл, хашаа байраар хангах, отор нүүдэл хийх, мал маллагааны туршлага дутагдах зэрэг малчидтай холбоотой бусад шалтгаануудыг нэрлэсэн байна. Малаа өсгөж чадаагүй өрхүүд, малжуулалтанд хамрагдаагүй өрхүүд малын хорогдолд туршлага дутагдах явдал их нөлөөтэй байсан гэж хариулжээ.

Хүснэгт 5.14

Ган, зудад малаа хорогдуулсан шалтгаан
(саналын хувийн жингээр)

Шалтгаанууд	Малжуулалтанд хамрагдсан			Малжуулалтанд хамрагдаагүй өрх
	Малаа өсгөсөн өрх	Малын тоо хэвийн байгаа	Хорогдуулсан огт малгүй болсон	
Цаг агаар туйлын хүнд байсан	49.2	59.0	35.7	39.9
Тэжээл дутагдсан	15.7	10.3	21.4	21.6
Хашаа байр муутай	5.3	5.1	8.2	10.6
Отор, нүүдэл хийгээгүйгээс	5.3	5.0	10.5	10.1
Туршлага дутсан	4.5	7.7	6.6	9.2
Хүн, хүч хүрэлцээгүй	14.7	10.3	8.8	8.6
Муу мал өгсөн	5.3	2.6	8.8	0.0

Өөрөөр хэлбэл,тэд тэжээл байраар хангах, отор нүүдэл хийх, мал маллагааны туршлага дутагдах, зэрэг малчидтай холбоотой бусад шалтгаануудын улмаас мал ихээр хорогдож байна гэж үзжээ. Эдгээр шалтгаануудаас гадна малчидын үйл ажиллагаатай холбоогүй бусад шалтгаанууд ч нөлөөлсөн байна. Тухайлбал, зах зээлээс алслагдмал орших, бүтээгдэхүүний борлуулалтын систем оновчгүй байх, мал аж ахуйн гаралтай түүхий эдийн зах зээлийн үнэ гэх мэт.

5.27. Байгаль цаг уурын нөхцөл ихээхэн хүнд байгаагаас гадна бэлчээр үлийн цагаан оготонд идэгдэх, өөр аймаг сумаас айл нүүж ирэх, бэлчээрийг сайжруулах талаар аймаг, сум, малчдын хүрээнд тодорхой ажил хийхгүй байгаагаас бэлчээр талхлагдаж байна. Үүнээс болж малчдын дунд бэлчээр усны маргаан гарах болжээ. Малжуулалтад хамрагдсан нийт өрхийн 22.5%, малжуулалтад хамрагдаагүй өрхийн 19.0% нь бэлчээр, усны маргаан гардаг гэж анкетийн судалгаанд хариулсан байна. Эдгээр баримтууд нь малын бэлчээр бүрэн хүрэлцээтэй гэж үзэх үндэслэл байхгүй байгааг харууллаа.

Шигтгээ 6.

Бэлчээрийн доройтол1998 он

Ангилал	*Км²*	*Газар нутагт эзлэх хувь*
Доройтоогүй	*21.841*	*1.7*
Бага зэрэг /10%/	*320.629*	*25.4*
Дунд зэрэг /20%/	*643.061*	*50.8*
Их хэмжээгээр /30%/	*260.274*	*20.7*
Маш их хэмжээгээр /50%/	*18.145*	*1.4*

"БОЯ. НҮБХХ. Даян дэлхийн байгаль орчны сан. Монгол орны биологийн баялгийн үндэсний тайлан 1998

5.28. Судалгааны дүнд тулгуурлан малчин өрхийн малын тоог нэмэгдүүлж, чанарыг сайжруулах замаар малчдын амьжиргааг сайжруулах нэг гол арга бол мал аж ахуй эрхлэх нөхцлийг нь бүрдүүлэх асуудал гэдэгт түшиглэн малжуулах арга хэмжээг бэлчээрийн менежментийг боловсронгуй болгох асуудалтай зөв хослуулан шийдвэрлэх шаардлагатай байсан гэдэг дүгнэлт хийж байна.

5.29. Малчин өрхийн малаа хорогдуулсан шалтгааныг тогтоох зорилгоор малаа өсгөсөн, хэвийн байгаа, хорогдуулсан малчдын нас, боловсрол, үйлдвэрлэл явуулж байгаа нөхцөл зэрэг нийгмийн, ахуйн, үйлдвэрлэлийн нөхцлийг судалж үзэв. Судалгаанд дөрвөн аймгийн малжуулалтанд хамрагдсан 185 өрх, малжуулалтанд хамрагдаагүй 178 өрх, үүнээс 33 өрхийн тэргүүлэгч нь эмэгтэй өрх хамрагджээ.

Хүснэгт 5.15

Судалгаанд хамрагдагсан малчдын тодорхойлолт, аймгаар

	Дундговь	Завхан	Баянхонгор	Хөвсгөл	Бүгд
Судалгаанд хамрагдсан, бүгд	49	42	44	50	185
Үүнээс: өрх толгойлсон эмэгтэй	6	9	14	4	33
Судалгаанд оролцогсодын дундаж нас	40.5	41.7	39.3	37.4	40.1
Мал малласан хугацаа, жилээр	22.8	17.7	17.3	11.5	17.5

5.30. Аймгийн болон малжуулалтанд хамрагдсан сум, багийн удирдлагын 57, малжуулах арга хэмжээг хэрэгжүүлсэн байгууллагын 23 хүнээс санал асуулга авлаа. Судалгаанд оролцсон аймаг, сумын удирдах ажилтнууд, багийн Засаг дарга нарын нилээд нь малжуулах төслийн хэрэгжилтэнд оролцож байжээ.

5.31. Судалгаанд хамрагдагсан малчдын дундаж нас аль ч аймагт дөч орчим байв. Тэд дунджаар 17.5 жил мал малласан байна. Дундговь аймагт харьцангуй олон жил мал малласан малчид судалгаанд хамрагдсан бол Хөвсгөл аймгаас цөөн жил мал малласан хүмүүс судалгаанд оролцжээ.

Хүснэгт 5.16

Судалгаанд хамрагдсан малчдын тодорхойлолт,
малжуулалтын үр дүнгээр

Үзүүлэлтүүд	Малжуулалтанд хамрагдсан		
	Малаа өсгөсөн өрх	Малын тоо хэвийн байгаа	Хорогдуулсан огт малгүй Болсон
Судалгаанд хамрагдсан, бүгд	69	33	83
Дүнд эзлэх хувь	37.3	17.8	44.9
Үүнээс: өрх толгойлсон эмэгтэй	7	7	19
Судалгаанд оролцогсодын дундаж нас	40.5	39.8	39.9
Мал малласан хугацаа, жилээр	14.8	20.1	16.2

5.32. Малжуулалтанд хамрагдсан өрхийн ам бүлийн гишүүдийн нас, хүйсний байдал, хөдөлмөрийн чадвар, ажлын дадлага туршлага малжуулах арга хэмжээний үр дүнд хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлох зорилгоор тэдний нас, хүйс, мал малласан хугацааг малаа өсгөсөн, мал нь хэвийн байгаа, малаа хорогдуулсан өрхөөр

ялгаж судлав. Судалгаанд хамрагдсан нийт өрхийн 55.1% нь малаа өсгөсөн ба анх байсан хэмжээнд нь байлгаж байгаа, 44.9% нь малаа хорогдуулсан огт малгүй болсон өрхүүд байна. Харин эмэгтэй тэргүүлэгчтэй өрхийн дотор малаа өсгөсөн өрх 21.2%, малаа хорогдуулсан буюу огт малгүй болсон өрх 57.6%-ийг эзэлж байгаа нь өрх толгойлсон эмэгтэйчүүдэд сэтгэл санааны дарамт, хөрөнгө мөнгөний хүрэлцээгүй байдал, ганцаараа бие даан хүүхдээ өсгөх зэрэг шалтгаанаар мал аж ахуй эрхлэхэд хүчин дутагдагийг харуулж байна. Үүнээс үзэхэд мал малласан хугацаа малын хорогдолд нөлөө үзүүлээгүй байна. Харин хүйсний байдал малын хорогдолд тодорхой хэмжээгээр нөлөөлжээ.

Боловсрол

5.33. Малжуулах арга хэмжээний үр дүнд малчдын боловсролын түвшин хир нөлөөтэйг илрүүлэх зорилгоор малжуулалтанд хамрагдагсадын боловсролын түвшинг судлаж үзэхэд дараах байдалтай байна. **Малчдын боловсролын түвшин нь малын тооны өсөлтөнд төдий л нөлөөтэй биш байна.** Ялангуяа малжуулалтаар авсан малаа хорогдуулсан буюу огт малгүй болсон өрхийн дотор дээд, тусгай дунд боловсролтой хүмүүсийн эзлэх хувийн жин өндөр (41.1%) байгаа нь малжуулалтаас өмнө албан хаагч байгаад ажилгүй болсон хүмүүсийг өргөнөөр хамруулсантай холбоотой байж болох талтай.

Хүснэгт 5.17

Судалгаанд хамрагдагсан малчдын боловсролын байдал,
хувийн жингээр

Боловсролын түвшин	Малжуулалтанд хамрагдсан		
	Малаа өсгөсөн өрх	Малын тоо хэвийн байгаа	Хорогдуулсан огт малгүй болсон
Дээд	2.9	2.8	21.0
Тусгай дунд	11.8	13.9	20.2
Бүрэн дунд	32.4	25.0	12.9
Бүрэн бус дунд	38.2	13.9	22.5
Бага.	13.2	30.5	16.9
Боловсролгүй	1.5	13.9	6.5

5.34. Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх нэн чухал нөхцөл нь өөрийн эзэмшлийн өвөлжөө, хаваржааны хангамжийн асуудал юм. Малчдын дийлэнх хэсэг нь өөрийн эзэмшлийн өвөлжөөтэй байдаг боловч малын тоо нь цөөрөх тусам өвөлжөөний хангамжийн хувь буурах хандлага харагдаж байна. Малчин өрхийн бэлчээр эзэмших эрх нь өвөлжөө, хаваржаагаар дамжин хэрэгжиж байдаг.

5.35. Сайн бэлчээр бүхий нутагт өөрийн өвөлжөөтэй бол тэр хавийн бэлчээрийг эзэмших эрхтэй болдог. **Гэтэл цөөн малтай, өөрийн эзэмшлийн өвөлжөө хаваржаагүй малчдад мал өгөөд бэлчээр нутаг, усны асуудлыг шийдээгүй орхисон нь малжуулалтад хамрагдсан олон малчин малаа хорогдуулах нэг шалтгаан байж болох юм.**

Хүснэгт 5.18

Өвөлжөө хаваржааны хангамж, бэлчээрийн хүрэлцээ
(нийт дүнд эзлэх хувийн жингээр)

Хөрөнгийн Төрөл	Малжуулалтанд хамрагдсан			Малжуулалтанд хамрагдаагүй өрх
	Малаа өсгөсөн өрх	Малын тоо хэвийн байгаа	Хорогдуулсан огт малгүй болсон	
Өөрийн өвөлжөөтэй	81.2	63.6	56.6	72.0
Өөрийн хаваржаатай	47.8	39.4	36.1	46.0
Өвөл хаврын бэлчээр хүрэлцээтэй гэж үзэж байгаа малчин өрх	63.8	63.6	61.4	68.0

5.36. Малчдын дийлэнх хэсэг нь өөрийн тогтсон хаваржаагүй байгаа ба түүний дотроос малаа хорогдуулсан өрхийн илүү хувь нь хаваржаагүй байна. Судалгаанд оролцогчдын барагцаалбал гуравны хоёр хувь нь малын бэлчээрийг хүрэлцээтэй гэж үзжээ. Малаа хорогдуулсан шалтгааныг тодруулсан анкетын судалгаагаар малын хорогдлын шалтгааныг өвс тэжээл хангалтгүй бэлтгэх, хашаа байрны хомсдол, мал маллагааны арга ухаан дутагдах зэрэг нь малжуулалтын үр дүнд сөргөөр нөлөөлсөн зүйлс болжээ гэж харагдаж байна.

5.37. Энэ бүхнээс дүгнэж үзвэл, малчин өрхийн малаа хорогдуулсан шалтгаан нь тэдний нас, боловсрол, ахуйн нөхцөлтэй холбоотой биш харин ган зудын бэрхшээл, малчдын өөрсдийнх нь үйл ажиллагаатай холбоотой байна.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ : МАЛЖУУЛАХ АРГА ХЭМЖЭЭГ БОЛОВСРОНГҮЙ БОЛГОХ АРГА ЗАМ

6.1. Энэхүү бүлэгт малжуулах арга хэмжээг илүү үр дүнтэй болгох арга замуудыг малжуулалтанд хамрагдсан ба хамрагдаагүй хөндлөнгийн ажиглагч өрхүүд, удирдах ажилтануудын саналд тулгуурлан тодорхойлж, малчдын ирээдүйн талаархи санал бодлыг тусгалаа. Мөн малчин өрхүүдийн үндсэн хэрэглээнүүдийн хангамжийн байдлыг хэрэглээ нь хангагдсан гэж үзэж байгаа өрхүүдийн хувийн жингээр тооцов.

Малжуулах арга хэмжээг боловсронгуй болгох арга замын талаарх бодол санал

6.2. Малжуулах арга хэмжээ нь малчдын амьжиргааны байдлыг дээшлүүлэх үндсэн арга учраас хэрэгжүүлсэн малжуулалтыг илүү үр дүнтэй болгох арга замуудыг судалгаанд хамрагдагсад өөрсдийн үнэлэмжээр үнэлсэн байна.

Хүснэгт 6.1

Малжуулалтыг илүү үр дүнтэй болгох байсан арга замууд

Арга замууд	Малжуулалтанд хамрагдсан			Малжуулалтанд хамрагдаагүй өрх
	Малаа өсгөсөн өрх	Малын тоо хэвийн байгаа	Хорогдуулсан огт малгүй болсон	
Нэг өрхөд илүү олон мал өгсөн бол	32.6	50.0	23.6	19.7
Эргүүлж төлөх болзолтой бол	4.7	0.0	12.7	15.2
Эргүүлж төлөх болзолгүй бол	9.3	4.6	8.2	8.3
Айл өрхийг сонгон шалгаруулсан бол	16.2	13.6	16.4	33.3
Өөр үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх боломж олгосон бол	4.6	9.1	19.1	9.1
Өндөр ашиг шимийн малаар малжуулсан бол	32.6	22.7	20.0	14.4

6.3. Тухайлбал, малжуулалтанд хамрагдаагүй өрхүүд малжуулалтанд хамрагдах айл өрхүүдийг сайн сонгон шалгаруулсан бол (31.6-56,3%) үр дүнтэй болох байсан гэж үзэж байхад малжуулалтад хамрагдсан өрхүүд нэг өрхөд өгсөн малын тоо олон байсан бол (23.6-50.0%) үр дүнтэй болох байсан гэж үзжээ. Харин малжуулалтад хамрагдаагүй өрхүүд энэ бодлыг дэмжихгүй (19.7%) байна. Судалгаанд хамрагдсан малчдын нэлээд хэсэг нь малжуулах арга хэмжээг өндөр ашиг шимтэй, чанар сайтай малаар хэрэгжүүлсэн бол илүү үр дүн гарах байсан гэжээ.

6.4. Нийт судалгаанд оролцсон удирдах ажилтнуудын 41.3% нь малыг гэрээ, түрээсийн хэлбэрээр өгсөн бол, 20.6% нь малжуулалтыг буцалтгүй тусламжийн хэлбэрээр хийсэн бол, 17.5% нь зээлийн хэлбэрээр олгосон бол, 15.9% нь хамт олныг малжуулсан бол үр дүнтэй болох байсан гэж үзсэн байна. Үүнийг дараах хүснэгтэнд харууллаа.

Хүснэгт 6.2

Малжуулалтын арга хэлбэрийг боловсронгуй болгох санал

Арга хэлбэр	Тоо	Хувь
Малжуулалтыг буцалтгүй тусламжийн хэлбэрээр хийсэн бол	13	21.7
Зээлээр олгосон бол	11	18.3
Хамт олныг малжуулсан бол	10	16.7
Малыг гэрээ түрээсийн хэлбэрээр өгсөн бол	26	43.3

Малчдын ирээдүйн талаарх төсөөлөл

6.5. Малчдын одоогийн амьдралын эх үүсвэртээ сэтгэл хангалуун байгаа эсэх нь ирээдүйн талаарх төсөөллөөр нь иларч байна. Олон малчин өрх мал аж ахуй эрхэлж амьдрах явдлыг ирээдүй муутайд тооцож, цаашдаа амьдралын өөр хэв маягийг хайх, үгүйдээ л үр хүүхдээ ирээдүйд малчин болгохоос татгалзаж байна.

Хүснэгт 6.3

Ирээдүйн амьдралын талаарх санал, бодол

Үзүүлэлтүүд	Малжуулалтанд хамрагдсан			Малжуулал-танд хамрагдаа-гүй өрх
	Малаа өсгөсөн өрх	Малын тоо хэвийн байгаа	Хорогдуул-сан огт малгүй болсон	
Малаа өсгөж орон нутагтаа амьдарна	86.5	70.8	50.5	81.1
Дахин малжуулах арга хэмжээ авах байх гэж хүлээж байна	6.75	2.8	8.7	0
Хот суурин газар луу нүүж ажил хийх санаатай	6.75	4.2	7.8	0
Ах дүүгээ бараадаж амьдрах байх	0	1.4	3.9	0
Айлын мал хариулах байх	0	0	1.9	3.8
Өөр үйлдвэрлэл үйлчилгээ эрхэлнэ	0	6.6	8.7	0
Яахаа сайн мэдэхгүй байна	0	14.2	18.5	0
Малын чанараа сайжруулна				15.1

6.6. Малаа өсгөсөн өрхүүдийн ихэнх нь орон нутагтаа мал аж ахуйгаа эрхлэж амьдарна (86.5%), малаа хорогдуулсан ба огт малгүй болсон өрхүүдийн 7.8% нь хот суурин газар уруу нүүж ажил хийнэ, 8.7% нь өөр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэнэ гэсэн хүсэл эрмэлзлэлтэй байна. Малаа өсгөж чадаагүй буюу хорогдуулсан өрхүүдийн 50-60% нь цаашдаа мал аж ахуй эрхлэн амьдрах хүсэлгүй байна.

6.7. Мал аж ахуй эрхлэж амьдрах нь цөөн малтай өрхийн хувьд ирээдүйгүй, малаа өсгөж чаддаг өрхийн хувьд ирээдүйтэй ажил гэж боддог болох нь дараах хүснэгтээс харагдаж байна.

Хүснэгт 6.4

Мал аж ахуй эрхлэж амьдрах нь хир ирээдүйтэй вэ

Үнэлгээ	Малжуулалтанд хамрагдсан			Малжуулал-танд хамрагдаа-гүй өрх
	Малаа өсгөсөн өрх	Малын тоо хэвийн байгаа	Хорогдуул-сан огт малгүй болсон	
Ирээдүйтэй гэж боддог	61.2	54.8	57.3	62.9
Ер нь эргэлзээтэй ажил болоод байна	34.3	29.0	26.8	30.6
Мал аж ахуйгаар амьдрах аргагүй болжээ	4.5	16.2	15.9	6.5

6.8. Малжуулах арга хэмжээ ядуу малчин өрхийн амьжиргааг сайжруулахад зохих хэмжээгээр нөлөөлсөн боловч тэдний амьжиргаанд шийдвэрлэх нөлөө үзүүлж чадаагүй байна. Малжуулах арга хэмжээнд хамрагдсан өрхүүд амьжиргааны наад захын хэрэглээний зүйлээр гачигдсан хэвээр байгааг нотолсон судалгааны дүн үүнийг харуулж байна.

Хүснэгт 6.5

Малчин өрхийн үндсэн хэрэглээнүүдийн хангамжийн байдал
(Хэрэглээ хангагдсан гэж үзэж байгаа өрхийн хувийн жингээр)

	Өрхийн малын өсөлтийн ялгаа		
	Малаа өсгөсөн	Хэвийн байгаа	Авсан малаа хорогдуулсан, Малгүй болсон
1. Хангалттай хоол унданд	21.9	44.9	30.2
2. Хангалттай хувцаслахад	19.1	10.2	15.5
3.Хүүхдээ дунд сургуульд сургахад	12.4	13.2	10.1
4. Хүүхдээ дээд сургуульд сургахад	3.7	5.1	4.6
5.Гэр орноо сайжруулахад	6.2	5.1	11.2
6. Машин унаатай болоход	5.1	4.1	8.5
7. Малын хадлан тэжээл бэлдэхэд	4.6	1.0	8.3
8. Малын хашаа байр бэлтгэхэд	14.6	8.2	5.8
9. Малын үүлдэр угсааг сайжруулахад	12.4	8.2	5.8

6.9. Судалгааны дүнгээс үзвэл, малжуулалтад хамрагдсан ихэнх өрхүүд хоол хүнс, хувцас хунараар дутагдаж, хүүхдээ сургуульд сургахад бэрхшээл учирч, гэр орноо өөд татаж сайжруулах, машин унаатай болох талаар мөрөөдөхийн хэрэггүй байдаг ажээ. Малынхаа чанарыг сайжруулах, малдаа хашаа байр барих, хадлан тэжээл бэлтгэхэд хөрөнгийн бололцоо хүрдэггүй нь эргээд мал аж ахуйн үйлдвэрлэлд нь сөрөг нөлөө үзүүлж улмаар малчин өрхийн бүтээмжийг бууруулах нэг хүчин зүйл болдог байна.

ДОЛООДУГААР БҮЛЭГ: МАЛЧИН ӨРХИЙН АМЬЖИРГААГ САЙЖРУУЛАХ АРГА ЗАМ

7.1. Энэ бүлэгт малчин өрхийн амьжиргааг сайжруулах арга замуудыг онцлон авч үзэх шалтгаануудыг тодорхойлон, малчин өрхийн амьжиргааны түвшиний ялгааг нэн ядуу, ядуу, боломжийн, чинээлэг гэж ангилан тэдний малын тоо, ам бүл, хөрөнгө чинээ, мал аж ахуй эрхлэх нөхцөл, ирээдүйн талаархи санал бодолыг тусгасан. Мөн малчин өрхийн амьжиргааг сайжруулах талаар авах арга хэмжээний тогтолцоо, малжуулалт явуулахад баримтлах загварыг боловсруулсан.

Малчин өрхийн амьжиргааг сайжруулах зорилтын онцлог

7.2. Малчин өрхийн амьжиргааны талаар урьд өмнө бусад байгууллагаас явуулсан судалгааны материал, төслийг хэрэгжүүлэх хугацаанд бидний хийсэн шинжилгээний дүн нь малчин өрхийн амьжиргааг сайжруулах арга замыг тодорхой авч үзэх боломж олгож байгаа юм. Монгол улсын нийт хүн амын амьжиргааны түвшний байдал, түүнийг сайжруулах арга замын судалгааг олон улсын байгууллагуудын оролцоотойгоор Монгол улсын Үндэсний статистикийн газраас 1995, 1998, 2000 онуудад явуулж үндэсний хэмжээнд авч хэрэгжүүлбэл зохих цогцолбор арга хэмжээг зөвлөмжийн хэлбэртэйгээр боловсруулсан байна. Энэхүү зөвлөмжийг монгол улсын малчин өрхийн амьжиргааг сайжруулах арга замыг тодорхойлоход тулгуур баримт бичиг болгон авч үзлээ. Хүн амын амьжиргааны түвшний түүвэр судалгаанууд нь хэдийгээр уг асуудлыг нэлээд ул суурьтай, дахин дахин авч үзсэн боловч хүн амын амьжиргаанд нөлөөлдөг хүн амын янз бүрийн бүлэг, орон нутгийн болон үйлдвэрлэлийн онцлог, ялгааг судлаагүй юм.

Шигтгээ 7

Малчин өрхийн амьжиргааны эх үүсвэр (ач холбогдлын зэргээр)

	Амьжиргааны түвшний ялгаа			
	Нэн ядуу	*Ядуу*	*Боломжийн*	*Чинээлэг*
Мал аж ахуй		+	+++	++++
Тэтгэвэр, тэтгэмж	++++	+++	++	+
Ажлын хөлс, цалин	+++	+++	++	
Мал аж ахуйгаас бусад үйлдвэрлэл, үйлчилгээ	++	++++	+	+
Тусламж	++++	+++	++	
Байгалийн баялаг ашиглах	++	+++	+	
Ан агнуур	++	+++		
Жижиг наймаа		+	++	
Төвлөрсөн ба орон нутгийн зах зээлийн үнийн зөрүү			+	++

Иймд бид малжуулах арга хэмжээ, түүний үр дүнгийн талаар хийсэн судалгаандаа тулгуурлан малчин өрхийн амьжиргааг сайжруулах арга замыг тусгайлан авч үзэж байна.

7.3. Малчин өрхийн амьжиргааны түвшинг сайжруулах арга замын асуудлыг онцлон авч үзэхэд хүргэж байгаа дараах үндсэн шалтгаанууд байна. Үүнд:

1. Малчин өрхийн амьжиргааны үндсэн эх үүсвэр болох мал аж ахуйн үйлдвэрлэл нь байгаль, цаг агаарын нөлөөллөөс шууд хамаарч байдаг. Сүүлийн жилүүдэд монгол орныг нийтэд нь хамарсан цаг агаарын бэрхшээл улам хүндэрч, давтамж нь ойртож байгаа явдал; дэлхийн цаг уурын ерөнхий өөрчлөлт, хүний байгальтай харьцах харьцаанаас үүдэлтэй мал аж ахуйд шаардлагатай байгалийн нөөцийн хомсдол зэрэг нь бэлчээрийн мал аж ахуйн хөгжилд сөргөөр нөлөөлж, малчдын амьжиргааны ирээдүйг тодорхой бус болгож байна. Үүний зэрэгцээ мал аж ахуйг эрсдэлээс хамгаалахад чиглэсэн хөрөнгө оруулалт, төр засгийн зүгээс тавих анхаарал халамж суларчээ. Мал аж ахуйн үйлдвэрлэлийн бүхий л түвшинд байгалийн эрсдэлийн менежментийн тогтолцоог бүрдүүлэх зайлшгүй шаардлага тулгараад байгаа боловч энэ талаар дорвитой ажил хийгдээгүй байна.
2. Хөдөөд эдийн засгийн болон нийгмийн баталгаагүй байдал хот суурин газраас илүү ноцтой болж, аюулгүй орчинд аж төрөх баталгаа алдагдаж эхэлж байна. Малчин өрхийн эдийн засгийн баталгаагүй байдал нь үйлдвэрлэлийн ба амьдралын шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрээр дутагдах, зах зээлээр гачигдах, цөөн малтайн улмаас нууц ажилгүйдэлд нэрвэгдэх явдлаар илэрч байна. Малчин өрхүүдийн хоорондын харилцаа холбоо, түүгээр ч барахгүй садан төрлийн бие биедээ туслах сайн санааны тусламж алхам алхмаар мөнгөний хэлбэрт шилжих, малчдад ногдох нийгмийн халамж, үйлчилгээний хэмжээ багасах, нэр төрөл нь цөөрөх, орон нутгийн захиргааны зүгээс хандах халамж анхаарал сулрах явдлаар малчин өрхийн өнөөгийн нийгмийн баталгаагүй байдал илэрхийлэгдэж байна. Архидан согтуурах, хулгай дээрэм /ялангуяа малын хулгай/, гэр бүлийн хүчирхийлэл зэрэг нийгмийн сөрөг үзэгдлүүд хөдөө орон нутаг руу ихээхэн хурдтайгаар хаяагаа тэлж байна. Энэ нь малчин өрхийн аюулгүй орчинд аж төрөн амьдрах баталгааг алдагдуулах илрэл болж, жил ирэх тутам гүнзгийрч байна.
3. Үйлдвэрлэл эрхлэх онцлогоосоо шалтгаалан малчдын алслагдмал, нэг нь нөгөөгөөсөө салангид байршил нь тэдний өөр хоорондоо нэгдэж хамтран ажиллах, нийгэм, соёл, боловсрол, ахуйн нийтлэг үйлчилгээнд хамруулах, мал аж ахуйн үйлдвэрлэлийг илүү боловсронгуй болгох арга хэмжээ хэрэгжүүлэхэд бэрхшээл учруулдаг.
4. Хөдөө орон нутагт эдийн засгийн боломж бага, зах зээл хязгаарлагдмал байгаагаас мал аж ахуйгаас өөр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх замаар амьжиргаагаа сайжруулах арга зам байхгүй байна. Үүний улмаас уулаасаа ядуу, малгүй буюу цөөн малтай болсон малчид, түүнчлэн ядуу малчин өрхөөс амьдралаа шинээр эхэлж байгаа залуучууд амьдрах орчин эрж хөдөөгөөс хот суурин газар луу шилжих явдал түгээмэл үзэгдэл болжээ.
5. Монгол орны аль ч орон нутагт малчин өрхийн амьжиргааны түвшний ялгаа ихэссэн. Үүний улмаас баян, ядуу малчдын талаар баримтлах ялгавартай бодлого шаардлагатай болсон байна.

Хүснэгт 7.1

Малчин өрхийн амьжиргааны түвшний ялгаа

	Амьжиргааны түвшний ялгаа			
	Нэн ядуу	Ядуу	Боломжийн	Чинээлэг
Малын тоо, байдал	1. Малгүй эсвэл тун цөөн малтай 2. Малын нас хүйсний ба төрлийн бтэц алдагдсан	3. Ам бүлийн нэг хүнд 20-30 мал ногдох 4. Малын чанар дунд зэрэг 5. Малын нас хүйсний бүтэц алдагдсан	6. Ам бүлийн нэг хүнд 30-40 мал ногдох 7. Малын чанар дунд зэрэг 8. Малын нас хүйсний бүтэц зөв	9. Ам бүлийн нэг хүнд 50 дээш мал ногдох 10. Малын чанар сайн 11. Малын нас хүйсний зохистой
Ам бүлийн байдал	1. Ам бүл олон 2. Хөдөлмөрийн чадвар сул 3. Цалин хөлстэй ажил хийдэг хүнгүй	4. Ам бүл олон 5. Хөдөлмөрийн чадвартай хүн цөөн 6. Цалин хөлстэй ажил хийдэг хүн цөөн	7. Ам бүлийн тоо хэвийн дундаж 8. Хөдөлмөрийн чадвартай хүмүүстэй	9. Ам бүлийн тоо хэвийн дундаж 10. Гэр бүлийн хүмүүсийн хөдөлмөрийн чадвар сайн
Хөрөнгө чинээ	1. Гэр нь жижиг 2. Эд хогшил нь хуучин чанаргүй 3. Үнэтэй эд хогшил байхгүй 4. Унаа унашгүй	5. Гэр нь дундаж хэмжээний 6. Эд хогшил нь хуучивтар 7. Үнэтэй эд хогшил байхгүй 8. Унааны морь тэмээтэй	9. Гэрнь дундаж хэмжээний 10. Эд хогшил нь хэвийн 11. Үнэтэй эд ховор 12. Унааны морь, тэмээ, мотоцикльтой	13. Гэр нь чамбай 14. Эд хогшил нь чанартай 15. Үнэтэй эд хогшлуудтай 16. Унааны мал хангалттай, мотоцикль, машин, цахилгааны эх үүсвэртэй
Мал аж ахуй эрхлэх нөхцөл	1. Өөрийн өвөлжөө, хаваржаагүй 2. Ихэвчлэн сумын төвд амьдардаг	3. Алдаг оног өвөлжөөтэй 4. Ихэвчлэн айл бараадан амьдардаг 5. Эзэмшлийн худаггүй	6. Ихэнх нь өөрийн өвөлжөөтэй 7. Эзэмшлийн худагтай байх нь алдаг оног	8. Бүгд өвөлжөө хаваржаатай, зарим нь 2 өвөлжөөтэй 9. Эзэмшлийн худагтай
Ирээдүйн талаарх бодол санал	• Төр засгаас үзүүлэх тусламжийг нэмэгдүүлэх	• Ажил олдвол хийх • Боломж олдвол хүүхдээ сургах	• Малынхаа тоог өсгөх • Нэмэлт орлого олох эх үүсвэр хайх	• Малынхаа чанарыг сайжруулах • Зарим хүүхдээ дээд сургуульд сургах

6. Малчдын суурь болон мэргэжлийн боловсролын түвшин хүн амын бусад бүлэгтэй харьцуулбал харьцангуй доогуур, боловсролоо ахиулах бололцоогүй байдал нь амьдрал, үйл ажиллагаагаа зах зээлийн харилцаанд шилжүүлэх, мал аж ахуйгаа байгаль, эдийн засгийн байнга хувиран өөрчлөгдөж байгаа шинэ нөхцөлд зохицуулан эрхлэх санаачлага гаргах, шинэ үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэх замаар амьжиргаагаа сайжруулахад нь саад бэрхшээл учруулж байна.
7. Малчид сэтгэл зүйн хувьд ихэнхдээ айлын мал хариулах, баян айлд зарцлагдах явдлыг хүлээн авах чадваргүй байдаг. Тэд хэдий ядарсан ч гэсэн нутгийнхаа хүний зарц болохгүй гэсэн хатуу байр суурь баримталж, өөр газар хатуу хүтүү ч хамаагүй ажил хийж, хүнд муугаа үзүүлэхгүй амьдрахыг эрхэмлэдэг.

Малчин өрхийн амьжиргааг сайжруулах арга замын асуудлыг авч үзэхдээ дээр дурьдсан онцлогуудыг зайлшгүй харгалзан үзэх шаардлагатай юм.

Малчин өрхийн амьжиргааг сайжруулах талаар авах арга хэмжээний тогтолцоо

7.4. Малчин өрхийн амьжиргааг сайжруулах чиглэлээр малжуулах, бэлчээрийн менежмент, худаг, усны хангамжийг сайжруулах, сургалт явуулж мэргэжил, боловсролыг дээшлүүлэх, газар тариалан, туслах үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлүүлэх зэрэг олон арга хэмжээ хэрэгжүүлсэн билээ. Гэвч иж бүрнээр шийдвэл зохих асуудлын нэгийг нөгөөгөөс нь салгасны улмаас аль ч арга хэмжээ нь дорвитой үр дүн өгөөгүй юм. Иймд иж бүрдэл арга хэмжээний тогтолцоог бид санал болгож байна.

7.5. Малчин өрхийн амьжиргааг сайжруулахын тулд дараах үндсэн арга хэмжээг иж бүрнээр авах хэрэгтэй гэж үзэж байна. Үүнд:

1. Малчин өрх бүрд мал аж ахуй эрхлэн амьдрах нөхцөл боломж бүрдүүлж өгөх
   - Мал аж ахуй эрхлэх чадвартай, орон нутагтаа тогтвортой амьдрах малчин өрхийг сонгон шалгаруулж малжуулах
   - Малчин өрх бүрд мал аж ахуй эрхлэх нутаг бэлчээр, худаг усны адил боломж бүрдүүлэх
2. Мал аж ахуйг байгаль цаг агаарын эрсдэлээс хамгаалах, эрсдэлийг даван туулах тогтолцоо бүрдүүлэх
   - Малчдын бүлэг, хоршоо зэрэг хамтын ажиллагааны хэлбэрүүдийг дэмжих
   - Бэлчээр, тэжээл, усны хангамжийг сайжруулах, менежментийг боловсронгуй болгох
   - Мал эмнэлгийн үйлчилгээг сайжруулах
   - Гамшгийн менежментийн тогтолцоо бүрдүүлэх
3. Мал аж ахуйн бүтээмжийг дээшлүүлэх
   - Зах зээлийн боломжтой нөхцөлд эрчимжсэн, хагас эрчимжсэн мал аж ахуйн салбаруудыг хөгжүүлэх
   - Бэлчээрийн монгол малын чанарыг сайжруулах
   - Мал аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг дээшлүүлэх
4. Мал аж ахуйн зэрэгцээгээр нэмэлт орлого олох эх үүсвэр бий болгох
   - Малчдын боловсрол, соёл, ахуйн үйлчилгээг сайжруулах чиглэлтэй үйлчилгээ
   - Мал аж ахуйн бүтээгдэхүүний маркетингийг боловсронгуй болгох

(Боловсруулалт, борлуулалтын түвшинд) үйл ажиллагаа
- Нэмэлт орлого олох салбаруудыг хөгжүүлэх

5. Малчдын боловсролыг дээшлүүлэх
   - Малчдын өсвөр үеийн ерөнхий боловсролын түвшинг ахиулах
   - Мал аж ахуйн үйлдвэрлэлийн технологийн мэдлэг, туршлагыг нэмэгдүүлэх
   - Бусад үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх мэдлэг, чадвар олгох

Малжуулалт явуулахад баримтлах загвар

7.6. Малжуулах арга хэмжээг хэрэгжүүлсэн сургамжаас дүгнэлт хийж, төслийг хэрэгжүүлэхдээ бүх талаас нь иж бүрэн хандах, төсөл нь харьцангуй удаан хугацааны хяналттай байх, үлгэр жишээ үзүүлэх замаар нийтэд хүртээмжтэй болгох зарчмыг зөвлөмж болгож байна. Малжуулалт явуулах загвар нь дараах байдалтай байж болох юм.

7.7. Эхлээд тодорхой бүлэг малчин өрхийн хамтлагийг хоршоо, компани, ТББ-ын аль нэг хэлбэрээр зохион байгуулж, түүнд оролцогч малчдын дундын өмчийн хэлбэрээр хөрөнгө оруулалт хийнэ. Малчдын бүлэг, хоршооны гишүүд нь өөрийн чадавхийн хэмжээгээр хөрөнгө оруулж, дүрмийн сан бүрдүүлэхэд оролцсон байвал зохино.

7.8. Малчдын бүлэг, хоршооны гишүүдийн оруулсан хөрөнгө, төслийг санхүүжүүлэгч байгууллагын хөрөнгөөс бүрдсэн үйлдвэрлэлийн нөхцөл бүхий аж ахуйд малчид гэрээ, түрээсээр ажиллаж, цалин хөлс авч өдөр тутмын амьжиргааны хэрэгцээгээ хангана. Гэрээ түрээс нь хөнгөн болзолтой байх ба төслийг санхүүжүүлэгч байгууллагын хөрөнгө малчдын бүлгийн гишүүдэд тэдний оруулсан хувь оролцооны хэмжээгээр аажмаар шилжин очиж байхаар зохион байгуулах нь зохимжтой юм. Ингэхдээ малчинд шууд төлөгдөх мөнгө, хөрөнгө хэлбэрээр биш, харин малчдын бүлэг, хоршоонд тэдний оруулсан хөрөнгийн эзлэх хувь хэмжээ нэмэгдэх байдлаар шилжүүлэх нь илүү зохимжтой болно. Гэхдээ малчин өрх бүр малчдын бүлэг, хоршооноос өөрийн эзэмшил хөрөнгөө дуртай цагтаа авч гарах, шинэ гишүүн элсэн орох боломжтой байх шаардлагатай. Төслийг санхүүжүүлэгч байгууллагын оруулах хөрөнгийн зарим хэсгийг, ялангуяа маркетингийн үйл ажиллагаанд оруулах хөрөнгийг урт, богино хугацааны, бага хүүтэй зээлийн хэлбэрээр оруулж болох юм.

7.9. Хөрөнгө оруулалт нь малжуулалтаас гадна мал аж ахуй эрхлэх нөхцлийг сайжруулахад зориулагдаж байх нь зүйтэй. Малжуулалтыг одоогийн бэлчээрийн малын тоог олшруулах чиглэлээр биш, харин байгалийн өөрчлөгдөж байгаа нөхцлийг тооцож үзсний үндсэн дээр бэлчээрийн мал аж ахуйн менежментийг илүү боловсронгуй болгох, эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийн үндэс суурийг бүрдүүлэхэд чиглүүлэх нь чухал гэж үзэж байна.

7.10. Зөвхөн малжуулалт дангаараа малчдын амьжиргааг сайжруулах үндэс болж чадахгүйг малжуулах арга хэмжээний туршлага харуулж байна. Ийм учраас малжуулах арга хэмжээг мал аж ахуй эрхлэх нөхцлийг сайжруулах, мал аж ахуйг удирдах, бүтээгдэхүүний борлуулалтыг боловсронгуй болгох үйл ажиллагаатай зайлшгүй хослуулах хэрэгтэй. Аймаг, сумдын байгаль, үйлдвэрлэлийн онцлогоос хамааран хөрөнгө оруулалтын чиглэл нь өөр өөр байна. Малын үүлдэр угсаа

сайжруулах ажлыг шууд малжуулах арга хэмжээтэй хамт эхлэх нь чухал. Үүний тулд анхнаас нь сайн үүлдрийн шилмэл мал худалдан авч төслийг эхлүүлэх шаардлагатай.

7.11. Малжуулах арга хэмжээг үр өгөөжтэй болгохын тулд бэлчээрийн усан хангамжийг сайжруулах, хадлан тэжээл бэлтгэх, малын хашаа байраар хангах, мал эмнэлгийн үйлчилгээг боловсронгуй болгох нэмэлт арга хэмжээнүүдийг малжуулалттай зэрэгцүүлэн зохион байгуулах хэрэгтэй. Эдгээр арга хэмжээ нь малжуулалтаас багагүй хөрөнгө шаардах бөгөөд эцсийн үр дүн нь малжуулалтаас харьцангуйгаар илүү, үлдэц сайтай байх болно.

7.12. Малчин өрхийн амьжиргааг сайжруулахад мал аж ахуйн үйлдвэрлэлийг дэмжихээс гадна мал аж ахуйн зэрэгцээгээр орлого олох бусад бүтцийг хөгжүүлэхэд дэмжлэг туслалцаа шаардлагатай. Малчин өрх, малчдын бүлгийн хэмжээнд нэмэлт үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх шаардлага дараах шалтгаануудаар тодорхойлогдож байна. Үүнд:

- Малчин өрхийн орлогыг нэмэгдүүлэх
- Өрхийн гишүүдийн ажил эрхлэлтийг нэмэгдүүлэх
- Улирлын шинж чанартай үүсч гардаг түр хугацааны ажилгүйдлийг багасгах
- Малчид, ялангуяа залуучуудад мал аж ахуйн бүтээгдэхүүнийг дахин боловсруулах болон өөр үйлдвэрлэл эрхлэх мэргэжил дадлага эзэмшүүлэх. Ингэснээр малчдад зөвхөн мал аж ахуйн эрхшээлд байдаг бэрхшээлийг хөнгөвчилж өгнө.
- Малчдын үйлчилгээний хүрээг өргөтгөх

ЗӨВЛӨМЖ БА ДҮГНЭЛТ

Малжуулалтыг боловсронгуй болгож, малчин өрхийн орлогыг нэмэгдүүлж, амьжиргааг сайжруулах талаар өгөх зөвлөмж

Нэг. Малжуулалтаар олгох малын тоо ,түүний бүтэц

8.1. Малжуулалтыг үр дүнтэй болгох талаар малчдаас авсан анкетийн судалгаагаар нэг өрхөд олон мал олгосон бол илүү үр дүнтэй байх байсан гэж судалгаанд оролцогсдын нилээд хэсэг нь хариулсан билээ. Энэ нь өрхийн малын орлого нь зарлагаасаа илүү гарч чадахгүй байгаагаас малын тоо өсч, амьжиргаанд нь мэдэгдэхүйц өөрчлөлт гарахгүй байгаатай холбоотой юм. Иймд малчин өрхийг малжуулах үед малчдад өрхийн хэрэгцээг хангах төдийгүй, мал нь өсч байх боломж олгохуйц олон мал олгох нь чухал. **Тухайлбал, нэг өрхөд ногдох малын тоог 200 толгойгоос багагүй байхаар бодож малжуулах хэрэгтэй гэж зөвлөж байна.**

8.2. Малжуулалтаар өгөх малын төрөл нь тухайн өрхийн хэрэглээг хангахуйц оновчтой бүтэцтэй байна. Өрхөд байх малын төрөл олон байх тусам өрхийн аж ахуйд тохиолдож болох эрсдлийг бууруулах боломж сайжирна. Малын бүтэц нь орон нутгийн онцлогийг тусгасан дундаж бүтэц байх шаардлагатай. Тухайлбал, өндөр уул, ойт хээрийн бүсэд 200 малтай өрх адуу 10, үхэр 20, хонь 100, ямаа 70 толгой байвал орлогоороо /1140.0 мянган төгрөг/ зардлаа /970.0 мянган төгрөг / нөхөөд ашигтай ажиллах боломжтой нь тооцооноос харагдаж байна.

8.3. Малчин өрхийг малжуулах үед малыг аль болохоор дулааны улирал эхлэх 6,7 сард өгч, богийг 3 дахь , бод малыг 6 дахь жилээс нь эхлэн эргүүлэн төлүүлэх болзолтойгоор олгох нь оновчтой болно.

Хоёр. Малжуулах үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар

8.4. Цаашид малжуулах стратегийг хэрэгжүүлэхдээ мал аж ахуй эрхлэх орчныг цогц байдлаар бүрдүүлэх, төсөл нь удаан хугацааны, байнгын хяналттай байх, малжуулалтыг нийтэд хүртээмжтэй болгох зарчмыг зөвлөмж болгож байна. Малжуулах арга хэмжээ нь 2 хэлбэртэй байж болно.

1. Малчны бүлэг, хамтлагийг малжуулах

8.5. Малчдын бүлэг, хамтлагийг малжуулах нь дээр дурьдсан зарчмуудыг хэрэгжүүлэхэд илүү чухал ач холбогдолтой юм. Ингэхдээ эхлээд тодорхой малчин өрхийн бүлэг, хамтлагийг хоршоо, компани, төрийн бус байгууллагын аль нэг хэлбэрээр зохион байгуулж, түүнд оролцогч малчдын дундын эзэмшилд мал олгоно. Малчдын бүлэг, хоршооны гишүүд нь өөрийн чадавхийн хэмжээгээр хөрөнгө оруулж, дүрмийн сан бүрдүүлэхэд оролцох шаардлагатай. Малжуулах арга хэмжээнд оруулах хөрөнгийг орон нутгийн захиргаагаар дамжуулан малчдын бүлэгт эзэмшүүлэх бөгөөд сумын ИТХ хяналт тавьж байна.

8.6. Малчдын бүлэг, хоршооны гишүүдийн оруулсан хөрөнгө, төслийг санхүүжүүлэгч байгууллагын хөрөнгөөс бүрдсэн үйлдвэрлэлийн нөхцөл бүхий малчдын бүлэгт малчид гэрээ, түрээсээр болон хөлсөөр ажиллаж, цалин хөлс авч

өдөр тутмын амьжиргааны хэрэгцээгээ хангана. Малчдын бүлэг нь технологийн удирдлагыг хангах, өөрөө бүртгэл тооцоо хөтөлж, тайлан тооцоо гаргаж, хяналт шалгалт хийх чадвартай удирдлагын бүтэц бүхий нэгж байх хэрэгтэй. Гэрээ, түрээс нь хөнгөн болзолтой байх ба бүлэг, хамтлагийн хөрөнгөнд гишүүдийн эзлэх хувь хэмжээ нь тэдний оруулсан хувь оролцооны хэмжээгээр өөрчлөгдөж байхаар зохион байгуулах нь зохимжтой юм. Гэхдээ малчин өрх бүр малчдын бүлэг хоршооноос өөрийн эзэмшил хөрөнгөө дуртай цагтаа авч гарах, шинэ гишүүн элсэн орох боломжтой байх шаардлагатай.

8.7. Малжуулалтыг санхүүжүүлэгч байгууллагын оруулах хөрөнгийн зарим хэсгийг малжуулалтаас гадна мал аж ахуй эрхлэх нөхцлийг сайжруулахад зориулж байх нь зүйтэй. Малчдын бүлэг, хамтлагийг малжуулах үед доорх асуудлуудыг анхаарах хэрэгтэй.

- Малжуулалтыг одоогийн бэлчээрийн малын тоог олшруулах чиглэлээр биш, харин байгалийн өөрчлөгдөж байгаа нөхцлийг харгалзан бэлчээрийн мал аж ахуйн менежментийг илүү боловсронгуй болгох, эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийн үндэс суурийг бүрдүүлэхэд чиглүүлэх нь чухал гэж үзэж байна. Малын үүлдэр угсаа сайжруулах ажлыг шууд малжуулах арга хэмжээтэй хамт эхлэх нь чухал. Үүний тулд анхнаас нь сайн үүлдрийн шилмэл мал худалдан авч төслийг эхлүүлэх шаардлагатай.
- Малжуулалтыг мал аж ахуйн хөгжлийн дэд бүтэц бүрдүүлэхтэй цогц байдлаар хэрэгжүүлбэл зохино. Энэхүү цогц арга хэмжээний бүрэлдэхүүнд бэлчээрийн усан хангамжийг сайжруулах, хадлан тэжээл бэлтгэх, малын хашаа байраар хангах, мал эмнэлгийн үйлчилгээг боловсронгуй болгох болон хөдөөгийн дэд бүтцийн хөгжлийг сайжруулах зэрэг нэмэлт арга хэмжээнүүдийг оруулж болно. Эдгээр арга хэмжээ нь малжуулалтаас багагүй хөрөнгө шаардах бөгөөд эцсийн үр дүн нь малжуулалтаас илүү, үлдэц сайтай байх болно.

2. Өрхийг малжуулах

8.8. Мал маллах сонирхолтой, үйлдвэрлэл явуулах хүн хүч, нөхцөл боломжтой (өөрийн өвөлжөө, хаваржаатай, унаатай), зээлийг эргүүлэн төлөх баталгаатай өрхийг ганцаарчлан малжуулах арга хэмжээнд хамруулах явдлыг үгүйсгэхгүй байна.

- Ганцаарчлан малжуулах өрхийг сонгох асуудлыг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар шийдвэрлүүлнэ.
- Авах малаа малчид өөрсдөө шилж сонгон худалдан авах боломжоор хангах

Гурав. Малчин өрхийн амьжиргааг сайжруулах талаар

8.9. Малчин өрхийн амьжиргааг сайжруулах асуудлыг дараах арга замуудаар шийдвэрлэх боломжтой гэж зөвпөж байна. Үүнд:

- Малжуулалтыг үргэлжлүүлэн явуулах,
- Өрхийн гишүүдийн ажил эрхлэлтийг дээшлүүлэх,
- Мал аж ахуйн бүтээмжийг дээшлүүлэх,
- Мал аж ахуйг эрсдлээс хамгаалах,
- Малчдын соёл, ахуйн хоцрогдлыг арилгах,

- Малчдад банк, санхүүгийн байгууллагаар үйлчлэх үйлчилгээг сайжруулах.

1. Малчин өрхийн амьжиргааг сайжруулах чухал арга болох малжуулалтыг өмнөх зөвлөмжийн дагуу явуулна
2. Өрхийн гишүүдийн ажил эрхлэлтийг дараах арга замуудаар дээшлүүлнэ.
   - Туслах үйлдвэрлэл, бусад ажил эрхлэх
   - Хашаа барих, худаг гаргах, хадлан, тэжээл бэлтгэх отор нүүдэл хийх, мал эмнэлгийн үйлчилгээ үзүүлэх зэрэг үндсэн үйлдвэрлэлийг дэмжих дэд бүтцийг бий болгох
3. Мал аж ахуйн бүтээмжийг дээшлүүлэх гол арга нь малын ашиг шимийг нэмэгдүүлэх явдал байдаг. Малын ашиг шимийг дараах арга замуудаар дээшлүүлнэ.
   - Нутгийн шилмэл малын хээлтүүлэгчээр малаа тодорхой бодлого төлөвлөгөөтэй сайжруулах
   - Үржлийн ажлыг мэргэжлийн өндөр түвшинд явуулж, мал аж ахуйн үйлдвэрлэлийн технологийг боловсронгуй болгон, түүнийг нарийн мөрдүүлэх. Үүний тулд малчдын бүлэгт мал аж ахуйн технологийн мэргэжилтэн ажиллуулах
   - Орон нутгийн онцлогт тохирсон эрчимжсэн технологи нэвтрүүлэх
4. Мал аж ахуйг эрсдлээс хамгаалах, түүнийг бууруулах арга замууд:
   - Бэлчээрийг урт хугацааны гэрээгээр эзэмшүүлэх
   - Бэлчээрийн усан хангамжийг сайжруулах замаар ашиглалт багатай бэлчээрийг эргэлтэнд оруулах
   - Бэлчээрийг хуваарьтай ашиглаж , нөхөн сэргэх боломж олгох
   - Эрчимжсэн мал аж ахуйд бэлчээрийг хашаалж, хуваарьтай ашиглах
   - Хадлан бэлтгэх, тэжээл тариалах зориулалт бүхий талбайтай болох
   - Аюулаас хамгаалах тэжээлийн сантай болох
   - Бэлчээрийн малыг бордох, сүүний чиглэлээр ашиглах зэргээр эрчимжсэн технологид шилжүүлэх
   - Малыг эмчлэх, урьчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулах
   - Хэрэглэгч байгууллагуудтай бүтээгдэхүүн нийлүүлэх талаар гэрээ байгуулж нийлүүлэх бүтээгдэхүүний хэмжээ, үнэ, чанарын талаар нарийн тохиролцох
   - Хөдөө аж ахуйн бүдээгдэхүүнийг ангилж зэрэглэх, анхан шатны боловсруулалт хийх ажиллагаанд суралцах
   - Бүтээгдэхүүн хадгалах, боловсруулалт хийх байр агуулахтай болох
5. Малчдын соёл, ахуйн хоцрогдлыг арилгах чиглэлээр.
   - Сургууль завсардсан залуучуудын ерөнхий боловсролын түвшинг гэрээр дээшлүүлэх,
   - Малчдад мал аж ахуйгаас бусад салбарын үйл ажиллагаа эрхлэх чиглэлээр сургалт явуулах,
   - Малчдыг жилд нэгээс доошгүй удаа эрүүл мэндийн үзлэгт оруулах,
   - Хүнс тэжээлийн баланс алдагдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор төмс, хүнсний ногоо тариалж, хэрэглүүлж сургах,
   - Малчдын бүлгүүдийг халуун ус, үсчин, гоо сайхан, дархан мужаан, оёдлын газар, номын сантай болгож малчдад үйлчлүүлэх,

- Малчны хот айл,малчны бүлгийг нар, салхины эрчим хүчний эх үүсвэрээр хангаж радио, телевизор үзэх боломж олгох,
- Багийн холбоог малчдад хүртээмжтэй болгох,

6. Малчдад банк санхүүгийн байгууллагаар үйлчлүүлэх үйлчилгээг сайжруулахын тулд дараах ажлуудыг нэг мөр болгох хэрэгтэй. Үүнд :
   - Малчин өрхийг аж ахуйн нэгжийн статустай, хуулийн хүчин төгөлдөр нэгж болгох
   - Мал аж ахуйг хөгжүүлэхэд зориулсан урт хугацааны, бага хүүтэй зээлийн бүтээгдэхүүн бий болгох

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

1. Монгол улс зах зээлийн харилцаанд шилжиж, өмч хувьчлал явуулсны үр дүнд 2000 оны байдлаар манай улсын нийт малын 96.7% нь хувийн хэвшилд хамрагдаж, нэг малчин өрхөд дунджаар 135 толгой мал ногдож байв. 1999-2001 оны өвөл, хаврын зуданд малчин өрхийн амьжиргааны гол хэрэгсэл болсон 7.6 сая мал хорогдсон юм. Ийнхүү жил дараалан болсон ган, зудын уршгаар малчин өрхийн нэлээд хэсэг нь мал цөөнтэй эсвэл огт малгүй болж ядуу, эмзэг бүлэгт хамрагдах болов. Иймд гадаад, дотоодын олон байгууллагууд малчдын ядуурлыг бууруулах арга хэмжээний хүрээнд малжуулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнг нарийн судалж үнэлэх, цаашид тэдний амьжиргааг сайжруулах арга хэлбэрийг тодорхойлоход уг төслийн зорилго оршсон юм.

2. Судалгааны ажлыг судалгаанд ашиглах тоо мэдээ цуглуулах, судалгааны материалд боловсруулалт хийх, дүгнэлт санал гаргах гэсэн 3 үе шатаар явуулсан. Судалгаанд статистикийн олон шатат зорилтот ба санамсаргүй түүврийн аргыг ашиглан мэдээлэл цуглуулах, баримт бичиг судлах арга, анкетийн судалгаа, ярилцлага, оролцооны аргуудыг хэрэглэсэн. Судалгааны үндсэн нэгжээр малжуулалт болон малчин өрхийн амьжиргааны талаар дүгнэлт гаргаж чадах дараах үндсэн обьектуудыг сонгож авсан.Үүнд:

а. малжуулалтад хамрагдсан өрх,
б. малжуулалтад хамрагдаагүй өрх,
в. малжуулах арга хэмжэнд хамрагдсан аймаг, сум, багийн удирдлага,
г. малжуулах арга хэмжээг зохион байгуулсан байгууллага, хүмүүс.

3. Зудад нэрвэгдсэн 13 аймгаас Дундговь, Завхан, Баянхонгор, Хөвсгөл гэсэн 4 аймгийг сонгож авлаа. Судалгаанд хамруулах аймгийг сонгохдоо урьд хийгдсэн тайлан, судалгааны тоо мэдээнд тулгуурлан зорилтот түүврийн аргыг ашиглав. Ингэхдээ дараах шалгуур үзүүлэлтүүдийг ашигласан болно. Үүнд: хохирлын түвшингийн хэмжээ, малжуулах төсөлд хамрагдсан сум, өрх, малын тоо, байгалийн бүсийн ялгаа, ган зудын давтамж, төсөл хэрэгжүүлсэн байгууллагын ялгаа болно. Өөрөөр хэлбэл, аймгийн дотроос судалгаа явуулах дараагийн шатны обьект болох сумдыг , сонгож авсан сумдаас малжуулалтад хамрагдсан багийг, багаас өрхийг тодруулсан юм. Судалгаанд хамрагдах сумдыг сонгохдоо судалгаанд хамрагдаагүй бусад сумдыг төлөөлөх чадвартай, малжуулах арга хэмжээний онцлогийг илрүүлэх боломжтой, өрхүүдийг хамруулах шаардлагуудыг удирдлага болгосон. Судалгаанд хамрагдах малчин өрхийг сонгохдоо малжуулалтанд хамруулсан өрхүүдийн хувьд сумын удирдлага, мэргэжилтнүүдийн саналаар нэг өрхөд ноогдох санхүүжилт, малын тооны өсөлт, малжуулалттай холбогдсон онцлог шинж зэрэг үзүүлэлтүүдийг харгалзсан болно. Харин малжуулалтад хамрагдаагүй өрхүүдийн хувьд санамсаргүй түүврийн аргаар сонгосон юм.

4. Хэвлэлийн тоймоос үзэхэд ган, зудын бэрхшээл, байгалийн нөөцийн хомсдол, бэлчээрийн даацын бууралт, малчдын ерөнхий ядуурал зэрэг нь малжуулах гол шалтгаан болж байна.

5. Малжуулалтын үр дүнд ядуу малчин өрхийн малын тоо, бүтээмж, өрхийн орлого, хэрэглээ, хөрөнгө нэмэгдэж, цөөн малтай өрхийн тоог бууруулж, ядуурлыг арилгахад нөлөөлсөн тул Монголд явуулсан малжуулах арга хэмжээ нь малчдын

амьжиргааг сайжруулахад чиглэгдсэн чухал арга хэмжээ болжээ. Гэвч өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсэн малжуулах арга хэмжээнүүд нь зохион байгуулсан арга хэлбэр, хугацаа, малчин өрхийн сонголт зэрэг менежментийн алдаанаас болж, олон тохиолдолд хүлээсэн үр дүнд хүрээгүй байна. Малжуулах арга хэмжээг боловсронгуй болгохын тулд малжуулах өрхийг зөв сонгон шалгаруулах, өрхийн хэрэгцээг харгалзан өгөх малын тоог оновчтой тогтоох, сайн чанарын буюу өндөр ашиг шимийн малаар малжуулах зэрэг асуудлуудад илүү анхаарал тавих хэрэгтэй байжээ. Хөдөөгийн ядуу өрхийн амьжиргааг дэмжих асуудлыг зөвхөн малжуулалтаар шийдвэрлэх боломжгүй гэдэг нь ойлгомжтой. Иймд малчин өрхийн амьжиргааг дээшлүүлэхэд өрхийн туслах аж ахуй хөгжүүлэх, малчдын хөдөлмөр, хөрөнгийг хорших замаар хагас эрчимжсэн мал аж ахуй, өөр үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх боломж олгохуйц санхүү, эрх зүйн нөхцлийг бүрдүүлж өгөх нь чухал байна.

6. Малжуулах стратегийг хэрэгжүүлэхдээ бэлчээрийн мал аж ахуй, малчин өрхийн амьжиргааны болон орон нутгийн өвөрмөц онцлогуудыг зайлшгүй харгалзан иж бүрэн хандах, төслийн хэрэгжилт, үр дүнд нь байнга хяналт тавих замаар нийтэд хүртээмжтэй болгох зарчмыг мөрдөх нь зүйтэй.

7. Малжуулалтаар малчин өрхийн амьжиргааг сайжруулахад малжуулалттай зэрэгцүүлэн дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх хэрэгтэй. Үүнд:

- ядуу малчин өрхийг малжуулахдаа бэлчээр, худаг, усаар хангагдах боломж олгох,
- эрсдэлээс хамгаалах, даван туулах тогтолцоог бүрдүүлэх,
- малын чанарыг сайжруулж, өндөр ашиг шимтэй, шилмэл малаар малжуулах,
- малчдын боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх сургалт явуулах,
- өрхийн нэмэлт орлогын эх үүсвэртэй болгох.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

Нэг. Монгол хэлээр

- Амьжиргааны түвшиний түүвэр судалгаа, 1998
- Амьжиргааны түвшинг оролцооны аргаар үнэлэх судалгаа, 2000
- "Архангай аймгийн Хөдөөгийн ядуурлыг бууруулах төсөл-ийн 2000 оны ажлын тайлан
- Байгалийн гамшигт нэрвэгдэж малгүй болсон өрхүүдийг дахин малжуулах төсөл хэрэгжүүлэх журам
- Бэлчээрийн тогтвортой менежмент семинарын материал, 2001
- "Хөвсгөл аймгийн Хөдөөгийн ядуурлыг бууруулах төсөл-ийн 2000 оны ажлын тайлан
- Төсөл Мон/00/302 судалгааны ажлын тайлан 1999-2000 оны зудын сургамж
- Мал аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэнхүүний нөөц, хүрэлцээ төслийн эсцийн тайлан, 1999 он
- Мал сүргийн ган зудаас хамгаалахад туслах үндэсний хөтөлбөр, Засгийн газрын 2001 оны 47-р тогтоолын 1-р хавсралт
- Малчин өрхийн статус: эдийн засаг, санхүү, эрхийн зүйн үндэс" төслийн эцсийн тайлан, 2002 он
- Монгол улсын дотоод шилжих хөдөлгөөн, баримтат хуудасны цомог
- Монгол улсын дотоод шилжих хөдөлгөөнийн микро түвшиний судалгаа 2000
- Монголын бэлчээр нутгийн тогтвортой менежмент бүсийн семинарын материал, 2001-10-30
- Монголын хүний хөгжлийн илтгэл, 2000
- Монгол улсын Засгийн газар хандивлагчдын зохион байгуулсан "Хөдөөгийн хөгжил" сэдэвт бага хурал, 2002
- "2000-2001 оны мал өвөлжилт, дүгнэлт-сургамж" нэгдсэн семинарын материал, 2001 он
- 2000-2001 мал өвөлжилт: дүгнэлт- сургамж- зорилт УБ 2001 он
- Орлогын эх үүсвэргүй болсон малчдын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх арга зам семинар, 2002.03.26
- Өрхийн амьжиргааны чадавхийг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр, 2001
- Хөдөө аж ахуйг бүсчлэн хөгжүүлэх бодлогын угтвар нөхцөлийн судалгаа, төслийн эцсийн тайлан, 2000
- Хүн амын амьжиргааны түвшиний түүвэр судалгаа, 2000
- Ядуурлыг бууруулах үндэсний хөтөлбөр, төгсгөлийн тайлан, 1994-2000 он
- Ядуурлыг бууруулах стратегийн баримт бичигийг хэлэлцсэн семинарын материал, 2002

Хоёр. Англи хэлээр

- Arhangai and Huvsgul rural poverty alleviation project, IFAD Loan No.412-MN, Supervision Mission Report
- Daniel Miller* August 2001, Pastoral Risk Management Strategy and Action Plan, Mongolia: Sustainable Livelihoods Project
- Lessons learnt in disaster preparation and mitigation from the Mongolian zud, 1999-2000, EXECUTIVE SUMMARY
- Ralph A. Van Gelder, May 2000, Livestock Products Marketing Sector Analysis, Mon/98/132, UNOPS, Enterprise Restructuring Project
- Ralph A. Van Gelder and D.Shombodon, December 1999, Some Mechanisms Interfering in Market Chains or the Mongolian Livestock Industries, The International Symposium of "Nomads and the Use of Pastures Today"
- The national programme for poverty alleviation 1994-2000
- Sustainable Livestock Production, MON/99/201, UNDP Mongolia